

## ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Өрсөлдөөний тухай хуульд тандан судалгаа хийв.

Өрсөлдөөний тухай хуулиар зохицуулах харилцаа нь Хууль тогтоомжийн<sup>1</sup>хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах /цаашид “урьдчилан тандан судлах” гэх/ аргачлалын1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг тус Аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

### НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 22-т “Өрсөлдөөний тухай хуулийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж байгаа бэрхшээлийг шийдвэрлэх, уг хуулийн зах зээлийн эдийн засгийн харилцааг зохицуулах суурь хууль болгон өөрчлөн шинэчлэх”, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.13-т “Зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжиж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг сайжруулана”, “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” зэрэг бодлогын баримт бичгүүдэд бизнес эрхлэгчийн шударга өрсөлдөөнийг дэмжих, зах зээлийн өрсөлдөөний таатай орчинг бүрдүүлэн, өрсөлдөөний эрх зүйн орчинг сайжруулах талаар тусгагдсан.

Түүнчлэн өрсөлдөөний эрх зүйн зохицуулалтыг нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, нийгмийн харилцаанд үүсч болох шударга бус өрсөлдөөний зохицуулалтыг өөрчлөх, зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгддэг Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд Улсын Их Хурлаар батлагдсантай холбогдуулан одоогийн мөрдөгдөж байгаа Өрсөлдөөний тухай хуулийг шинэчлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохицуулах хуулийн төслүүдтэй нийцүүлэн хуулийн үзэл баримтлал, зохицуулалтыг өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Иймд аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, асуудлыг үүсгэж байгаа шалтгаан, нөхцлийг тодорхойлсон болно.

#### 1.1. Асуудлын хамрах хүрээг тодорхойлсон байдал:

Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/-ийн дэмжлэгтэйгээр “Монгол Улсын шударга өрсөлдөөний орчинг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2016 онд Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох хэрэгцээ, цаг үеийн шаардлага, олон улсын жишигт нийцүүлэн

<sup>1</sup>Монгол улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.

одоогийн мөрдөж буй хуулиа сайжруулах талаар судалгааны ажлуудыг зөвлөх багуудаар гүйцэтгүүлэн түүний үр дүнд Монгол Улсын болон бусад улс орнуудын өрсөлдөөний эрх зүйн баримт бичгүүдэд судалгаа шинжилгээг хийсэн.

Энэхүү төслийн хүрээнд хийгдсэн Монгол Улсын зах зээлийн шударга өрсөлдөөн, өрсөлдөөний хууль эрх зүйн талаарх бизнес эрхлэгчдийн ойлголт болон зах зээлийн өнөөгийн төлөв байдал, нэвтрэх саадын судалгаа, өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаанд тавих хяналт зохицуулалт, монополийн үйл ажиллагаанд тавих хяналт зохицуулалт, нэгдэх, нийлэх үйл ажиллагаанд тавих хяналт зохицуулалт, өрсөлдөөнийг хязгаарласан гэрээ хэлцэл, картелийн хяналт зохицуулалт, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зэрэг судалгааг хөндлөнгийн эрдэмтэн судлаачдыг оролцуулан хийсэн.

Мөн хуулийн төсөл боловсруулахтай холбогдуулан "Өрсөлдөөний хууль ба бодлогын хэрэгжилт", "Өрсөлдөөний хууль тогтоомжийн хэрэгжилт, өөрчлөлт хийх шаардлага", "Өрсөлдөөний тухай хуулийн өөрчлөлтийн ерөнхий чиглэл", "Өрсөлдөөний тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал авах, "Өрсөлдөөний тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төслийн зэрэг нийт 5 удаагийн хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулж, хэлэлцүүлгүүдээс гарсан санал, зөвлөмж зэргийг судлаж энэхүү судалгааг хийсэн болно.

#### Эрх зүйн зохицуулалтын талаар:

Монгол Улс 1990 онд нийгмийн болоод эдийн засгийн тогтолцооны хувьд шилжилт хийн зах зээлийн эдийн засаг бүхий ардчилсан нийгмийн тогтолцоотой болсон. Энэ үед зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд нэн шаардлагатай хууль эрх зүйн актуудыг батлан гаргахаар ажиллаж байсан бөгөөд тэдгээрийн нэг нь өрсөлдөөний харилцааг зохицуулах хууль байсан байна.

Иймээс 1991 оны 5 дугаар сард тухайн үеийн Засгийн газраас дангаар ноёрхолыг хориглох, өрсөлдөөнийг дэмжих тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж Улсын бага хуралд өргөн барьсан боловч хэлэлцэгдээгүй байдаг.

Харин 1993 онд зах зээлийг чөлөөт, шударга өрсөлдөөний зарчмаар хөгжүүлэх, дэлхийн бусад улс орнуудын хөгжлийн нийтлэг жишгийг дагаж Монгол Улсын Их Хурлаас "Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай" хуулийг батлан гаргасан.

Уг хуулийн төслийг боловсруулахдаа Олон Улсын Валютын сан, Азийн хөгжлийн банк, НҮБ-ын мэргэжлийн байгууллагаас зөвлөмж туслалцаа авсан байдаг.

Хуулийн төслийн анхны хувилбарт уг хуулийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллагыг өрсөлдөөний асуудал эрхлэх хороо байхаар, мөн хороог УИХ-аас байгуулдаг байхаар тусгасан байсан. Гэвч хууль батлагдаж гарахдаа энэ хэсэгт өөрчлөлт оруулж хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, шударга бус өрсөлдөөнийг хориглох чиг үүргийг хэд хэд салган УИХ, Засгийн газар, Үндэсний хөгжлийн газар зэрэгт хуваан хариуцуулсан байдаг. Энэ нь олон улсын жишигт нийцээгүй, анх боловсруулж байсан үзэл баримтлалаас ухарсан зүйл болсон.

Улмаар зах зээлийн өрсөлдөөний харилцааг зохицуулах улс төр, эдийн засаг нийгмийн орчин нь бүрдээгүй, хэрэгжүүлэх тогтолцоо тодорхойгүй зэрэг олон

шалтгааны улмаас Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль үндсэндээ хэрэгжихгүй байсан тул 2000 онд уг хуулинд нэмэлт өөрчлөлт оруулсан байдаг.

Энэхүү 2000 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн нэг чухал ололт нь өрсөлдөөний зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байхаар тусгасан явдал юм. 2004 онд Өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь уг хууль амьдралд бодитоор хэрэгжих эхлэл тавигдсан.

Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг хэрэгжүүлэх явцад олон хүндрэл бэрхшээл тулгарч байсан бөгөөд тэдгээрийг шийдвэрлэхээс гадна цаг үеийн байдалд нийцүүлэн өөрчлөх зайлшгүй шаардлагын үүднээс уг хуулийг 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдөр шинэчлэн баталж мөрдүүлсэн нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна.

#### Практик хэрэгжилтийн байдал:

Өрсөлдөөний тухай хуулиар хориглосон зөрчлүүд нь бусад төрлийн захиргааны зөрчлүүдээс ялгаатай буюу өөрийн гэсэн онцлог шинжүүдийг агуулдаг тул эдгээрийг нэг хяналт шалгалтын процессын дагуу шийдвэрлэх боломжгүй байдаг.

Тухайлбал, Өрсөлдөөний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т өөрийн санаачилгаар хяналт шалгалт хийхээр заасан боловч Төрийн хяналт шалгалтын тухай хуульд 5 дугаар зүйлийн 5.1-т төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус байхаар заасан. Картелийн төрлийн зөрчил нь дийлэнхи тохиолдолд нууц далд байдлаар үйлдэгддэг тул түүнийг шалгуулагч этгээдэд мэдэгдэлгүйгээр хянан шалгах шаардлагатай байдаг. Гэтэл Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу хяналт шалгалт хийх талаар шалгуулагч этгээдэд урьдчилан мэдэгдэх гэснийг хэрэгжүүлэх боломжгүй байдаг.

Хяналт шалгалт хийх хугацааны хувьд одоо мөрдөгдөж буй хуулиар 60 хоногийн дотор хийхээр заасан байдаг. Мөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зөрчлийн хэрэг бүртгэлтийг 14 хоногт багтаан хийхээр заасан нь дээрх 2 хугацааны алийг нь баримталж ажиллах талаар ойлгомжгүй байдлыг үүсгэж байна. Нөгөө талаас дээрх 2 хугацааны алийг нь ч баримталж хяналт шалгалтыг хийсэн хугацааны хувьд бодит байдалд Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн эсэх асуудлаар хийх хяналт шалгалтыг хийж дуусгах боломжгүй байдлыг үүсгэж байна.

Учир нь өрсөлдөөний эрх зүйн маргаан бүхий асуудлын гол үндэслэл нь эдийн засгийн тооцоо судалгаанд тулгуурлах явдал бөгөөд тухайн зах зээл, бараа бүтээгдэхүүний цар хүрээнээс хамаараад нарийн тооцоо судалгааг хийхэд зургаан сараас 1 жил хүртэл хугацаа зарцуулах тохиолдол ч гарахаар байна. Дэлхийн бусад улс орнуудын жишгээс харахад зах зээлийн өрсөлдөөний асуудлаарх хяналт шалгалтыг 3 жил хүртэл хугацаанд хийж байна. Мөн өрсөлдөөний асуудлаарх зарим зөрчил тухайлбал картелийн зөрчил нь нууц далд хэлбэрээр хийгдэж, зөрчил гаргагчид аль болох нотлох баримтууд үлдээхгүй байхыг эрмэлздэг тул уг зөрчлийг илрүүлэх, нотлоход ихээхэн хугацаа шаардлагатай байдаг.

Мөн түүнчлэн Өрсөлдөөний тухай хуулиар зохицуулж буй харилцаануудыг цаг үеийн байдал, зах зээл, эдийн засгийн харилцааны хөгжил, дэвшилтэй уялдуулан өөрчлөн найруулах, нэр томъёонуудыг оновчтой болгох, зохицуулах зайлшгүй

харилцаануудыг шинээр бий болгох шаардлага байгааг шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдийн байдлаас харж болохоор байна.

Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллага нь хууль зөрчсөн үйл ажиллагааг илрүүлэн тогтооход холбогдох нотлох баримтыг олж авах, цуглуулах эрх, үүргээ хэрэгжүүлэхэд одоогийн хуулийн зохицуулалт нь хэт ерөнхий байдагтай холбогдуулан хууль хэрэглээний явцад хүндрэлүүд гарсаар байна.

Тухайлбал хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд дараах зарчмийн өөрчлөлтүүдийг хийх практик шаардлага үүсээд байна. Үүнд:

1. Өнөөдрийн байдлаар Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах байгууллага нь хамтын удирдлагын зарчмаар ажиллахаар Өрсөлдөөний тухай хуулинд тусгагдсан боловч байгууллагын оноосон нэрийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар гэж зааж өгсөн байдаг. Олон улсын жишигт төдийгүй Монгол улсад хамтын удирдлагын зарчмаар ажилладаг байгууллагууд нь хороо, комисс гэсэн статустай байдаг нийтлэг жишиг байдаг Жишээлбэл Санхүүгийн зохицуулах хороо, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн Үндэсний комисс гэх мэт. Үүнийг дагаад хуулийн хэрэгжилт сул байгууллагын дарга, гишүүдийн бүрэн эрх тодорхой бус, байгууллагын зохион байгуулалт, статусын талаар нийтэд ойлгомжгүй байдал үүсч байгаа нь ажиллагддаг. Мөн өрсөлдөөний тухай хуулинд өрсөлдөөний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан байдаг ч орон нутагт салбар нэгж байхгүйн улмаас хуулийн хэрэгжилт сул байдаг.

Тиймээс өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагын оноосон нэрийг Хороо байхаар, орон нутагт салбар нэгжтэйгээр хуульчлах зайлшгүй шаардлагатай байна.

- Засгийн газрын бүтцийн байгууллага болох одоогийн өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагын удирдлага болоод боловсон хүчин маш тогтворгүй байгаа бөгөөд тухайлбал 2012-2016 онуудад уг байгууллагын удирдлага нийт 4 удаа өөрчлөгдсөнөөс мэргэжлийн боловсон хүчний тогтвортой байдалд шууд нөлөөлж, байгууллагын чадамж буурч тэр хэмжээгээр хуулийн хэрэгжилт суларч байна.

- Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд хийсэн хяналт шалгалтын үр дүнгийн талаарх шийдвэр болох зөрчлийн талаарх эцсийн шийдвэрийг улсын байцаагч буюу нэг этгээд дангаараа гаргаж, улсын байцаагчийн гаргасан уг шийдвэрийг зөрчилд холбогдогч этгээд эс зөвшөөрвөл шууд шүүхэд маргаан үүсгэж байгаа өнөөгийн зохицуулалт нь учир дутагдалтай болох нь практикаар нотлогдож байна. Учир нь Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн талаарх шийдвэр нь тухайн аж ахуй эрхлэгчийн бизнесийн нэр хүнд, ашиг орлогод шийдвэрлэх нөлөө үзүүлэхээс гадна, хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх торгуулийн хэмжээ өндөр бөгөөд зарим тохиолдолд хэдэн тэрбум төгрөгөөр хэмжигддэг тул зөрчилд холбогдогч этгээд улсын байцаагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй маргаан үүсгэж, шүүхийн ачааллыг нэмэгдүүлэх явдал түгээмэл байна.

Иймд Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн талаар гаргасан улсын байцаагчийн шийдвэрийг тухайн зөрчилд холбогдогч болон гуравдагч этгээд эс зөвшөөрвөл гомдлоо шүүхийн өмнөх шатанд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороонд гаргаж шийдвэрлүүлдэг байх, уг хорооноос гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд хандах зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

- Аж ахуй эрхлэгч нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж ахуй эрхлэгчийг худалдан авах тохиолдолд Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас зөвшөөрөл олгох зохицуулалтын хамрах хүрээг өргөтгөх шаардлагатай байна. Учир нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуулиар дээрх зохицуулалтад зөвхөн давамгайл байдалтай аж ахуй эрхлэгч хамаарч байгаа бөгөөд энэ нь давамгайл байдалтай биш аж ахуй эрхлэгчид хоорондоо нэгдэх, нийлэх замаар зах зээлийн хэт төвлөрөл үүсгэж шударга бус өрсөлдөөний нөхцлийг бий болгох боломжийг үүсгэж байна. Иймд аж ахуй эрхлэгч бусад аж ахуй эрхлэгчтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж ахуй эрхлэгч хуулийн этгээдийн хувьцааг худалдан авсан эсхүл бусад хэлбэрээр шилжүүлэн авсаны үр дүнд Компанийн тухай хуульд заасан хяналтын багцыг эзэмших, эсхүл дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт хамгийн их энгийн хувьцаа эзэмших тохиолдолд өөрчлөн байгуулагдаж байгаа этгээдийн аль нэг нь, эсхүл хувьцаа худалдах, худалдан авах, шилжүүлж байгаа хуулийн этгээдийн аль нэгийг нь борлуулалтын орлогоор босго тогтоодог байхаар өөрчлөх шаардлагатай байна.

Хуулийн зорилтыг бодит байдалд бүрэн гүйцэд хэрэгжихүйц болгох үүднээс энэ хуулийн үйлчлэлд Монгол Улсын зах зээлд нөлөөлөх гадаадын болон дотоодын бүх аж ахуй эрхлэгч, бүх төрлийн захиргааны байгууллага хамааруулах шаардлагатай юм.

Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагын зарим шийдвэр шүүхээр шийдвэрлэгдсэн байдлаас харахад зах зээлд давамгайл байдалтай гэх аж ахуй эрхлэгчийг урьдчилсан байдлаар тогтоож байгаа нь учир дутагдалтай бөгөөд зах зээлийн оролцогчдын нөхцөл байдал байнга өөрчлөгддөгтэй холбоотойгоор энэ зохицуулалт нь бодит нөхцөл байдалд төдий л нийцэхгүй, зорилгодоо хүрч чадахгүй байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 78 мянга гаруй аж ахуйн нэгжийг үйл ажиллагаа явуулж байгаа зах зээл тус бүрээр нь судлан давамгайл байдалтай эсэхийг тогтоож, уг аж ахуй эрхлэгч бүрийн зах зээлийн эзлэх хувь өөрчлөгдөхийг мөн тухай бүр судлан тогтоох шаардлагатай болдог. Энэ нь хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө мөнгө ихээхэн шаарддагаас бодит байдалд хэрэгжүүлэх боломжгүй байна. Иймээс аливаа этгээдийг хууль бус үйл ажиллагаа явуулж буй цаг хугацаандаа давамгайл байдалтай байгаа эсэхийг нь тухай бүрт нь тогтоож байх нь шударга ёсны зарчимд нийцсэн, бодит үндэслэлтэй болох юм.

**1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлсон байдал:**

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Өрсөлдөөний тухай хуулийн үйлчлэлд Монгол Улсад бүртгэлтэй, аж ахуй эрхэлж байгаа ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хувь хүн, Төрийн захиргааны байгууллага буюу Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, баг, хорооны иргэдийн нийтийн хурал хамаарч байна.

Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд гадаадын хуулийн этгээд болон Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан захиргааны байгууллага, төрийн бус байгууллагыг хуулийн үйлчлэлд хамааруулах юм.

Тодруулбал Монгол Улсад бүртгэлгүй гадаадын хуулийн этгээд, иргэн, Монгол Улсын Засгийн газар, яам, Улсын Их хурлын харьяа байгууллага, Монгол Улсын Засгийн газрын харьяа байгууллага болон төрийн чиг үүргийг хууль, гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж, аж ахуйн үйл ажиллагаанд оролцож байгаа төрийн бус байгууллагыг шинээр хуулийн үйлчлэлд хамааруулна.

Эдгээр гадаадын хуулийн этгээд, иргэн дээр дурьдсан байгууллага, түүний албан тушаалтнууд Монгол Улсын Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг мөрдөх бөгөөд тэдгээрийн эрх, ашиг сонирхол шууд хөндөгдөхгүй.

### 1.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

Тандан судлах ажлын хүрээнд зах зээлийн шударга өрсөлдөөн, өрсөлдөөний хууль эрх зүйн орчны талаарх бизнес эрхлэгчдийн ойлголт, хандлага болон Монгол Улсын зах зээлийн өрсөлдөөний төлөв байдал, зах зээлд нэвтрэх саад, өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд гарч буй саад, бэрхшээлийг тус тус судалж, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийн дунд хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Зах зээлийн шударга өрсөлдөөн, өрсөлдөөний хууль эрх зүйн орчны талаарх бизнес эрхлэгчдийн ойлголт, хандлагын судалгааны түүврийг үүсгэхдээ 2015 оны 4-р улирлын байдлаар бизнес регистрийн санд бүртгэлтэй идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа 63,401 аж ахуйн нэгж, байгууллагаас 600 аж ахуйн нэгж, байгууллагыг түүвэрлэн судалгаанд хамруулсан ба энэ нь үндэсний хэмжээний төлөөлөх чадвар бүхий түүвэр юм. Судалгааны мэдээллийг анкет судалгааны аргаар цуглуулсан ба судалгааны анкет нь 6 бүлэг 57 багц асуулттай, нэг оролцогчоос 60-80 минутын турш нүүр тулсан ярилцлага хэлбэрээр мэдээлэл цуглуулсан. Судалгаанд байгууллагын зах зээлийн өрсөлдөөний талаар бүрэн мэдээлэл бүхий байгууллагын удирдах албан тушаалтан болон мэргэжилтэнгүүдийг судалгаанд хамруулсан.

Монгол Улсын 21 аймгийн төв, Улаанбаатар хотын 7 дүүргийн 600 аж ахуй нэгжийг хамруулсан ба үүнээс 335 ААНБ Улаанбаатараас, 265 ААНБ орон нутгаас хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан аж ахуй нэгжүүдийг эдийн засгийн салбараар авч үзвэл 6.5% Цахилгаан, хий, уур агааржуулалт, 2% Нефть, 5.7% Мэдээлэл холбоо, 14.8% Эрүүл мэнд, 9% Банк, санхүү, даатгал, 2.8% Боловсрол, 9.8% Барилга, орон сууц, 7.7% Ус, НАА, СӨХ, 4.8% Тээвэр, 3.2%, Уул уурхай, 6% Боловсруулах үйлдвэр, 4.7% Худалдааны төв, Кинотеатр гэсэн салбарын төлөөллүүд хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан бүрэлдэхүүн төлөөлөх чадвартай байхаар сонгогдсон.

Судалгаанд оролцогчдын өрсөлдөөний орчин нөхцлийн талаарх үнэлгээ харилцан адилгүй байна. Нийт оролцогчдын 75% нь шударга өрсөлдөөний орчин, нөхцлийг дунд ба түүнээс доогуур үнэлсэн ба дунд ба муу гэж үнэлсэн оролцогчдын олонх нь хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эрүүл мэнд, барилгын салбарт үйл ажиллагаагаа явуулж байна.

Өрсөлдөөнийг хязгаарлагч хамгийн том хүчин зүйлийг төрийн байгууллага бий болгож байна. аж ахуйн нэгж, байгууллагуудын том, жижгээс үл хамааран төрийн байгууллагууд шударга өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлийг гаргадаг гэсэн бөгөөд

тухайлбал, 50 ба түүнээс дээш ажилчидтай аж ахуйн нэгж, байгууллагуудын 60 орчим хувь нь төрийн байгууллагыг шударга бус өрсөлдөөний зөрчил гаргадаг гэжээ.

Өрсөлдөөний тухай хуулийн зохицуулалтын хамрах хүрээнд Төрийн захиргааны байгууллага буюу Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд болон аймаг, нийслэл, сум, дүүргий иргэдийн төлөөлөгчдийн хурал, баг, хорооны иргэдийн нийтийн хурлаар хязгаарлагдаж байгаа нь бусад төрийн байгууллага, албан тушаалтаны өрсөлдөөнийг хязгаарлах үйл ажиллагаанд хяналт тавих эрх зүйн боломжгүйг харуулж байна.

Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагын улсын байцаагчийн хяналт шалгалт, зохицуулалтын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан дүрэм, журам дутмаг байдаг, эдийн засгийн тооцоо судалгааг үнэн зөв, бүрэн гүйцэд хийгээгүйн улмаас тус байгууллагаас гаргасан захиргааны шийдвэрүүд шүүхийн шатанд хүчингүй болох тохиолдлууд сүүлийн жилүүдэд өссөн үзүүлэлттэй гарсан байна. Нэг талаас боловсон хүчний мэргэжлийн шалгуур, шаардлага, хяналт шалгалт, зохицуулалтын үйл ажиллагааг нарийвчилсан зохицуулалтыг хуульчилж өгөөгүйтэй шууд холбоотой юм. Түүнчлэн хуулийн зохицуулалтын хийдэл, цоорхой байгаагаас зах зээлд шударга бус өрсөлдөөн бий болох нөхцлийг бүрдүүлж байна. Мөн Засгийн газрын бусад байгууллагаас гаргаж буй өрсөлдөөнийг хязгаарласан шийдвэрүүдийг хянах боломжгүй, тэдгээрийг хянах шаардлагатайг харуулж байна. Эдгээр нь Өрсөлдөөний тухай хуулийн хэрэгжилт сул байгааг илэрхийлж байна.

Иймээс судалгааны дүнг үндэслэж, өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг олон улсын жишиг, практик, дээр дурдсан бэрхшээлүүдэд тулгуурлаж хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлагатай байна гэж үзлээ.

### ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Энэхүү үнэлгээний тайлангийн нэгд заасан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага урган гарч байгаатай холбогдуулан Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

#### Зорилго:

1. Өрсөлдөөний эрх зүйн зохицуулалтыг нийгмийн хэрэгцээ, шаардлага болон олон улсын жишигт нийцүүлж, нийгмийн харилцаанд үүсч болох бизнесийн шударга бус өрсөлдөөний зохицуулалтыг өөрчилж, зарим ойлголтын нэр томъёоны агуулга шинэчлэгдэж, өрсөлдөөний асуудал эрхэлсэн байгууллага чадавхжих, бие даан үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин бэхжүүлнэ.

2. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгддэг Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан эдгээр хуультай нийцүүлэн практикт хэрэгжих, өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэхэд төрийн байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоо тодорхой болгоно.

### ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛУУДЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

1. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоох. Энэхүү үнэлгээний тайлангийн Нэгд заасан асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу "зорилгод хүрэх байдал" буюу Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагын албан хаагчдын хууль зүй, эдийн засаг, нийгэм, улс төрийн зэрэг баталгааг манай улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлж, чиг үүргээ хууль ёсны дагуу хэрэгжүүлэх нөхцөл бололцоог сайжруулах, хуулиар зохицуулаагүй харилцааг зохицуулах, хуулийн оновчгүй зохицуулалтаас үүдэлтэй бэрхшээлийг арилгах зорилгоор шийдлийг сонгох хувилбарыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь хэсэг, Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалд тус тус заасны дагуу Өрсөлдөөний тухай хуулийг шинэчлэн боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Асуудалд дүн шинжилгээ хийх явцад хуулийг өөрчлөх, шинэчлэн найруулахгүйгээр асуудлыг шийдвэрлэх гарцуудын талаар тодорхой судалгаанууд хийгдсэн.

• "Тэг" хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах. Энэ тохиолдолд өнөөгийн мөрдөж буй эрх зүйн зохицуулалтын хүрээнд ажиллахыг ойлгох бөгөөд одоогийн мөрдөж буй хуулийн зарим заалт хэрэгжих боломжгүй, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа ба өрсөлдөөний асуудал, Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагын эрх зүйн чадамж, эдийн засгийн баталгаа нь олон улсын болон өнөөгийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдалд нийцээгүй, бизнес эрхлэгчдийн өрсөлдөөний орчинг сайжруулах боломжгүй, хуулийн зохицуулалтын хийдэл, цоорхой байдал хэвээр, төрийн байгууллагуудаас өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагааг зохицуулах зохицуулалт хангалтгүй хэвээр байна. Хуулийн хэрэгжилт муу байгаа нь бизнесийн орчин, улмаар Монгол улсын эдийн засгийн өсөлтөд сөрөгөөр нөлөөлж байна.

• Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх. Одоогийн мөрдөж буй Өрсөлдөөний тухай хуулийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон бусад арга хэрэгслээр олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг авч байгаа боловч тухайн хуулийн зохицуулалт нь өнөөгийн нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлага, олон улсын жишигт нийцээгүйгээс зах зээлийн өрсөлдөөний харилцааг хангалттай зохицуулж чадахгүй байна.

• Зах зээлийн механизмаар төрөөс зохицуулалт хийх. Татвар, хураамжийн бодлого, эсхүл зөвшөөрөл, лиценз болон квот зэрэг зах зээлийн эдийн засагт нөлөөлөхүйц арга хэмжээг төрөөс зохицуулж байгаа нь өрсөлдөөний харилцааг зохицуулах боломжгүй юм. Учир нь Өрсөлдөөний тухай хуулиар зүй ёсны монополь, давамгайл байдалтай аж ахуй эрхлэгч, нэгдэн, нийлэх үйл ажиллагаа, үгсэн хуйвалдах, давамгайл байдлаа буруугаар ашиглах, өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулах, төрийн байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагааг зохицуулах зэрэг зах зээлийн эдийн засагт нөлөөлдөг томоохон харилцааг зохицуулдаг.

• Төрөөс санхүүгийн интервенц хийх. Төрөөс санхүүгийн интервенц хийх буюу шууд мөнгөн хэлбэрийн дэмжлэг үзүүлэх аргаар зохицуулах нь өрсөлдөөний харилцааг зохицуулах боломжгүй юм.



• Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх. Монгол улсын Засгийн газрын тухай хуульд "Засгийн газар нь төргийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж болно..." гэж заасан байдаг боловч зах зээлийн өрсөлдөөний харилцааг зохицуулах боломжгүй юм. Учир нь төрийн байгууллага нь төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байгаа нь бизнес эрхлэгчдийн өрсөлдөөнийг /зөвшөөрөл, лиценз гэх мэт/ зарим тохиолдолд хязгаарладаг.

• Захиргааны шийдвэр гаргах. Тус байгууллага нь хэдийгээр захиргааны байгууллага боловч зах зээлийн өрсөлдөөний эрх зүйн харилцааг зөвхөн захиргааны шийдвэрээр зохицуулах боломжгүй эдийн засгийн олон талт харилцаа юм.

• Хууль тогтоомжийн төсөл боловсруулах. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах аргачлалын 5.1-д заасны дагуу тухайн асуудал нь хүний салшгүй эрхийг /Монгол улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрхийг/ хөндөж байгаа бол хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарын шууд сонгоно гэсний дагуу Өрсөлдөөний тухай хуулийн шинэчлэн найруулгаар зохицуулах асуудлууд нь хүний салшгүй эрхэд буюу Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний аж ахуй эрхлэх, өмч хөрөнгөтэй байх, түүнийгээ захиран зарцуулахтай холбогдсон эрх, үүргийг бий болгох, хязгаарлах, улмаар хуулийн хариуцлага ногдуулах хүртэл харилцааг зохицуулах тул үүнийг гагцхүү хууль тогтоомж гаргах замаар шийдвэрлэх боломжтой юм.

## 2. Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах.

**2.1. Зорилгод хүрэх байдал.** Зорилгод хүрэх байдлыг өмнө хийгдсэн судалгаа, санал асуулга, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүд болон салбарын мэргэжилтнүүдийн санал зэргийг үндэслэн тодорхойллоо. Өрсөлдөөний эрх зүйн зохицуулалтыг нийгмийн хэрэгцээ, шаардлага болон олон улсын жишигт нийцүүлж, нийгмийн харилцаанд үүсч болох шударга бус өрсөлдөөний зохицуулалтыг өөрчилж, зарим ойлголтын нэр томъёоны агуулга шинэчлэгдэж, өрсөлдөөний асуудал эрхэлсэн байгууллага чадавхиж, бие даан үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгддэг Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан эдгээр хуультай нийцүүлэн практикт хэрэгжих, өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэхэд төрийн байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоо тодорхой болно гэж үзэж байна.

**2.2. Зардал, үр өгөөжийн харьцаа.** Өрсөлдөөний тухай хуулийг шинэчилэн батлуулсанаар өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллага нь Засгийн газрын бүтцээс гарч одоогийн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын бааз суурин дээр өргөжин УИХ-ын харьяанд шинэчлэн байгуулагдах тул бүтцийн өөрчлөлтийн зардал шаардагдана.

Байгууллага нь өөрчлөн зохион байгуулагдсанаар үйл ажиллагааны зардалд жилд 2,179.0 сая төгрөг шаардлагатай гэж төсөөлж байна. 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэлд дүнтэй харьцуулахад шинэ бүтцээр ажиллах орон тоо, урсгал зардалд 1,209.9 сая төгрөг нэмж шаардагдана.

Түүнчлэн Улсын Их хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх, төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах, эрүүл мэнд, боловсрол, цагдаа, онцгой байдлын салбараас 2017-2019 онд өндөр насны тэтгэвэрт гарах 2 төрийн албан хаагч тутамд 1 албан хаагчийг нөхөн томилж, энэ хугацаанд бусад салбарт төрийн албанаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн албан хаагчийн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байж, ажил, үүргийн хуваарийг шинэчлэн оновчтой тогтоох замаар ачааллыг нягтруулах, сул орон тоог зайлшгүй нөхөх шаардлагатай гэж үзвэл төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад дахин зохион байгуулалт хийх зарчмаар шийдвэрлэх гэж тус тус тусгасны дагуу төсвөөс зардал бага гархаар харагдаж байна.

Өрсөлдөөний тухай хуулийг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгж, иргэдэд тусгайлан хуулиар олгодог зөвшөөрөл, лиценз, лавлагаа зэргийг гаргахгүй тулзахиргааны ачаалал, зардал гарахгүй болно.

### 3. Харьцуулалтанд үндэслэн хамгийн үр дүнтэй хувилбарыг сонгох.

Энэхүү тандан судалгааг хийх явцад зохицуулалтын нэг л хувилбар буюу хууль тогтоомжийн төслийг боловсруулах хувилбарыг сонгон авсан болно. Мөн Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах аргачлалын 5.1-д заасны дагуу тухайн асуудал нь хүний салшгүй эрхийг /Монгол улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрхийг/ хөндөж байгаа бол хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарын шууд сонгоно гэсний дагуу Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгаар зохицуулах асуудлууд нь хүний салшгүй эрхэд буюу Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний аж ахуй эрхлэх, өмч хөрөнгөтэй байх, түүнийгээ захиран зарцуулахтай холбогдсон эрх, үүргийг бий болгох, хязгаарлах, улмаар хуулийн хариуцлага ногдуулах хүртэл харилцааг зохицуулах тул үүнийг гагцхүү хууль тогтоомж гаргах замаар шийдвэрлэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Мөн дээр дурдсанчлан зориглгод хүрэх үр дүн нь нийгэм эдийн засагт учруулах сөрөг нөлөөллөөс илүү эерэг үр өгөөжтэй байгаа нь харагдаж байна.

### **ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 5.4-т заасны дагуу хуулийн төсөл боловсруулах нэг хувилбарыг сонгосон ба үүнтэй холбогдуулан сонгосон нэг хувилбарын үр нөлөөг Аргачлалын 6-д заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

*Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг үнэлгээний тайланд хавсаргасан хавсралт хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.*

#### **4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд Өрсөлдөөний тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж заасантай уялдуулан боловсруулна.

Ийнхүү боловсруулахдаа хүний эрх, эрх чөлөөг хөндөж байгаа ажиллагаа Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци зэрэгт нийцэж байгаа эсэх, улмаар хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх эрсдлээс хамгаалах, хариуцлагыг нэмэгдүүлэх зэргээр хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн зохицуулалтыг бий болгоно.

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа нь Аргачлалын 6.2-т заасан хүний эрхэд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт/Хавсралт хүснэгт 1/-аас харагдаж байна.

#### 4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь дотоодын болон гадаадын аж ахуйн нэгж байгууллага дэлхий болон дотоодын зах зээл дээр өрсөлдөх чадварт эерэг нөлөө үзүүлэх ба макро эдийн засгийн тогтвортой байдал, өрхийн орлого, зарлага, олон улсын харилцаа зэрэгт сөрөг нөлөө үзүүлэхгүй нь Аргачлалын 6.2-т заасан эдийн засагт үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт/Хавсралт хүснэгт 2/-оос харагдаж байна.

#### 4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хувьд Аргачлалын 6.2-т заасан нийгэмд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт/Хавсралт хүснэгт 3/-аас харахад нийгэмд үзүүлэх ямар нэг сөрөг үр нөлөө байхгүй ба төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид эерэгээр нөлөөлөхөөр байна.

#### 4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Аргачлалын 6.2-т заасан байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт/Хавсралт-1/-аас харахад хуулийн төсөл боловсруулах хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй байна.

#### 4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Аргачлалын 5.4.4-т "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу хийсэн үнэлгээнээс тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн зөвлөмж гарсан бол" гэж заасны дагуу холбогдох судалгааны үр дүн болон практикт тулгарч байгаа хүндрэл бэрхшээлүүдийг засч залруулах зах зээлийн эдийн засаг өндөр хөгжсөн зарим орнуудын өрсөлдөөний тухай хуулийн жишигт нийцүүлэн хуулийн төсөл боловсруулах хувилбарыг сонгосон.

Түүнчлэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай бодлогын баримт бичгүүдэд зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих, эрх зүйн орчинг сайжруулах талаар тусгасан байна.

- Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл (Хуулийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж байгаа бэрхшээлийг шийдвэрлэх, уг хуулийг зах зээлийн эдийн засгийн харилцааг зохицуулах суурь хууль болгон өөрчлөн шинэчлэх)

- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого хэсэгт “Макро тэнцвэрийг бататгасан олон тулгуурт дотоодын үйлдвэрлэлд түшиглэсэн, тогтвортой эдийн засгийг бий болгон Монгол Улсын үндэсний нийт орлогыг нэмэгдүүлж, дундаж-дээгүүр орлоготой орнуудын эгнээнд буцаан оруулна гэж заасан. Энэхүү хэсгийн 2.12-т “Зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжиж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг сайжруулна” гэж заасан байгаа.

Одоогийн мөрдөж буй хуулиар Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллага нь өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, өрсөлдөөний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, аж ахуй эрхлэгч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн гэж заасны дагуу үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хүндрэл бэрхшээлүүдийг хуульд өөрчлөлт оруулах замаар сайжруулах зайлшгүй шаардлагатай байгаа. Үүнд:

1. Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллага статус, бүтэц, зохион байгуулалт
2. Хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, өрсөлдөөнд хамааралгүй зохицуулалт байдаг
3. Зарим зохицуулалт дутуугаас хуулийн хийдэл гардаг
4. Зарим харилцааг хуулиар зохицуулах боломжгүй байдал үүсдэг

#### ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг харьцуулан дүгнэлт хийлээ. Үүнд:

Өрсөлдөөний тухай хуулийг шинэчлэн найруулснаар чөлөөт зах зээлийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, аж ахуй эрхлэгчдийн бизнес эрхлэх өрсөлдөөний таатай орчныг сайжруулах, хэрэглэгчдэд зах зээлд бодит үнэ, өртөгөөр чанартай бараа бүтээгдэхүүн нийлүүлэх зохицуулалтыг бий болгох, өрсөлдөөний хуулийн хэрэгжилт сайжирна.

Өрсөлдөөний эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлснээр Монгол Улс дахь бизнесийн орчин сайжирч, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэх, эдийн засгийн салбарууд хурдацтай хөгжихөд чухал нөлөө үзүүлнэ. Мөн аж ахуй эрхлэгч нэгдэн, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж ахуй эрхлэгчийг худалдан авах, удирдлагын үүргийг хавсран гүйцэтгэхэд Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас зөвшөөрөл олгосноор зах зээлийн төвлөрөлд хяналт тавьж, аж ахуй эрхлэгчид давамгайл байдлаа хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлж, хянах боломж бүрдэнэ. Мөн дээр дурдсан асуудалд Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн

байгууллагаас зөвшөөрөл олгох зохицуулалтын хамрах хүрээг өргөтгөж байгаа боловч шийдвэрлэх хугацааг тодорхой, шуурхай болгосноор аж ахуй эрхлэгчдэд хүндрэл, чирэгдэл учруулахгүй гэж тооцоолж байна.

Хуулийн хариуцлагын оновчтой, бодит байдалд хэрэгжихүйц болгон тодорхойлж хуульчилснаар зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, гаргасан зөрчлийг цаг алдалгүй таслан зогсоох, зөрчлийн улмаас нийгэм, эдийн засаг, иргэн, аж ахуй эрхлэгчдэд учирч болох хохирлыг багасгах томоохон хөшүүрэг болохуйц бодитой арга хэмжээний тогтолцоотой болно.

Хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд Өрсөлдөөний тухай хууль тогтоомжид хяналт тавих байгууллагыг Улсын Их хурлын харьяаны байгууллага болгосноор өмчийн хэлбэр харгалзахгүй хяналт тавих эрх мэдлийн хараат бус буюу Засгийн газраас хараат бусаар бие дааж, үйл ажиллагаа явуулах, түүний харьяа байгууллагуудын өрсөлдөөнийг хязгаарласан шийдвэрт хяналт тавих нөхцөл бүрэлдэх илүү давуу тал бий болно.

## ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар сонгогдсон тохиолдолд Аргачлалын 8-д заасны дагуу олон улсын эрх зүйн холбогдох зохицуулалт, бусад орны адил төстэй эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх зорилгоор энэ чиглэлээр өмнө хийгдсэн судалгааны мэдээлэлд үндэслэн дараах олон улсын эрх зүйн зохицуулалтыг сонгон авсан: /Хавсралт-2/

1. Нэгдсэн үндэсний байгууллагаас хөгжиж буй болон хөгжингүй орнуудын Өрсөлдөөний байгууллагын эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор загвар хуулийг боловсруулсан байдаг бөгөөд энэхүү НҮБ-ын загвар хуулийг сонгон авлаа;

2. Өндөр хөгжилтэй орны хууль эрх зүйн оновчтой шийдэл, хоёр улсын хооронд байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр болон тус байгууллагад Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/-ийн дэмжлэгтэйгээр “Монгол Улсын шударга өрсөлдөөний орчинг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Япон улсын Монополийг хориглох тухай хуулийг сонгон авлаа.

Нэгдсэн үндэсний байгууллагын худалдаа хөгжлийн бага хурал нь өрсөлдөөний тухай хууль, бодлогын бичиг баримтын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахын зэрэгцээ Өрсөлдөөний загвар хуулийг гаргасан бөгөөд тухайн баримт бичгыг үндэслэн судалгааг хийлээ.

Энэхүү загвар хуульд улс орон бүр өөрийн эдийн засаг, нийгмийн онцлогт тохируулан хэрэглэж болохоор зохицуулан боловсруулсан, аливаа аж ахуй эрхлэгчид тус тусын зах зээлд эзлэх давамгайл байдлыг урвуугаар ашиглах, нэгдэн нийлэх замаар дотоод болон гадаад худалдааны зах зээлийн өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөх гэрээ хэлцэл байгуулах, арга хэрэгсэл ашиглахыг таслан зогсоох тухайлбал зүй ёсны монополь болон давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчийн хориглосон үйл ажиллагаа, нэгдэн, нийлэх, худалдан авах ажиллагааны хуулийн зохицуулалтын талаарх зөвлөмж, хүнд хэлбэрийн картелийг нарийвчлан үзэх, тухайн зөрчлийн байдлаас хамааран захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх зэргээр тодорхойлсон байна.

Япон улсын хувьд манай улстай ижил төстэй хуулийн зарим заалтыг хэрэглэх боломжгүй, хэрэгждэггүй заалтуудыг тодорхой шийдэж өгсөн, авч хэрэгжүүлэх боломж бололцоотойн дээр хоёр орны хоорондын эдийн засгийн хэлэлцээр, тус газарт хэрэгжүүлж буй төсөл зэргээс үүдэн Япон улсын Монополийг хориглох тухай хуулийг авч үзлээ.

Япон улсын Монополийг хориглох тухай хуульд Өрсөлдөөний асуудал эрхэлсэн байгууллага нь хорооны зохион байгуулалттай буюу эцсийн шийдвэрийг хамтын удирдлагын зарчмаар гаргадаг, хуулиар байгууллагын эрх зүйн байдлыг нарийвчлан тогтоож, давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчийг урьдчилан тогтоодоггүй зэрэг сайн туршлагыг хуулийн төслийг боловсруулахдаа авч ашиглахаар байна. Тухайлбал хамтын удирдлагыг томилох, чөлөөлөх, нөхөн томилох, бүрэн эрхийн хугацаа, ажлын алба, албан хаагчдын баталгаа зэргийг тусгаж өгсөн байна.

Хуулийн төслийг боловсруулахад хамрах хүрээг “Монгол Улсын зах зээлд нөлөөлөх гадаад болон дотоодын бүх аж ахуй эрхлэгч, төрийн захиргааны байгууллага, Монгол банк, төрийн бус байгууллага /мэргэжлийн холбоо/ хамаарна” гэж тусгахаар байна. Учир нь харьцуулсан орнуудын хуулийн хамрах хүрээний зохицуулалт тийм байна.

## ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Аргачлалын 9-д заасны дагуу энэхүү үнэлгээний тайлангийн 5 дахь хэсгийн “Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт”, 6 дахь хэсгийн “Олон улсын болон бусад улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал” зэргийг харьцуулан Зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгддэг гол хуулиуд Зөрчлийн тухай, Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан эдгээр хуультай нийцүүлэн практикт нэг зэрэг хэрэгжих нөхцлийг бүрдүүлэх, Өрсөлдөөний эрх зүйн зохицуулалтыг нийгмийн хэрэгцээ, шаардлага болон олон улсын жишигт нийцүүлж, нийгмийн харилцаанд үүсч болох шударга бус өрсөлдөөний зохицуулалтыг өөрчилж, зарим ойлголтын нэр томъёоны агуулга шинэчлэгдэж, өрсөлдөөний асуудал эрхэлсэн байгууллага чадавхижж, бие даан үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин бэхжүүлэх, сайжруулах зорилгын хүрээнд дараахь зөвлөмжийг боловсрууллаа. Үүнд:

1. Хуулийн төслөөр зохицуулах харилцаа нь холбогдох процесс үйл ажиллагааг зохицуулсан хуулиудтай /Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай/ уялдах шаардлагатай учраас Өрсөлдөөний тухай хуулийн төслийг тэдгээр хуулиудын үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулах.

2. Хуулийн төслийг зөвлөмжийн 1-т заасанд нийцүүлэн шинэчлэхдээ тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, Өрсөлдөөний эрх зүйн зохицуулалтыг нийгмийн хэрэгцээ, шаардлага болон олон улсын жишигт нийцүүлэх, зарим ойлголтын нэр томъёоны агуулга шинэчлэгдэх, байгууллагын статусын өөрчлөлтийн асуудлыг тусгах зэргийг харгалзан одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Өрсөлдөөний тухай хуулийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасны дагуу шинэчилсэн найруулга хэлбэрээр боловсруулах.

---oOo---

1. ХҮНИЙ ЭРХ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ  
ҮР НӨЛӨӨНИЙ ТАНДАЛТЫН СУДАЛГАА

Хавсралт-1

1.1 ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Үгүй	
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	
	1.1.3. Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Үгүй	Эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилготой арга хэмжээ биш болно.
	1.2. Оролцоог хангах		
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Аж ахуй эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн удирдлага, болон бусад төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулж хэлэлцүүлэг хийж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэхийг тогтоосон. Оролцогчдын санал, хүсэлтийг хуулийн төсөлд зохих хэмжээнд тусгана.
	1.2.2. Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Зүй ёсны монополь болон давамгайл байдалтай аж ахуй эрхлэгч болон бусад аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээд хамаарна. Мөн гадаадын хуулийн этгээд хамаарна.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага		
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн	Тийм	Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээнд аливаа байдлаар харшлаагүй бөгөөд хүний эрхийг хамгаалахад чиглэгдэж байна.

	талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх			
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм		
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Аж ахуй эрхлэгчдийн зарим эрхийг хязгаарлаж байгаа боловч аж ахуй эрхлэгчийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, өрсөлдөөнийг хамгаалах, зах зээлд ноёлох болон өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хориглон хязгаарлах зорилтыг хүрээнд хэрэгжинэ.	
3. Эрх агуулагч	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Олон улсын жишиг болон одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зайлшгүй хязгаарлалт тогтоох шаардлагатай юм.	
	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Үгүй		
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Үгүй		
4. Үүрэг хүлээгч	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Үгүй		
	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө хороо болон захиргааны байгууллага, мэргэжлийн төрийн бус байгууллага, аж ахуй эрхлэгчид хуулийн дагуу үүрэг хүлээхээр байна.	
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Үгүй	Уг хуульд жендерийн эрх хөндөгдөхгүй болно.	



Хуульд нийцүүлсэн эсэх	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Үгүй	Уг хуульд жендерийн эрх хөндөгдөхгүй болно.
------------------------	---	------	---

### 1.2 ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Дэлхийн зах зээлд дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй. Хуулийн үйлчлэлд дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид тэгш үйлчлэх бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл бий болгоно.
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээд нь Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдтэй Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна болон дотор талд нэгдэл үүсгэх, нэгдэх, нийлэх болон хувьцааг худалдан авах, бэлэглэх, шилжүүлж авахад Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө хороонд мэдэгдэл гаргаж, зөвшөөрөл авна.
	1.3. Дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Энэ хуулийн үйлчлэлд Монгол улсын зах зээлд нөлөөлөх гадаад улсын бүх аж ахуй эрхлэгч хамаарахаар төсөлд тусгасан.
	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Үгүй	
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.2. Хязгаарлагдмал улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Үгүй	Зохицуулалттай салбарт үйл ажиллагаа явуулж байгаа зүй ёсны монополь аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүний үнийг хянах зохицуулалтыг шинээр нэмэх бөгөөд хэрэглэгчдийн зайлшгүй хэрэгцээ болох ус, цахилгаан, дулааны үнийг хянаж, зөвшөөрөл олгоно.
	2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Үгүй	
	2.4. Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Үгүй	Хуулийн этгээд бусад хуулийн этгээдтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад компанийн хувьцааг худалдан авах, хувьцааг бусдад бэлэглэх, шилжүүлэх

3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1. Зохицуулалтын хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Угүй	болон удирдлагын үүргийг хавсран гүйцэтгэхэд зохих хязгаарлалт хийж, Хуулийн этгээдийг тодорхой тохиолдолд хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэр гаргаж, шүүхээр хянан шийдвэрлүүлэх зохицуулалтыг оруулсан болно.
	3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	
	3.3. Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Угүй	
	3.4. Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Зохицуулалттай салбарт үйл ажиллагаа явуулж байгаа зүй ёсны монополь аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүний үнийн зөвшөөрлийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө хорооноос авсны үндсэн дээр үнийг мөрдөж эхлэх юм.
	3.5. Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Угүй	
4. Мэдээлэх үүргийн үүсч улмаас захиргааны зардлын ачаалал	4.1. Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Аж ахуй эрхлэгч нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж ахуй эрхлэгчийг худалдан авахад Өрсөлдөөний асуудал хариуцсан байгууллагаас дүгнэлт гаргана
5. Өмчлөх эрх	5.1. Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Угүй	
	5.2. Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Аж ахуй эрхлэгч нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж ахуй эрхлэгчийг худалдан авахад Өрсөлдөөний асуудал хариуцсан байгууллагаас дүгнэлт гаргана
	5.3. Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Угүй	

6. Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1. Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Үгүй	Урьдчилан тооцоолох боломжгүй бөгөөд аж ахуй эрхлэгч бүр тэгш эрхтэйгээр шударгаар өрсөлдөж, шинэ бараа бүтээгдэхүүн бий болгох, худалдан борлуулах боломж бүрдэх юм.
	6.2. Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Үгүй	
	7. Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	Үгүй	
	7.1. Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
7. Тодорхой бүс нутаг, салбарууд	7.2. Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Үгүй	
	7.3. Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагааг хориглосон зохицуулалтыг шударга худалдааг хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагааг хориглох гэж өөрчилсөн бөгөөд өрсөлдөөнийг хязгаарласан эсэхээс үл хамаарч шударга бус худалдааны үйл ажиллагааг хориглоно. Үүгээр хэрэглэгч болон аж ахуй эрхлэгчийн эрх хамгаалагдах таатай боломж бүрдэнэ гэж тооцоолж байна.
	7.4. Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	8. Тодорхой бүс нутаг, салбарууд	Үгүй	
8. Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1. Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Үгүй	
	8.2. Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	8.3. Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Зохицуулалттай салбарт үйл ажиллагаа явуулж байгаа зүй ёсны монопол аж ахуй эрхлэгчид үнийн зөвшөөрөлийг авах шинэ зохицуулалт бий болно.
9. Төрийн захиргааны байгууллага	9.1. Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын харьяалал Монгол Улсын Засгийн газрын харьяалалаас

				өөрчлөгдөж, УИХ-ын харьяалалд шилжсэн тохиолдолд улсын байцаагч болон бусад төрийн албан хаагчдын цалингийн зэрэглэл, шатлалд өөрчлөлт орж болно.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм		Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын харьяалал Монгол Улсын Засгийн газрын харьяалалаас өөрчлөгдөж, УИХ-ын харьяалалд шилжсэн тохиолдолд бүтцийн өөрчлөлт хийгдэнэ.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм		Зохицуулалттай салбарт үйл ажиллагаа явуулж байгаа зүй ёсны монопол аж ахуй эрхлэгчид үнийн зөвшөөрөл олгоно.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй		
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Шударга өрсөлдөөний таатай нөхцлийг бүрдүүлэх бөгөөд шударга өрсөлдөөний нөхцөл бүрдсэнээр эдийн засгийн өсөлт, зах зээлийн тогтвортой хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.
11.Олон харилцаа	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Үгүй		
	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		
<b>1.3 НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ</b>				
<b>Үзүүлэх үр нөлөө</b>	<b>Холбогдох асуулт</b>	<b>Хариулт</b>	<b>Тайлбар</b>	
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Үгүй		
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Үгүй		
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй		
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Үгүй		
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Үгүй		

3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	<p>2.2. Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх</p> <p>2.3. Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх</p> <p>2.4. Шинээр ажлын стандарт гаргах эсэх</p> <p>2.5. Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх</p> <p>3.1. Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх</p> <p>3.2. Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт</p> <p>3.3. Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх</p>	<p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Тийм</p>	<p>Хуулийн этгээд бусад хуулийн этгээдтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах бусад компанийн хувьцааг худалдан авах, хувьцааг бусдад бэлэглэх, шилжүүлэх болон удирдлагын үүргийг хавсран гүйцэтгэх тохиолдолд мэдэгдэл гаргаж, зөвшөөрөл авна. Энэ хуулийн үйлчлэлд Монгол улсын зах зээлд нөлөөлөх гадаад бүх аж ахуй эрхлэгч хамаарна.</p>
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	<p>4.1. Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх</p> <p>4.2. Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх</p>	<p>Үгүй</p> <p>Үгүй</p>	<p>Өрсөлдөөнийг хязгаарлах үйл ажиллагааг хориглох зохицуулалтын хамрах хүрээнд төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага хамаарч байсныг өөрчилж, захиргааны байгууллага хамаарахаар өөрчиллөө. Ингэснээр Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан захиргааны байгууллага бүхэлдээ хуулийн үйлчлэлд хамаарна.</p>

4.3. Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан захиргааны байгууллага буюу албан тушаалтанаас өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаа явуулахыг хориглож, зохих үүрэг хүлээлгэж байна.
4.4. Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Үгүй	
4.5. Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Энэ хуулийн үйлчлэлд төрийн бус байгууллага буюу мэргэжлийн холбоод хамаарч байгаа бөгөөд мэргэжлийн холбоодоос өрсөлдөөнийг хязгаарлах үйл ажиллагаа явуулахыг хориглох юм.
5.1. Хувь хүнийг хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	
5.2. Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
5.3. Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Үгүй	
6.1. Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Үгүй	
6.2. Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Үгүй	
6.3. Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
6.4. Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
6.5. Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан захиргааны байгууллага буюу албан тушаалтанаас өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаа явуулахыг хориглож, зохих үүрэг хүлээлгэж байгаа тул их, дээд

7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	сургуулиудын үйл ажиллагаанд зохих хязгаарлалт тогтооно.	
7.1. Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	
7.2. Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Үгүй	
7.3. Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
7.4. Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
8. Соёл	Үгүй	
8.1. Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
8.2. Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	
8.3. Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Үгүй	

1.4 БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Агаар			
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	1.1. Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
	2.1. Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	
	2.2. Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
	2.3. Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	2.4. Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
	3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	

	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Үгүй	
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	
7. Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Үгүй	
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Үгүй	



## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Хавсралт-2

№	Зохицуулалт	Монгол улсын Өрсөлдөөний тухай хуулийн Өрсөлдөөний тухай хууль 2010	НҮБ-н модел хуулийн төсөл Өрсөлдөөний тухай хуулийн модел / Женива 2007/	Япон
1	Хэрэглэх хуулийн хэм хэмжээ			1.Хувийн монополийг хориглох тухай хууль /1947 он/ 2.Уг хуулийн 2.9 дэх хэсгийг үндэслэн Японы Шударга худалдааны хорооноос гаргасан мэдэгдэл
2	Хуулийн зорилт	1.1.Энэ хуулийн зорилт нь аж ахуй эрхлэгчийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлд ноёлох болон өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хориглон хязгаарлах, өрсөлдөөнийг зохицуулах байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	1. Аливаа аж ахуйн нэгж өөрийн зах зээлд эзлэх давамгай байдлыг урвуугаар ашиглах, нэгдэн нийлэх замаар дотоод болон гадаад худалдааны зах зээлийн өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөх гэрээ хэлцэл байгуулах, арга хэрэгсэл ашиглахыг таслан зогсооход энэхүү хуулийн зорилт оршино.	Энэхүү хууль нь хувийн монополчлол болон хууль бус худалдаа наймааг хязгаарлах, өөрөөр хэлбэл шударга бус худалдааны аргыг хориглох замаар бизнесийн давамгай байдлын хэт төвлөрлөөс урьдчилан сэргийлэх, нэгдэн нийлэх, хэлэлцэн тохирох зэрэг аргаар бүтээгдэхүүн, худалдаа, үнэ өртөг, ашиглах технологи зэргийг зүй бусаар хязгаарласан эсхүл тодорхой бизнесийн үйл ажиллагааг зүй бусаар хязгаарласан байдлыг арилган, шударга, чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, бизнес эрхлэгчдийн бүтээлч санааг гаргах, бизнесийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хөдөлмөр эрхлэлт болон үндэсний ашиг орлогын түвшинг нэмэгдүүлэх, жирийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах болон улс орны эдийн засгийг ардчилсан байдлаар эрүүлээр

3	Хамрах хүрээ	3.1.Энэ хуулийн үйлчлэлд аж ахуй эрхлэгч, төрийн, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага хамаарна.	2. Энэхүү хуулийн нь бүх төрлийн хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, иргэний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, оюуны өмчтэй холбоотой байгуулсан аливаа гэрээ хэлцэлд хамаарна. Гэвч аливаа тусгаар тогтносон улсын төрийн захиргааны байгууллагын шийдвэр, төрийн өөрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарахгүй.	хөгжин дэвших явдалд дэмжлэг үзүүлэх зорилттой. Япон улсад бүртгэлтэй, дотоодын аж ахуйн нэгжид хамаарална, мөн хуулийн этгээдийн гадаад худалдааны хэлцэлд хамаарна.
4	Зүй ёсны монополь	5.1.Тухайн бараа бүтээгдэхүүний зах зээлд нийлүүлэлт хийж байгаа нэг этгээд байхад л нийгмийн дундаж зардал хамгийн бага байх боломжтой зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй эрхлэгчийг зүй ёсны монополь байдалтай гэж үзнэ	байхгүй	Хувийн аж ахуйн нэгжийн зүй ёсны монополь зөвшөөрсөн зохицуулалт байхгүй

5	<p>Давамгай байдалтай аж ахуйн нэгжийг тогтоох</p>	<p>5.2.Тодорхой бүтээгдэхүүний зах зээлд дангаараа буюу бусад этгээдтэй хамтран, эсхүл харилцан хамаарал бүхий этгээд үйлдвэрлэл, борлуулалтын, эсхүл худалдан авалтын гуравны нэг буюу түүнээс дээш хувийг эзэлж байвал давамгай байдалтай аж ахуй эрхлэгч гэж үзнэ.</p>	<p>2.1.6 Нэг хуулийн этгээд дангаар эсхүл бусад хуулийн этгээдтэй хамтран тухайн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд нөлөөлөх чадвартай бол давамгай байдалтай аж ахуйн нэгж гэнэ.</p>	<p>Японд аж ахуй эрхлэгчийн давамгай байдлыг урьдчилан тогтоодоггүй. Хяналт шалгал хийх явцдаа зөрчлийг тогтоох үедээ тухайн зах зээлд эзлэх хувиар зах зээлийн давамгай байдлыг нь тодорхойлдог</p>
6	<p>нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад компанийн хувьцааг худалдан авах, хувьцааг бусдад бэлэглэх, шилжүүлэх болон удирдлагын үүргийг хавсран гүйцэтгэх</p>	<p>8.1.Давамгай хуулийн этгээд бусад этгээдтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, эсхүл ижил төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулдаг өрсөлдөгч компанийн энгийн хувьцааны 20-оос дээш, давуу эрхийн хувьцааны 15-аас дээш хувийг худалдан авах, эсхүл харилцан хамаарал бүхий этгээдтэй</p>	<p>6.1Доорхи тохиололд хэвтээ болон босоо эсэхээс үл хамааран аливаа хуулийн этгээд нэгдэх, нийлэх, хувьцааг худалдан авах, хамтран ажиллах, болон бусад хэлбэрээр шилжүүлэх, удирдлагын албан тушаал давхар эрхлэх бол мэдээллэнэ. Үүнд: Хуулийн</p>	<p>Компанийн нэгдэл 15. Нэгдэн нийлэх компанийн нэгнийх нь дотоод дахь борлуулалтын дүн 20 тэрбум иенээс дээш, нөгөө компанийх 5 тэрбум иенээс дээш байх тохиолдолд нэгдэх хүсэлт гаргана. Хувьцаа эзэмших 10. Дотоод дахь борлуулалтын дүн 20 тэрбум иенээс дээш компани, хувьцаа гаргагч компани болон түүний охин компанийн дотоод дахь</p>

	<p>нэгдэх, нийлэх тохиолдолд Шударга хэрэглэгчийн төлөө газарт өргөдөл гаргана.</p>	<p>этгээдийн аль нэг нь дотоодын хуулийн этгээд бөгөөд Үүсэх хуулийн этгээд нь тухайн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд зах зээлд давамгайл байдал бий болох, ялангуяа тухайн зах зээлд нэвтрэх саад өндөр, орлох бүтээгдэхүүн байхгүй бол өргөдөл гаргана.</p> <p>6.2 Доорхи тохиолдолд хэвтээ болон босоо эсэхээс үл хамааран аливаа хуулийн этгээд нэгдэх, нийлэх, хувьцааг худалдан авах, хамтран ажиллах, болон бусад хэлбэрээр шилжүүлэх, удирдлагын албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.</p>	<p>борлуулалтын нийт дүн 5 тэрбум иенээс Дээш, саналын эрхтэй хувьцааны эзэмших хувь 20% мөн 50%-иас давсан тохиолдолд хүсэлт гаргана.</p>
	<p>Уүнд: 1. Үүсэх хуулийн этгээд нь тухайн зах зээлд өөрийн давамгайл байдлыг ашиглаж чадах хүчин чадалтай болох бөгөөд - жишээ нь өөрчлөлтийн үр дүнд аж ахуйн нэгж, эсхүл хэд хэдэн аж ахуйн нэгж хамтран барааны үнийг зах зээлийн өрсөлдөөнт үнээс дээгүүр удаан хугацаагаар тогтоож болох хүчин чадалтай байх.</p> <p>2. Тухайн бараа үйлчилгээний хувьд давамгайл байдал зах зээлд үүсэж, өрсөлдөгчийн тоо буурахаар бол</p>		

7	Хяналт шалгалт хийх үндэслэл	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.1.Хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага /цаашид "хяналт шалгалтын байгууллага" гэх/ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хяналт шалгалтыг хийх бөгөөд хяналт шалгалтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн гэж ангилна.	5 дугаар бүлэг 1 дүгээр зүйл Энэхүү хуулийн 3, 4 дүгээр зүйлд хамаарал бүхий этгээд нь хуульд заасан үндэслэл, нөхцөл байдал бий болоход Өрсөлдөөний хороонд тухай бүр албан ёсны мэдэгдэл хүргүүлнэ.	1.Эрх мэдлийн хүрээнд хийх хянан шалгалт /Хуулийн 45.4/ 2. Энгийн иргэдээс гаргасан гомдлын дагуу хийх хянан шалгалт /Хуулийн 45.1/ 3. Хууль зөрсөн үйлдлээ сайн дураараа илчилсэн этгээдийн торгуулийн хэмжээг бууруулах тогтолцооны хүрээнд хийх хянан шалгалт / Хуулийн 7.2.10-7.2.13/ 4. Жижиг дунд аж ахуйн нэгжүүдийн холбооноос гаргасан нэхэмжлэлийн дагуу хийх хянан шалгалт / Жижиг дунд аж ахуйн нэгжүүдийн холбооны тухай хуулийн 4.7/
8	Хяналт шалгалтын эцсийн шийдвэр гаргах субъект	Улсын байцаагч Шүүхийн байгууллага	Хорооны шийдвэр Шүүхийн байгууллага	Шударга худалдааны хороо Шүүхийн байгууллага
9	Хуулийн этгээдийг хуваах тусгаарлах	10.1.Ноёлох үйл ажиллагааг нэг жилд хоёр ба түүнээс дээш удаа явуулж хуулийн хариуцлага хүлээж байсан ч дахин ийм үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдвол тухайн давамгай байдалтай хуулийн этгээдийг хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас гаргасан нэхэмжлэлийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.	Байхгүй	
10	Шударга худалдааны ажиллагаа /картел/-г хориглох	Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлд "Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн Дараах үйл ажиллагааг хориглохоор заасан байна.	3 дугаар бүлэг 1-р зүйл А. Үнийг урьдчилан тогтоосон аливаа хэлцэл, гадаад худалдааны хэлцэл	Хуулийн 3-р зүйл. Аж ахуй эрхлэгч нь, хувийн монополчлол болон хууль бусаар худалдаа наймааг хязгаарлах үйл ажиллагаа явуулж болохгүй.

	<p>12.1.1.Аж ахуй эрхлэгч өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p> <p>12.1.1.өрсөлдөгчийн түүний бараа бүтээгдэхүүний нэр хүндийг гутаах, эсхүл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараах;</p> <p>12.1.2.өөрийн бараа бүтээгдэхүүний талаар худал, зөрүүтэй мэдээлэх, эсхүл үнэн байдлыг гуйвуулах зэргээр бусдыг төөрөгдүүлэх;</p> <p>12.1.3.өрсөлдөөнд харш үр дагавар үзүүлэх зар сурталчилгаа явуулах;</p> <p>12.1.4.бусдын барааны тэмдэг, шошго, аж ахуй эрхлэгчийн нэр, барааны чанарын баталгааг дур мэдэн хэрэглэх, барааны оноосон нэр, баглаа боодлыг хуулбарлах;</p> <p>12.1.5.патент зохиогчийн зөвшөөрөлгүйгээр шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэл, худалдааны мэдээлэл, нууцыг худалдах, нийтлэх, бусдад тараах;</p>	<p>Б. Урьдчилан шалгарлуулсан тендер зардал, В. Зах зээлийн байршил заах, худалдан авагчийг зааглах, Г. Үйлдвэрлэлийн тоо хэмжээ, борлуулалтыг хязгаарласан гэрээ байгуулах, Д. Үгсэн хуваалдаж Худалдан авалт хийхээс хамтаар татгалзах, Е. үгсэн хуйвалдаж нийлүүлэлт хийхээс хамтаар татгалзах, Ё. Өрсөлдөөнд чухал ач холбогдол бүхий холбоонд нэгдэн орох, бусад өрсөлдөх арга хэрэгсэлийг ашиглах боломжийг хязгаарлах</p>	<p>6 дугаар зүйл Аж ахуй эрхлэгч нь хууль бусаар худалдаа наймааг хязгаарлах эсхүл Шударга бус худалдааны аргад хамаарах дараах агуулга бүхий олон улсын хэлэлцээр болон олон улсын гэрээ байгуулахыг хориглоно. 3 дугаар бүлэг Аж ахуй эрхлэгчдийн холбоо 8 дугаар зүйл Аж ахуй эрхлэгчдийн холбоо нь дараах хэсэгт заасан үйл ажиллагаа явуулахыг хориглоно. 5 дахь хэсэг аж ахуй эрхлэгчээр шударга бус худалдааны аргад хамаарах үйл ажиллагаа эрхлүүлэх. 5 дугаар бүлэг Шударга бус худалдааны арга 19 дүгээр зүйл Аж ахуй эрхлэгч нь шударга бус худалдааны арга хэрэглэхийг хориглоно. 2 дугаар зүйлийн 9 дэх хэсэг Энэ хуульд заасан "Шударга бус худалдааны арга" гэдэгт дараах заалтуудын аль нэгт хамаарах үйлдлийг ойлгоно. 1.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр өрсөлдөгчтэйгээ хамтран, дараах үйлдлүүдийн аль нэгтэй ижил үйлдэл хийсэн байх. И. Аливаа аж ахуйн эрхлэгчид бараа бүтээгдэхүүн нийлүүлэхээс татгалзах, нийлүүлж буй бараа бүтээгдэхүүн эсхүл үйлчилгээнийхээ тоо хэмжээ, агуулгыг хязгаарлах</p>
--	---	--	--

<p>12.1.6.барааны чанарын доголдол, хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюултай шинж чанарыг нуун дарагдуулах;</p> <p>12.1.7.өөрийн бараа бүтээгдэхүүнийг борлуулахдаа өрсөлдөгчийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авахуулахгүй байх болзол тулгах;</p> <p>12.1.8.тухайн бараа бүтээгдэхүүний борлуулалтад урамшуулал, хямдрал байгаа гэсэн хуурамч мэдээлэл түгээх, эсхүл уг урамшууллыг аль нэг этгээдэд өгөхөөр урьдаас тохиролцож зориуд хуурамчаар зохион байгуулах;</p> <p>12.1.9.уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаа болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцохдоо өрсөлдөгчөө тухайн үйл ажиллагааны бодит нөхцөлөөс теерэгдүүлэх, тэдэнд дарамт, шахалт үзүүлэх;</p> <p>12.1.10.хууль ёсны ашиг сонирхолд харшлах болон</p>	<p>Р.О.Аливаа аж ахуй эрхлэгчийг бусад аж ахуй эрхлэгчид бараа бүтээгдэхүүн нийлүүлэхээс татгалзуулах, нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний эсхүл үйлчилгээний тоо хэмжээ, агуулгыг хязгаарлуулах</p> <p>2.Шударга бусаар, газар нутаг эсхүл нөгөө талаас шалтгаалан ялгаатай үнээр, бараа бүтээгдэхүүн эсхүл үйлчилгээг үргэлжлүүлэн нийлүүлж бусад аж ахуйэрхлэгчдийн үйл ажиллагаанд бэрхшээл учруулж болзошгүй үйлдэл хийх</p> <p>3.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, бараа бүтээгдэхүүн эсхүл үйлчилгээг тэдгээрийн нийлүүлэлтийн зардлаас бага үнээр үргэлжлүүлэн нийлүүлж, бусад аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаанд бэрхшээл учруулж болзошгүй үйлдэл хийх</p> <p>4.Өөрийнх нь барааг худалдан авч буй нөгөө талдаа, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, дараах нөхцлүүдийн аль нэгт хамаарах нөхцөл тулган, өөрийн бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх</p> <p>И. Нөгөө талын худалдаж буй бараа бүтээгдэхүүний үнийг тогтоон өгч, үүнийгээ хүлээн зөвшөөрүүлснээр нөгөө талынхаа худалдаж буй бараа бүтээгдэхүүнийхээ үнийг чөлөөтэй шийдвэрлэхийг нь хязгаарлах</p> <p>Р.О. Нөгөө талын худалдсан бараа бүтээгдэхүүнийг худалдаж авсан аж ахуй эрхлэгчийн тухайн бараа</p>
---	---

	<p>хэрэглэгчийг хууль бусаар          хохироох худалдааны арга          хэрэглэх.</p>	<p>бүтээгдэхүүнийг цааш худалдах          үнийг тогтоон өгч, нөгөө талаар          тухайн бараа бүтээгдэхүүний          худалдан авч буй аж ахуй эрхлэгчид          энэ нөхцлөө тулгуулах, үүнээс гадна          нөгөө талаар бусад аж ахуй          эрхлэгчийн худалдан авч буй бараа          бүтээгдэхүүнийхээ үнийг чөлөөтэй          шийдвэрлэх эрхийг хязгаарлуулах          5.Өөрийн худалдах худалдан авах          харилцаанд нөгөө талаас давамгай          байдалтай байгаагаа ашиглан,          жирийн худалдааны ёсонд          нийцэхгүйгээр шударга бусаар,          дараах үйлдлийн аль нэгийг хийх.          И.Цаашид урт хугацааны худалдаа          хийх нөгөө талдаа (шинээр цаашид          урт хугацааны худалдаа хийх гэж          байгаа нөгөө талыг мөн ойлгоно)          худалдаж буй бараа бүтээгдэхүүн          болон үйлчилгээг өөр бараа          бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх.          Рo.Цаашид урт хугацааны худалдаа          хийх нөгөө талаар, өөрт ашигтай          мөнгө, аливаа үйлчилгээ болон          бусад эдийн засгийн ач          холбогдолтой зүйлийг санал          болгуулах          Вa. Худалдааны харилцаанд буй          нөгөө талын арилжиж буй бараа          бүтээгдэхүүнийг хүлээн авахаас          татгалзах, нөгөө талаас тухайн          худалдааны зүйл болох бараа          бүтээгдэхүүнийг хүлээн авсны дараа          тухайн бараа бүтээгдэхүүнийг нөгөө          талаар эргүүлэн татуулах,</p>
--	---	--



			<p>худалдааны нөгөө талдаа худалдааны үнийг төлөхөөс хожимдуулах, эсхүл телберийн хэмжээг багасгах, түүнээс гадна нөгөө талд ашиггүй худалдааны нөхцлийг тогтоох, өөрчлөх, эсхүл хэрэгжүүлэх.</p> <p>Б.Дээрх заалтуудад хамаарах зүйлээс гадна, шударга өрсөлдөөнд хохирол учруулах эрсдэлтэй гэж үзэн Шударга худалдааны хорооноос тогтоосон дараах нөхцлүүдийн аль нэг</p> <p>И. Шударга бусаар бусад бизнес эрхлэгчдийг ялгаварлан гадуурхах</p> <p>Ро. Шударга бус үнээр худалдаа хийх</p> <p>Ва.Шударга бусаар өрсөлдөгчийнхөө харилцагчийг өөртэйгээ худалдаа хийлгүүлэхээр татах, эсхүл хүчлэх</p> <p>Ни. Нөгөө талынхаа бизнесийн үйл ажиллагааг шударга бусаар хязгаарлах нөхцлөөр худалдаа хийх,</p> <p>Хо. Өөрийн давамгай байдлаа шударга бусаар ашиглан, нөгөө талтайгаа худалдаа хийх</p> <p>Хэ. Нөгөө талыгаа Өөрийн эсхүл өөрийн хувьцаа эзэмшдэг компани эсхүл өөрийнх нь ажилладаг компанитай улс дотроо өрсөлдөөний харилцаатай байдаг бусад бизнес эрхлэгчтэй худалдаа хийхэд хөндлөнгөөс оролцох тухайн бизнес эрхлэгч нь компани байгаа тохиолдолд, тухайн компанийн</p>
--	--	--	--

<p>хувьцаа эзэмшигч, ажилтаныг тухайн компанид ашиггүй байх үйлдэл хийлгүүлэхээр нөлөөлөх, хатгах, хүчлэх.</p>			
<p>Шударга худалдааны хорооны зохицуулалт</p>			
<p>Нийтлэг зохицуулалт: Шударга худалдааны хороо нь "Шударга бус худалдааны арга" –ыг тогтоосон мэдэгдэл (Шова 57.06.18-ны Шударга худалдааны хорооны 15 дахь мэдэгдэл)-ээр дараах үйлдлүүдийг шударга бус худалдааны арга гэж үзсэн байдаг. Эдгээр нь бүх төрлийн бизнест хамааралтай ойлголт бөгөөд нийтлэг зохицуулалт гэж нэрлэдэг.</p>			
<p>1.Хамтран худалдаа хийхээс татгалзах</p>			
<p>2.Бусад худалдаа хийхээс татгалзах</p>			
<p>3.Ялгаварласан үнэ</p>			
<p>4.Худалдааны</p>			
<p>ялгавартайгаар хэрэглэх</p>			
<p>5.Бизнес эрхлэгч</p>			
<p>шалтгаалан</p>			
<p>хэрэглэх г.м</p>			
<p>6.Шударга бус хямд үнэ тогтоох</p>			
<p>7.Шударга бус өндөр үнэ тогтоох</p>			
<p>8. Хэрэглэгчдийг</p>			
<p>мэхлэсэн худалдаа</p>			
<p>9.Шударга бус аргаар хэрэглэгчдийг</p>			
<p>татах</p>			
<p>10.Боогдуулсан худалдаа г.м</p>			

					<p>11.Хязгаарласан худалдаа нөхцөлтэй</p> <p>12.Тулгасан нөхцөлтэй худалдаа</p> <p>13.Худалдааны нөгөө талаа ажилтнаа томилоход нь хөндлөнгөөс оролцох</p> <p>14.Өрсөлдөгчийнхөө худалдаанд хөндлөнгөөс оролцох</p> <p>15.Өрсөлдөгч компанийнхаа дотоод явдалд хөндлөнгөөс оролцох</p> <p><b>Тусгай зохицуулалт:</b> Бүх төрлийн бизнес эрхлэгчид хамааралтай бизнес эрхлэгчид зохицуулалтаас гадна, тусгай төрлийн бизнес эрхлэгчид хамаарах шударга бус худалдааны аргуудыг тусгасан зохицуулалт байдаг бөгөөд үүнийг тусгай зохицуулалт гэнэ. Тусгай зохицуулалтад дараах ойлголтуудыг хамааруулдаг. Үүгээр хязгаарлагдахгүй</p> <p>1.Лаазласан болон лонхонд хийсэн хунсний үйлдвэрлэл дэх шударга бус худалдааны арга</p> <p>2.Өргөн хүрээнд жижиглэнгийн бараа худалдагчтай нийлүүлэгч худалдаа хийхэд гардаг шударга бус худалдааны арга</p> <p>3.Сонин эрхлэгчдэд хамаарах шударга бус худалдааны арга /сонин тусгай зохицуулалт/</p> <p>4.Сургуульд ашиглагдах номын үйлдвэрлэл дэх шударга бус худалдааны арга</p> <p>5.Бараа нийлүүлэгчийн бараа бүтээгдэхүүнээ нийлүүлэх эсхүл</p>
--	--	--	--	--	--

11	Төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах	13 Дугаар зүйлд заасан үйл ажиллагааг хориглохоор заасан	Төрийн өмчит, болон төрийн өмчийн оролцоот аж ахуйн нэгжид хамааралгүй.	хадгалах явц дахь шударга бус худалдааны арга Төрийн өмчит, болон төрийн өмчийн оролцоот аж ахуйн нэгжид хамааралгүй.
12	Байгууллагын харьяалал	14.2.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дүрмийг Засгийн газар батална. 14.7.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар үйл ажиллагаагаа жил бүр Засгийн газарт тайлагнана.	Улс бүр өөрийн онцлолт тохируулан байгууллагын харьяалалыг тогтоох зохицуулалтыг зөвлөсөн.	Засгийн газрын агентлаг, засгийн газрын тэргүүнд тайлагнадаг хэрэгжүүлэгч
13	Хариуцлага	27.1.1, 27.1.2, 27.1.3, 27.1.4-д аж ахуйн эрхлэгчийн тухайн бараа бүтээгдэхүүний орлогоос хувь хэмжээгээр торгууль ногдуулдаг зохицуулалттай.	11 дүгээр зүйл Хууль зөрчигч аж ахуйн нэгж, хувь хүнд хуулийн ямар зөрчил гаргаснаас шалтгаалан торгууль ногдуулах /хууль бус үйл ажиллагаанаас олсон хувь бус орлогыг бууруулах зорилт агуулах/, хорих ялаар шийтгэх /хувь хүн зорилготойгоор хууль зөрчсөн үйлдэл хийсэн, эсхүл хорооноос гаргасан шийдвэрийг биелүүлээгүй бол, ноцтой тохиолдолд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг бүр болон тодорхой хугацаагаар зогсоох, нийтээс албан ёсоор уйчлалт гуйх, нийтэд хууль зөрчсөн үйлдлийн талаар мэдээлэх	Шийтгэлийн төрлүүд: •Анхааруулга өгөх /Хянан шалгах дүрмийн 26.1/ •Үйл ажиллагаа явуулахыг хориглох /Хуулийн 7.1, 7.2, 8.2.1-8.2.3, 17.2.1, 17.2.2, 20.1, 20.2/ •Торгууль ногдуулах /7.2.1, 7.2.2, 7.2.4, 8.3, 20.2-20.6/ •Яаралтай тохиолдолд тодорхой хугацаагаар үйл ажиллагааг нь зогсоох /Хуулийн 70.4.1/ •Эрүүгийн ял ногдуулах /101-106/  Хуулийн 2.9.1-2.9.5-д заасан шударга худалдааны аргыг зөрчсөн үйлдэлд ногдуулах торгуулийн хэмжээ:  •Хуулийн 20.2-т заасны дагуу уг хуулийн 2.9.1-т заасан зөрчил гаргасан этгээд нь үйлдвэрлэгч бол

	<p>         зөрчил гаргаж эхэлсэн өдрөөс          зөрчил дуусгавар болсон өдрийг          хүртэлх холбогдох бараа          бүтээгдэхүүн, аж үйлчилгээний          борлуулалтын үнийн дүнгийн 3 хувь,          жижиг дунд худалдаа эрхлэгч бол 2          хувь, бөөний худалдаа эрхлэгч бол 1          хувьтай тэнцэх торгууль тус тус          ногдуулна. Зөрчлийн үргэлжлэх          хугацаа 3 жилээс илүү гарсан          тохиолдолд сүүлийн 3 жилийн          холбогдох бүтээгдэхүүн, аж          үйлчилгээний борлуулалтын үнийн          дүнгээс тооцно. Торгуулийн хэмжээ          1 сая иенээс бага байгаа          тохиолдолд Шударга худалдааны          хороо нь торгууль ногдуулахгүй.          •Хуулийн 20.3-т заасны дагуу уг          хуулийн 2.9.2-т заасан зөрчил          гаргасан этгээд нь үйлдвэрлэгч бол          зөрчил гаргаж эхэлсэн өдрөөс          зөрчил дуусгавар болсон өдрийг          хүртэлх холбогдох бараа          бүтээгдэхүүн, аж үйлчилгээний          борлуулалтын үнийн дүнгийн 3 хувь,          жижиг дунд худалдаа эрхлэгч бол 2          хувь, бөөний худалдаа эрхлэгч бол 1          хувьтай тэнцэх торгууль тус тус          ногдуулна. Зөрчлийн үргэлжлэх          хугацаа 3 жилээс илүү гарсан          тохиолдолд сүүлийн 3 жилийн          холбогдох бүтээгдэхүүн, аж          үйлчилгээний борлуулалтын үнийн          дүнгээс тооцно. Торгуулийн хэмжээ          1 сая иенээс бага байгаа       </p>
--	---

тохиолдолд Шударга худалдааны хороо нь торгууль ногдуулахгүй.  
 •Хуулийн 20.4-т заасны дагуу уг хуулийн 2.9.3-т заасан зөрчил гаргасан этгээд нь үйлдвэрлэгч бол зөрчил гаргаж эхэлсэн өдрөөс зөрчил дуусгавар болсон өдрийг хүртэлх холбогдох бараа бүтээгдэхүүн, аж үйлчилгээний борлуулалтын үнийн дүнгийн 3 хувь, жижиг дунд худалдаа эрхлэгч бол 2 хувь, бөөний худалдаа эрхлэгч бол 1 хувьтай тэнцэх торгууль тус тус ногдуулна. Зөрчлийн үргэлжлэх хугацаа 3 жилээс илүү гарсан тохиолдолд сүүлийн 3 жилийн холбогдох бүтээгдэхүүн, аж үйлчилгээний борлуулалтын үнийн дүнгээс тооцно. Торгуулийн хэмжээ 1 сая иенээс бага байгаа тохиолдолд Шударга худалдааны хороо нь торгууль ногдуулахгүй.  
 •Хуулийн 20.5-д заасны дагуу уг хуулийн 2.9.4-т заасан зөрчил гаргасан этгээд нь үйлдвэрлэгч бол зөрчил гаргаж эхэлсэн өдрөөс зөрчил дуусгавар болсон өдрийг хүртэлх холбогдох бараа бүтээгдэхүүн, аж үйлчилгээний борлуулалтын үнийн дүнгийн 3 хувь, жижиг дунд худалдаа эрхлэгч бол 2 хувь, бөөний худалдаа эрхлэгч бол 1 хувьтай тэнцэх торгууль тус тус ногдуулна. Зөрчлийн үргэлжлэх хугацаа 3 жилээс илүү гарсан тохиолдолд сүүлийн 3 жилийн

холбогдох бүтээгдэхүүн, аж үйлчилгээний борлуулалтын үнийн дүнгээс тооцно. Торгуулийн хэмжээ 1 сая иенээс бага байгаа тохиолдолд Шударга худалдааны хороо нь торгууль ногдуулахгүй.

•Хуулийн 20.6-д заасны дагуу уг хуулийн 2.9.5-т заасан зөрчил гаргасан этгээд нь үйлдвэрлэгч бол зөрчил гаргаж эхэлсэн өдрөөс зөрчил дуусгавар болсон өдрийг хүртэлх холбогдох бараа бүтээгдэхүүн, аж үйлчилгээний борлуулалтын үнийн дүнгийн 1хувь хувьтай тэнцэх торгууль ногдуулна. Зөрчлийн үргэлжлэх хугацаа 3 жилээс илүү гарсан тохиолдолд сүүлийн 3 жилийн холбогдох бүтээгдэхүүн, аж үйлчилгээний борлуулалтын үнийн дүнгээс тооцно. Торгуулийн хэмжээ 1 сая иенээс бага байгаа тохиолдолд Шударга худалдааны хороо нь торгууль ногдуулахгүй.

Эрүүгийн ялын хэмжээ:

89 дүгээр зүйл  
 Хувийн монополлол, зүй бусаар худалдааг хязгаарлах, аж ахуй эрхлэгчдийн холбооноос өрсөлдөөнд бодитоор хохирол учруулсан зөрчилд 5 хүртэлх жилийн ажил хийлгүүлэн хорих ял эсхүл 5 сая хүртэлх иений торгууль 90 дүгээр зүйл

				<p>Олон улсын хэлэлцээ г.м-ийг үйлдсэн, аж ахуй эрхлэгчдийн холбоонд хориглосон үйл ажиллагаа эрхэлсэн, тодорхой үйл ажиллагааг зогсоосон захирамжийг зөрчсөн эсхүл өрсөлдөөнийг сэргээн тохинуулсан захирамжийг зөрчсөн тохиолдолд 2 хүртэлх жилийн ажил хийлгүүлэн хорих ял эсхүл 3 сая хүртэлх иений торгууль 91 дүгээр зүйл</p>
--	--	--	--	---

---000---



---

**“ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР  
НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН**

# ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН

## НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж байгаа бэрхшээлийг шийдвэрлэх, орхигдуулсан зарим зохицуулалтыг бий болгох зэргээр өөрчлөн сайжруулах зорилгоор нийт 5 бүлэг, 31 зүйлтэйгээр боловсруулсан байх бөгөөд хуулийн төслийн бүтцийг авч үзвэл:

Нэгдүгээр бүлэг:	Нийтлэг үндэслэл
Хоёрдугаар бүлэг:	Өрсөлдөөний зохицуулалт
Гуравдугаар бүлэг:	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хорооны эрх зүйн байдал
Дөрөвдүгээр бүлэг:	Зөрчил шалгах ажиллагааны бусад харилцаа
Тавдугаар бүлэг:	Бусад зүйл

Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал" /цаашид "аргачлал" гэх/-д заасны дагуу дараахь үе шаттайгаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

## ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Практикт хэрэгжих боломж
4. Харилцан уялдаа зэрэг болно.

"Зорилгод хүрэх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл,

шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэллээ.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

**“Практикт хэрэгжих боломж”** шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтооход туршилтын ажиллагааг явуулах цаг хугацааны боломж хомс байсан боловч хэлэлцүүлэг, судалгааны ажлуудаас гаргасан санал, зөвлөмжийг ашиглах замаар үнэлэх боломжтой гэж үзэн сонголоо.

**“Хүлээн зөвшөөрөгдөх байдал”** Хуулийн төсөл эцэслэн боловсруулагдаж холбогдох этгээдүүдээс санал авах үед аргачлалд заасны дагуу уг шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн холбогдох заалтуудыг үзэх боломжтой байх тул энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдэд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

**“Зардал”** шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тусад нь тооцохоор шийдвэрлэсэн тул энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгох шаардлагагүй гэж үзэв.

**“Харилцан уялдаа”** шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Үндсэн хууль холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

## **ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

Энэхүү хэсэгт Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгов. Эдгээр зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдолтой, мөн анхаарах шаардлагатай заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл, тус хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ товч бөгөөд оновчтой байх үүднээс хуулийн төслөөс шинэлэг зохицуулалт бий болгож буй, агуулгын хувьд чухал ач холбогдолтой, мөн асуудалтай, анхаарах шаардлагатай заалтуудыг сонгож, тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судаллаа. Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцохоор сонгосон хэсгээ шалгуур үзүүлэлт тус бүрээр авч үзэв.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилт, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ. Хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар:

№	Хуулийн төслийн хэрэгцээ шаардлага /хуулийн төслийн үзэл баримтлалаас/	Хуулийн төслийн зүйл, заалт
1	Олон улсын жишигт төдийгүй Монгол улсад хамтын удирдлагын зарчмаар ажилладаг байгууллагууд нь хороо, комисс гэсэн статустай байдаг. Мөн Өрсөлдөөний тухай хуульд өрсөлдөөний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан байдаг ч орон нутагт салбар нэгж байхгүйн улмаас хуулийн хэрэгжилт сул байдаг. Тиймээс өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагын оноосон нэрийг Хороо байхаар, орон нутагт салбар нэгжтэй байхаар зохицуулах	14.1.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороо /цаашид “Хороо” гэх/ нь Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, өрсөлдөөний талаар баримтлах бодлогыг тодорхойлж улсын хэмжээнд хэрэгжүүлэх, өрсөлдөөнийг хамгаалах, зохицуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн. 14.4.Хороонд улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана. Орон нутагт Хорооны салбар нэгж ажиллах бөгөөд салбар нэгжид улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана.
2	Зөрчлийг хянан шалгах, хянан шийдвэрлэх эрх бүхий субъектийг зааглан, улсын байцаагч шийдвэр гаргадаг тогтолцоог халж хамтын удирдлагын зарчмаар эцсийн шийдвэрийг гаргадаг тогтолцоог бий болгох	15.1.Хороо чиг үүргийнхээ дагуу дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.1.4.өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуй эрхлэгч, байгууллагад хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг шалган шийдвэрлэх, 24.2.1.өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах, зөрчил шалгах болон хяналт шалгалт хийх саналаа Хорооны даргад тавьж шийдвэрлүүлэх, ...
3	Зах зээлд давамгайл байдалтай гэх аж ахуй эрхлэгчийг урьдчилсан байдлаар тогтоож байгаа нь учир дутагдалтай буюу зах зээлд оролцогчдын нөхцөл байдал байнга өөрчлөгддөгтэй холбогдуулан бодит нөхцөл байдалд нийцдэггүй байна. Тиймээс зөрчлийг хянан шийдвэрлэхэд тухайн аж ахуй эрхлэгчийг холбогдох зах зээлд давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчээр урьдчилан тогтоосон байхыг шаардахгүйгээр зөрчлийг шалгах явцдаа уг зөрчил үйлдэгдсэн тухайн жилд тухайн аж ахуй эрхлэгч холбогдох зах зээлд давамгайл байдалтай байсан эсэхийг тогтоох	7.2.Энэ хуулийн 7.1.1-7.1.11-т заасныг зөрчсөн этгээдийн зөрчлийг шийдвэрлэхэд тухайн аж ахуй эрхлэгчийг холбогдох зах зээлд давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчээр урьдчилан тогтоосон байхыг шаардахгүй бөгөөд зөрчлийг шалгах явцдаа уг зөрчил үйлдэгдсэн тухайн жилд тухайн аж ахуй эрхлэгч холбогдох зах зээлд давамгайл байдалтай байсан эсэхийг тогтоосон байхад хангалттай гэж үзнэ.

4	<p>Практикт давамгайл байдалтай бус аж ахуй эрхлэгчид нэгдэн нийлсэн тохиолдолд зах зээл дээр хэт төвлөрөл бий болгох боломжтой байдаг. Тиймээс хуулийн этгээдийг давамгайл байдалтай эсэхээс үл хамааран нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж ахуй эрхлэгчийн хувьцааг худалдан авах тохиолдолд өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагад заавал мэдэгдэн дүгнэлт гаргуулж зөвшөөрөл авах</p>	<p>8.1.Аж ахуй эрхлэгч бусад аж ахуй эрхлэгчтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж ахуй эрхлэгчийн хувьцааг худалдан авсан үр дүнд Компанийн тухай хуульд заасан хяналтын багцыг эзэмших, эсхүл дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт хамгийн их энгийн хувьцаа эзэмших тохиолдолд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хорооноос урьдчилан зөвшөөрөл авна.</p>
5	<p>Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбоотой хууль хоорондын уялдааг хангах</p>	<p>Дөрөвдүгээр бүлэг.Зөрчил шалгах ажиллагааны бусад харилцаа /26, 27 дугаар зүйл/</p>

3.2. “Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл 5 бүлэг, 31 зүйлтэй./

3.3. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараахь зохицуулалтыг сонгон үзлээ.

*“8.1.Аж ахуй эрхлэгч бусад аж ахуй эрхлэгчтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж ахуй эрхлэгчийн хувьцааг худалдан авсан үр дүнд Компанийн тухай хуульд заасан хяналтын багцыг эзэмших, эсхүл дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт хамгийн их энгийн хувьцаа эзэмших тохиолдолд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хорооноос урьдчилан зөвшөөрөл авна.”*

*“14.1.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороо /цаашид “Хороо” гэх/ нь Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, өрсөлдөөний талаар баримтлах бодлогыг тодорхойлж улсын хэмжээнд хэрэгжүүлэх, өрсөлдөөнийг хамгаалах, зохицуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.”*

3.4. “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог тогтоохын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо. /Хуулийн төсөл 5 бүлэг, 31 зүйлтэй./

## **ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараахь байдлаар харуулав.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 14.1, 14.4 дэх хэсэг, 15.1.4, 15.1.9 дахь заалт, 7.2, 8.1, 8.4 дэх хэсэг, 26, 27 дугаар зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 8.1, 14.1 дэх хэсэг	Практикт тухайн төрлийн харилцаанд гарч болох хүндрэлийг судлах.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах.

#### 4.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

14.1. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороо /цаашид "Хороо" гэх/ нь Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, өрсөлдөөний талаар баримтлах бодлогыг тодорхойлж улсын хэмжээнд хэрэгжүүлэх, өрсөлдөөнийг хамгаалах, зохицуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.

Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл шаардлага нь өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг олон улсын жишигт нийцүүлэн хамтын удирдлагын зарчмаар хороо статустайгаар өөрчлөн байгуулах бөгөөд уг зорилтын дагуу хуулийн төслийн үзэл баримтлалд өрсөлдөөний асуудал эрхэлсэн байгууллагын шийдвэр гаргах тогтолцоог өөрчилж, хамтын удирдлагын зарчмаар эцсийн шийдвэрийг гаргадаг тогтолцоог бий болгох чиглэлээр хуулийн төсөл боловсруулахаар заасан.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллага нь "Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар" байсныг хуулийн төслийн 14.1-д "Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороо" болгон өөрчилснөөр хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл

олон улсын жишиг өрсөлдөөний байгууллагын хамтын удирдлагын зарчмаар ажиллах зорилгод нийцсэн байна. Гэхдээ практикт хэрэгжих боломжтой эсэхийг дараагийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд дахин авч үзэх болно.

15.1. Хороо чиг үүргийнхээ дагуу дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.4. өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуй эрхлэгч, байгууллагад хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг шалган шийдвэрлэх, .....

24.2.1. өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах, зөрчил шалгах болон хяналт шалгалт хийх саналаа Хорооны даргад тавьж шийдвэрлүүлэх, ...

Хуулийн төслийн 15.1.4, 15.1.9 дэх заалтууд нь зөрчлийг хянан шалгах, хянан шийдвэрлэх эрх бүхий субъектийг зааглан, улсын байцаагч шийдвэр гаргадаг тогтолцоог халж хамтын удирдлагын зарчмаар эцсийн шийдвэрийг гаргадаг тогтолцоог бий болгох хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын хүрээнд нь боловсруулагдсан байна. Тодруулбал, хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуулийн 20.2, 20.3, 15.1.16 дахь заалтад заасны дагуу улсын байцаагч хяналт шалгалт явуулж, шийдвэр гаргадаг, харин Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар улсын байцаагчийн шийдвэрт гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх зохицуулалттай байсныг хуулийн төслийн 15.1.4, 24.2.1 дэх заалтаар улсын байцаагч хянан шалгаж, Хороо шалган шийдвэрлэх чиг үүрэгтэй байхаар өөрчилсөн нь хамтын удирдлагын зарчмаар шийдвэр гаргадаг тогтолцоог бий болгох хуулийн төслийн зорилгод нийцэж байна. Гэхдээ хуульд нийцэж буй эсэхийг дараагийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд дахин авч үзэх болно.

7.2. Энэ хуулийн 7.1.1-7.1.11-т заасныг зөрчсөн этгээдийн зөрчлийг шийдвэрлэхэд тухайн аж ахуй эрхлэгчийг холбогдох зах зээлд давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр урьдчилан тогтоосон байхыг шаардахгүй бөгөөд зөрчлийг шалгах явцдаа уг зөрчил үйлдэгдсэн тухайн жилд тухайн аж ахуй эрхлэгч холбогдох зах зээлд давамгай байдалтай байсан эсэхийг тогтоосон байхад хангалттай гэж үзнэ.

Зах зээлд оролцогчдын нөхцөл байдал байнга өөрчлөгдөж байдаг тул давамгай байдалтай гэх аж ахуй эрхлэгчийг урьдчилсан байдлаар тогтоож байгаа нь учир дутагдалтай, бодит нөхцөл байдалд нийцдэггүй байна. Тиймээс хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуулийн 7.1-д давамгай байдалтай аж ахуй эрхлэгч ноёлох үйл ажиллагаа явуулахыг хориглож байсан бол шинэчилсэн найруулгын төсөлд аж ахуй эрхлэгч бүр давамгай байдлаа ашиглахыг хориглож, зөрчлийг хянан шийдвэрлэхэд тухайн аж ахуй эрхлэгчийг холбогдох зах зээлд давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр урьдчилан тогтоосон байхыг шаардахгүйгээр зөрчлийг шалгах явцдаа уг зөрчил үйлдэгдсэн тухайн жилд тухайн аж ахуй эрхлэгч холбогдох зах зээлд давамгай байдалтай байсан эсэхийг тогтоохоор зохицуулсан нь практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа зохицуулалтыг шийдвэрлэх хуулийн төслийн зорилготой нийцэж байна.

8.1. Аж ахуй эрхлэгч бусад аж ахуй эрхлэгчтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж ахуй эрхлэгчийн хувьцааг худалдан авсан үр дүнд Компанийн тухай хуульд заасан хяналтын багцыг эзэмших, эсхүл дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт хамгийн их энгийн хувьцаа эзэмших тохиолдолд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хорооноос урьдчилан зөвшөөрөл авна.

Шинэчилсэн найруулгын 8.1-д "зөвхөн давамгай байдалтай хуулийн этгээд" нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, хувьцаа худалдан авах тохиолдолд дүгнэлт гаргуулдаг байсныг өөрчилж, "бүх аж ахуй эрхлэгч" урьдчилан зөвшөөрөл авахаар зохицуулсан нь практикт давамгай байдалтай бус аж ахуй эрхлэгчид нэгдэн нийлсэн тохиолдолд зах зээл дээр хэт төвлөрөл бий болгохоос сэргийлэх хуулийн төсөл боловсруулах практик шаардлагад нийцсэн, өрсөлдөөнийг хамгаалах хуулийн төслийн зорилтыг хангахад чиглэгдсэн зохицуулалт болсон гэж үзэхээр байна. Хэдийгээр уг зохицуулалт нь хуулийн төслийн зорилготой нийцэж буй боловч практикт хэрэгжих боломж, хуулийг хэрэгжүүлэх байгууллага, бусад этгээдэд үзүүлэх нөлөөллийн талаар дараагийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд авч үзье.

#### 4.2. "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

8.1. Аж ахуй эрхлэгч бусад аж ахуй эрхлэгчтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж ахуй эрхлэгчийн хувьцааг худалдан авсан үр дүнд Компанийн тухай хуульд заасан хяналтын багцыг эзэмших, эсхүл дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт хамгийн их энгийн хувьцаа эзэмших тохиолдолд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хорооноос урьдчилан зөвшөөрөл авна.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Аж ахуй эрхлэгч бусад аж ахуй эрхлэгчтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж ахуй эрхлэгчийн хувьцааг худалдан авсан үр дүнд Компанийн тухай хуульд заасан хяналтын багцыг эзэмших, эсхүл дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт хамгийн их энгийн хувьцаа эзэмших тохиолдолд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хорооноос урьдчилан зөвшөөрөл авна." гэж заасан байна. Үүнд нэгдүгээрт, хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуулийн 8.1-д зөвхөн давамгай байдалтай хуулийн этгээдэд хамаарахаар заасныг бүх аж ахуй эрхлэгчид хамаарахаар өөрчилсөн нь жижиг, дунд бизнес эрхлэгчид хүндрэлтэй, цаг хугацаа, зардал шаардсан зохицуулалт гэж үзэхээр байна. Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.19-д "Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасган, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгана." гэж заасан. Хэдийгээр төр өрсөлдөөнийг хамгаалах, өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой боловч зохистой түвшинд, бодит зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлж иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдийн дунд зохих хяналтыг тогтоох нь зүйтэй байна. Энэ талаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тодорхой зааж, тусгай зөвшөөрлийн тоог бууруулахаар тусгасан байна.

Эсхүл уг заалт хамаарахгүй буюу үйлчлэхгүй байх нөхцөлүүдийг тусгайлан хуульчлах /Япон Улсын Монополийн эсрэг хуулийн 6 дугаар бүлгээс жишиг зохицуулалтыг харах/.

Хоёрдугаарт, хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуулийн 8.1-д "... эсхүл ижил төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулдаг өрсөлдөгч компанийн энгийн хувьцааны 20-оос дээш, давуу эрхийн хувьцааны 15-аас дээш хувийг худалдан авах ... тохиолдолд ..." гэж заасныг "... аж ахуй эрхлэгчийн хувьцааг худалдан авсан үр дүнд Компанийн тухай хуульд заасан хяналтын багцыг эзэмших ..." гэж өөрчилснөөр тухайн гэрээ, хэлцэлд тавих хяналтын хүрээг багасгасан гэж үзэхээр байна. Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д "Компанийн гаргасан энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг компанийн хувьцааны хяналтын багц гэнэ." гэж заасан бөгөөд үүнд компанийн 34 ба түүнээс дээш энгийн хувьцаа хамаарах юм. Энэ



тохиолдолд тухайн компанийн 20 хувийн энгийн хувьцааг худалдан авах тохиолдолд зөвшөөрөл авдаг байсныг 34 хувь болгон өсгөснөөр хяналтын хүрээг багасгаж байна. Түүнчлэн уг зохицуулалтаас давуу эрхийн хувьцаа худалдан авах нөхцөлийг хасах болсон үндэслэл, шалтгаан хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн урьдчилсан тандан судалгаанд тодорхойгүй байна. Тиймээс уг заалтыг практикт хэрэгжүүлэхэд бизнес эрхлэгчид, ялангуяа жижиг, дунд, гарааны бизнес эрхлэгчдэд хүндрэлтэй, тэдний эсэргүүцэлтэй тулгарах эрсдэлээс гадна уг чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллагын техник, боловсон хүчин, удирдлага, дотоод зохион байгуулалтын нөөц бололцоо зохистой хэмжээнд бүрдсэн байхыг шаардана.

14.1. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороо /цаашид "Хороо" гэх/ нь Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, өрсөлдөөний талаар баримтлах бодлогыг тодорхойлж улсын хэмжээнд хэрэгжүүлэх, өрсөлдөөнийг хамгаалах, зохицуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.

Хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын эрх зүйн статусыг хамтын удирдлагын зарчмаар ажиллах "хороо" болгон өөрчилж зохицуулсан байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд олон улсын жишигт төдийгүй Монгол Улсад хамтын удирдлагын зарчмаар ажилладаг байгууллагууд нь хороо, комисс гэсэн статустай байдаг бөгөөд жишээлбэл, Санхүүгийн зохицуулах хороо, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн үндэсний комисс байна гэж үзжээ. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар /Засгийн газрын тохируулагч агентлаг/-ыг дээрх байгууллагуудтай харьцуулах замаар хороо болгон өөрчлөн зохион байгуулах нь оновчтой эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэхийг дүгнэвэл:

Нэгдүгээрт, дээрх байгууллагууд нь Засгийн газраас бус Улсын Их Хурлаас байгуулагддаг, өөрөөр хэлбэл, хорооны дүрэм, хорооны дарга, гишүүдийг Улсын Их Хурлаас баталдаг, томилдог, огцруулдаг, чөлөөлдөг, үйл ажиллагаагаа Улсын Хуралд тайлагнадаг, хараат бус, бие даасан, эрх зүйн статус нь тусдаа хуулиар тодорхойлогддог байгууллагууд юм. Харин шинэчилсэн найруулгын төсөлд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хорооны дарга, гишүүдийг Засгийн газраас томилж, чөлөөлөхөөр, үйл ажиллагаагаа Засгийн газарт тайлагнахаар зохицуулсан байна.

Хоёрдугаарт, дээрх байгууллагууд нь хамтын удирдлагын зарчмаар ажилладаг боловч эрхлэн хариуцах асуудалтай холбоотойгоор шийдвэр гаргах процесс нь ялгаатай. Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хорооноос тавих хяналт шалгалтыг улсын байцаагч хэрэгжүүлж, хууль тогтоомжийн дагуу захиргааны шийтгэл ногдуулдаг /хянан шийдвэрлэсний үндсэн дээр/ бол тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих бүрэн эрхийг Хороонд олгосон байна. Харин шинэчилсэн найруулгын төсөлд өрсөлдөөний хуулийн зөрчлийг хянан шийдвэрлэх бүрэн эрхийг улсын байцаагч хэрэгжүүлдэг байсныг Хороо хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Гуравдугаарт, практикт хууль тогтоомжийн дагуу Засгийн газраас байгуулсан хорооны эрх зүйн байдлын талаар авч үзье. Тухайлбал, Эрчим хүчний тухай хуулийн дагуу Эрчим хүчний зохицуулах хороог Засгийн газар байгуулахаар заасан. Тус хуулиар хороо нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах, үнэ тарифыг тогтоох, эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох бүрэн эрхтэй

байхаар заасан бол эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эрчим хүчний тухай хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгохтой холбогдон гарсан маргааныг хянаж дүгнэлт гаргах эрхтэй байхаар уялдуулан зохицуулсан. Өөрөөр хэлбэл, хороо нь зөвхөн эрчим хүчний хууль тогтоомжийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулах чиг үүргийн хүрээнд хяналт тавих, харин салбарын бодлогын асуудлыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хэрэгжүүлэхээр заасан байна. Түүнчлэн тусгай зөвшөөрөлтэй холбоотой хорооны байцаагчийн гаргасан шийдвэрийг төрийн захиргааны төв байгууллага нь хянан хэлэлцэж шийдвэрлэхээр заасан нь захиргааны актыг дээд шатны захиргааны байгууллагад гомдол гаргах журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг хангасан зохицуулалт байна.

Түүнчлэн Харилцаа холбооны тухай хуулийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хороог Засгийн газар байгуулахаар заасан боловч харилцаа холбооны тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай байхаар хуульчилсан.

Нөгөөтэйгүүр, хорооны статустай ажилладаг гадаад улс орнуудын хууль тогтоомжийг харьцуулан судлахад, Япон Улсын Засгийн газрын тухай хууль<sup>1</sup>-ийн 3 дугаар зүйл болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын тухай хууль<sup>2</sup>-ийн 2 дугаар зүйлд зааснаар Засгийн газраас байгуулагдах байгууллагад яам, агентлаг, хороо хамаарах бөгөөд яам нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хороо болон агентлаг байгуулахаар заасан байна. Япон Улсын Засгийн газрын тухайд, яамны хариуцан хэрэгжүүлэх үйл ажиллагааны томоохон хэсэг буюу хүрээ, чиг үүргийг дагнан хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзвэл агентлаг байгуулах, харин сайдын шууд удирдлага, хяналтан дор үйл ажиллагаа явуулснаар тодорхой ажил, үйл ажиллагааны зорилгод саад учруулах, алдагдах байдал үүсэх магадлалтай тохиолдолд хороо байгуулан ажилладаг байна.<sup>3</sup>

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 1-д зааснаар Засгийн газар нь үйл ажиллагааныхаа зохих хүрээ, салбарт тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийг байгуулж болно. Төрийн захиргааны төв байгууллага эсхүл төрийн захиргааны байгууллагагүйгээр Засгийн газрын түвшинд “хороо” байгуулсан жишиг байхгүй байна.

Иймд хороо байгуулах тохиолдолд шударга өрсөлдөөний бодлогын асуудлыг Засгийн газар эсхүл уг асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хамааруулж, шударга өрсөлдөөнийг зохицуулах чиг үүргийг хороонд хуваарилан хуульчлах нь зүйтэй байна. Энэ тохиолдолд Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д өөрчлөлт оруулахаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах шаардлагатай.

Нөгөө талаас, тус байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангах шаардлагатай тохиолдолд хороог Улсын Их Хурлаас байгуулах нь зохистой байна.

<sup>1</sup> <http://www.cas.go.jp/jp/seisaku/hourei/data/ngo.pdf>

<sup>2</sup> <http://www.moleg.go.kr/english/korLawEng?pstSeq=54793&rctPstCnt=3&searchCondition=Ttl&searchKeyword=government+organization+act>

<sup>3</sup> [https://japan.kantei.go.jp/constitution\\_and\\_government/frame\\_all\\_02.html](https://japan.kantei.go.jp/constitution_and_government/frame_all_02.html)

4.3. "Ойлгомжтой байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгасан бөгөөд үүнд хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн зохицуулалттай нийцэж байгаа, давхардаж байгаа эсэхийг "харилцан уялдаа холбоо" шалгуур үзүүлэлтийн хүрээнд шалгасан болно.

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг сайжруулахад чиглэсэн санал дүгнэлт

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1	8.4.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороо зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хянаж зөвхөн <u>өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөл бүрдэнэ</u> гэж үзвэл татгалзсан дүгнэлт гаргана. Дүгнэлт гаргахтай холбогдох журмыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороо батална.	"Өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөл" гэдэгт юуг хамруулах нь тодорхойгүй байна. Тиймээс татгалзсан шийдвэртэй холбоотойгоор маргаан үүсэх эрсдэл өндөр. Маргаан үүссэн тохиолдол талууд өөрсдийн үзэмжээр хуулийн зохицуулалтыг тайлбарлах үр дагавартай.	Хүсэлтийг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг журмаар бус хуульд маш тодорхой тусгах.
2	11.2.Аж ахуй эрхлэгчдийн хоорондох дараахь гэрээ, хэлцэл нь өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн буюу <u>бүрдүүлж болзошгүй</u> нь тогтоогдсон бол хориглоно.	"бүрдүүлж болзошгүй" гэдэгт ямар нөхцөлийг хамруулан тогтоох нь тодорхойгүй байна. Түүнчлэн ийнхүү зөрчиж байгуулсан гэрээ, хэлцлийн үйлчлэлийн талаарх зохицуулалтыг орхигдуулсан байна.	Нөхцөлийг тодорхой болгох.  Зөрчиж байгуулсан гэрээ, хэлцлийн үйлчлэлийн талаар зохицуулах.
3	5.1.Өрсөлдөгч аж ахуй эрхлэгч нэвтрэн ороход <u>хууль, эдийн засаг, техник, технологийн аль нэгнийх нь хувьд боломжгүй, эсхүл хязгаарлагдмал зах зээлд дангаараа үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй эрхлэгчийг зүй ёсны монополь байдалтай гэж үзнэ.</u>	"зүй ёсны монополь байдалтай" аж ахуй эрхлэгчийг тодорхойлох шалгуурыг өөрчилсөн. "хууль"-ийн хувьд нэвтрэх боломжгүй зах зээл гэдэг нь ойлгомжгүй байна. Түүнчлэн "хязгаарлагдмал зах зээл" гэдэгт ямар нөхцөлийг хамруулах нь төсөлд тодорхой тусгагдаагүй байна.	"зүй ёсны монополь байдал", "хязгаарлагдмал зах зээл"-ийг тогтоох шалгуур үзүүлэлтийг хуульд тодорхой заах.
4	13.3.Засгийн газраас нийтийн ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдлыг хангах, үр ашигтай өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хорооны саналыг авч зарим төрлийн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлд тодорхой	"Засгийн газраас ... зарим төрлийн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлд тодорхой хугацаагаар <u>хязгаарлалт</u> хийж болно." гэж заасан бөгөөд хязгаарлалт гэдэгт ямар үйл ажиллагааг хамруулах нь тодорхойгүй. Мөн	Тусгай зөвшөөрөлд хязгаарлалт хийх тухай ойлголт Аж ахуйн үйл ажиллагааны тухай хуульд тодорхойгүй тул хуульд нийцүүлэх, мөн тодорхой хугацаа тогтоох.

	хугацаагаар хязгаарлалт хийж болно.	хязгаарлалтын хугацаа заагаагүй байна.	
5	<p>15.1.10.аж ахуй эрхлэгч, захиргааны байгууллага, албан тушаалтнаас ... <u>зөрчил шалган шийдвэрлэхэд</u> шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, санхүүгийн болон бусад баримт бичгийг үнэ төлбөргүй гаргуулан авах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах;</p> <p>15.1.12.мэргэжлийн хяналт шалгалтын болон бусад байгууллага, тэдгээрийн ажилтан, иргэнийг хяналт шалгалт, судалгаа, <u>зөрчил шалгах</u> ажилд татан оролцуулах;</p> <p>15.1.19.өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх, хяналт шалгалт хийх, <u>зөрчил шалган шийдвэрлэх</u> болон өрсөлдөөнтэй холбоотой асуудлаар гадаад улсын болон олон улсын ижил төстэй байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;</p>	Хуулийн төслөөр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг журамласан нь тухайн хуулиар зохицуулах харилцааны хүрээнээс хальсан нь Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалттай давхардал, хийдэл, зөрчил үүсгэж байна	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нийцүүлж, "... зөрчил шалган шийдвэрлэх ...", "... зөрчил шалгах ..." хэсгийг зохицуулалтаас хасах.

#### 4.4. "Харилцан уялдаа" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд

№	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Нийцэж байна.
2	Хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Хуулийн төслийн 2.1-д заасан Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль нь Өрсөлдөөний тухай хуулиар зохицуулах харилцаанд хамаарах хуулиуд байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Нийцэж байна.

4	Хуулийн төслийн зүйл, заалт төслийн бусад заалттай нийцэж байгаа эсэх	<p>Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн гарчиг "... бусад аж ахуй эрхлэгчийг худалдан авах" гэсэн нь хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "аж ахуй эрхлэгч" гэж аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа ... хувь хүнийг" ойлгохоор заасантай нийцэхгүй байна. Аж ахуй эрхлэгч хувь хүнийг худалдан авах гэсэн ойлголт байхгүй тул "аж ахуй эрхлэгч хуулийн этгээдийн хувьцааг худалдан авах" гэж өөрчлөх.</p> <p>Нөгөөтэйгүүр, хувьцааг бэлэглэх, өвлүүлэх замаар нэг талын хэлцлээр хувьцаа шилжиж байгаа тохиолдолд уг зохицуулалт нэгэн адил үйлчлэх эсэх, үйлчлэх тохиолдолд зүйлийн гарчгийг "хувьцаа шилжүүлэх" гэсэн агуулгаар өөрчлөх.</p>
5	Хуулийн төслийн зүйл, заалт бусад хуулийн заалттай нийцсэн эсэх	<p>-Хуулийн төслийн 14.1-д "Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороо нь ... өрсөлдөөний талаар баримтлах бодлогыг тодорхойлж, улсын хэмжээнд хэрэгжүүлэх ..." гэж заасан нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна." гэж заасантай нийцэхгүй байх тул уг хэсгийг хасах.</p> <p>-Хуулийн төслийн 19 дүгээр зүйлд хорооны дарга, гишүүнийг огцруулах асуудлыг зохицуулсан байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6-д Улсын Их Хурал "Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах" онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан бөгөөд Засгийн газраас байгуулах байгууллагын бүрэлдэхүүнийг огцруулах асуудал үүнд хамаарахгүй. Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн уг заалтыг хасах.</p> <p>-Хуулийн төслийн 8.2, 10.1, 10.2 дахь заалт нь Үндсэн хуулийн 49.2, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 20.1 дэх хэсэгтэй нийцэхгүй байна.</p> <p>-Хуулийн төслийн 15.1.4, 15.1.14, 23.1, 24.2.1, 24.2.5 дахь заалт нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 2.4, 6.10, 6.11, 7.1 дүгээр зүйлд заасантай зөрчилдөж байна.</p> <p>-Хуулийн төслийн 15.1.9 дэх заалт нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106.3 дахь хэсгийг зөрчиж байна.</p> <p>-Хуулийн төслийн 15.1.23 дэх заалт нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10 дугаар зүйлийн 1.3, 8.2 дугаар зүйлийн 1.3-т заасныг зөрчиж байна.</p>

		-Хуулийн төслийн 11.5 дахь хэсэг нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэгтэй зөрчилдөж байна.
6	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Хуулийн төслийн 2.2-т Иргэний хуулийн зүйлийн 3.3, 4.3 дэх хэсэгт заасан зохицуулалттай агуулгын хувьд давхардсан байна.
7	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төсөлд уг хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан.
8	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Хуулийн төслийн 11.2-т зөрчиж байгуулсан гэрээ, хэлцлийн үйлчлэлийн талаарх зохицуулалтыг орхигдуулсан байна.
9	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төслөөр төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан зохицуулалт байхгүй.
10	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Хуулийн төсөлд төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх зохицуулалт байхгүй.
11	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Тухайн хуулийн төсөлд болон дагалдах хуулийн төслүүдээр татвар хураамж тогтоогоогүй.
12	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
13	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Хуулийн төслийн 8.1 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т заасан "өмчлөх эрх" хязгаарласан байж болзошгүй байна.
14	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
15	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
16	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
17	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хуулийн төсөлд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар тусгасан.

## ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үнэлгээний ажлын явцад хуулийн төслийн харилцан уялдаа, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох зорилгын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, гадаадын улс орны хууль тогтоомж, уг асуудлын хүрээнд хийгдсэн албан ёсны судалгааг ашиглан дүн шинжилгээ хийх замаар хийж гүйцэтгэлээ.

Энэхүү хуулийн төсөлд Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу холбогдох судалгаа хийгдсэн тул энэхүү судалгааны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалыг дахин тодорхойлж, түүнд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Харин одоогийн байдлаар боловсруулсан хүрээнд нь хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, дараахь зөвлөмжийг өгч байна.

1.Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ. Өрсөлдөөний хууль тогтоомжийг төсөөтэй хэрэглэхийг хориглоно.” гэж заасан нь Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-т “Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ.” гэж, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т “Тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно.” гэж заасан зохицуулалттай агуулгын хувьд давхардсан байна. Хуулийн төслийн 2.1-д зааснаар Өрсөлдөөний тухай хууль тогтоомжид Иргэний хууль багтаж байгаа тул Өрсөлдөөний тухай хуулиар зохицуулагдах харилцаанд Иргэний хуулийн зохицуулалт нэгэн адил үйчлэхээр заасан тул хуулийн төслийн 2.2 дахь заалтыг хасах.

2.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д “зүй ёсны монополь байдалтай” аж ахуй эрхлэгчийг тодорхойлох шалгуурыг өөрчилж, “өрсөлдөгч аж ахуй эрхлэгч нэвтрэн ороход хууль, эдийн засаг, техник, технологийн аль нэгнийх нь хувьд боломжгүй, эсхүл хязгаарлагдмал зах зээлд дангаараа үйл ажиллагаа явуулж байгаа” аж ахуй эрхлэгчийг зүй ёсны монополь байдалтай гэж үзэхээр заажээ. Өрсөлдөөний тухай хуулийн гол зорилт бол зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгч, давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шударга өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх юм. Иймд “зүй ёсны монополь байдал” болон “давамгай байдал”-г тогтоох шалгуур үзүүлэлтийг хуульд тодорхой заах шаардлагатай байна. Дээрх заалтын нөхцөлөөс харахад, тухайлбал, “хууль”-ийн хувьд нэвтрэх боломжгүй зах зээл гэдэг нь ойлгомжгүй байна. Түүнчлэн “хязгаарлагдмал зах зээл” гэдэгт ямар нөхцөлийг хамруулах нь төсөлд тодорхой тусгагдаагүй байна.

3.Хуулийн төслөөс хамаарал бүхий этгээд гэдгийг хассан үндэслэл, хэрэгцээ, шаардлага хуулийн төслийн үзэл баримтлал, тооцоо судалгаанд дурдагдаагүй байгааг анхаарч, энэ талаар тайлбар хийж, тодруулах.

4.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн гарчиг “... бусад аж ахуй эрхлэгчийг худалдан авах” гэсэн нь хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “аж ахуй эрхлэгч” гэж аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа ... хувь хүнийг” ойлгохоор заасантай нийцэхгүй байна. Аж ахуй эрхлэгч хувь хүнийг худалдан авах гэсэн ойлголт байхгүй тул “аж ахуй эрхлэгч хуулийн этгээдийн хувьцааг худалдан авах” гэж өөрчлөх.

Нөгөөтэйгүүр, хувьцааг бэлэглэх, өвлүүлэх замаар нэг талын хэлцлээр хувьцаа шилжиж байгаа тохиолдолд уг зохицуулалт нэгэн адил үйлчлэх эсэх, үйлчлэх тохиолдолд зүйлийн гарчгийг “хувьцаа шилжүүлэх” гэсэн агуулгаар өөрчлөх.

5.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Аж ахуй эрхлэгч бусад аж ахуй эрхлэгчтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж-ахуй-эрхлэгчийн хувьцааг худалдан авсан үр дүнд Компанийн тухай хуульд заасан хяналтын багцыг эзэмших, эсхүл дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт хамгийн их энгийн хувьцаа эзэмших тохиолдолд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хорооноос урьдчилан зөвшөөрөл авна.” гэж заасан байна. Үүнд нэгдүгээрт, хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуулийн 8.1-д зөвхөн давамгайл байдалтай хуулийн этгээдэд хамаарахаар заасныг бүх аж ахуй эрхлэгчид хамаарахаар өөрчилсөн нь жижиг, дунд бизнес эрхлэгчид хүндрэлтэй, цаг хугацаа, зардал шаардсан зохицуулалт гэж үзэхээр байна. Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.19-д “Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасган, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгана.” гэж заасан. Хэдийгээр төр өрсөлдөөнийг хамгаалах, өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой боловч зохистой түвшинд, бодит зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлж иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдийн дунд зохих хяналтыг тогтоох нь зүйтэй байна. Энэ талаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тодорхой зааж, тусгай зөвшөөрлийн тоог бууруулахаар тусгасан байна.

Эсхүл уг заалт хамаарахгүй буюу үйлчлэхгүй байх нөхцөлүүдийг тусгайлан хуульчлах /Япон Улсын Монополийн эсрэг хуулийн 6 дугаар бүлгээс жишиг зохицуулалтыг харах/.

Хоёрдугаарт, хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуулийн 8.1-д “... эсхүл ижил төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулдаг өрсөлдөгч компанийн энгийн хувьцааны 20-оос дээш, давуу эрхийн хувьцааны 15-аас дээш хувийг худалдан авах ... тохиолдолд ...” гэж заасныг “... аж ахуй эрхлэгчийн хувьцааг худалдан авсан үр дүнд Компанийн тухай хуульд заасан хяналтын багцыг эзэмших ...” гэж өөрчилснөөр тухайн гэрээ, хэлцэлд тавих хяналтын хүрээг багасгасан гэж үзэхээр байна. Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Компанийн гаргасан энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг компанийн хувьцааны хяналтын багц гэнэ.” гэж заасан бөгөөд үүнд компанийн 34 ба түүнээс дээш энгийн хувьцаа хамаарах юм. Энэ тохиолдолд тухайн компанийн 20 хувийн энгийн хувьцааг худалдан авах тохиолдолд зөвшөөрөл авдаг байсныг 34 хувь болгон өсгөснөөр хяналтын хүрээг багасгаж байна. Түүнчлэн уг зохицуулалтаас давуу эрхийн хувьцаа худалдан авах нөхцөлийг хасах болсон үндэслэл, шалтгаан тодорхойгүй байна.

6.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Аж ахуй эрхлэгч энэ хуулийн 8.1-д заасан зөвшөөрлийг аваагүй бол энэ талаар хийгдсэн хэлцлийг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцох шийдвэрийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хорооны нэхэмжлэлээр шүүх гаргана.” гэж, 10 дугаар зүйлийн 10.1-д “Энэ хуулийн 7.1-д зааж хориглосон үйл ажиллагааг хоёр ба түүнээс дээш удаа явуулж хуулийн хариуцлага хүлээж байсан ч дахин ийм үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдвол тухай аж ахуй эрхлэгчийг хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрийг Шударга өрсөлдөөн,



хэрэглэгчийн хорооны хүсэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ." гэж заасан нь дараахь хууль тогтоомжид нийцэхгүй байна.

Нэгдүгээрт, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан үндэслэлээр гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдол /цаашид "нэхэмжлэл" гэх/-ыг шүүх харьяалан шийдвэрлэнэ" гэж заасны дагуу төсөлд тусгасан хүсэлт гэснийг "нэхэмжлэл" гэж томъёолох нь зүйтэй. Компанийн бүртгэлтэй холбоотой захиргааны байгууллагын /улсын бүртгэл/ шийдвэрийг хүчингүй болгох нэхэмжлэл нь захиргааны хэргийн шүүхэд хамаарах бөгөөд тухайн тохиолдолд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар нэхэмжлэл болон гомдол гаргах замаар шүүхэд хандах боломжтой байна.

Хоёрдугаарт, Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 49.1-д "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана", мөн зүйлийн 49.2-т "Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй." гэж тус тус заасан. Түүнчлэн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус байж, гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд захирагдана." гэж заасны дагуу шүүгч аливаа хэрэг маргааныг шийдэхдээ хараат бус байх ёстой гэж шүүгч хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хараат бус байх ёстой талаар заажээ.

Хуулийн төсөлд зааснаас үзэхэд Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн хорооны хүсэлтийг үндэслэн шүүх шийдэхийг даалгасан байдлаар тусгасан бөгөөд хуулийн төслийн 10.2-т "Энэ хуулийн 10.1-д заасан шийдвэрийг шүүх гаргахдаа Компанийн тухай хуулийн 21, 22 дугаар зүйлд заасныг баримтлан тухайн аж ахуй эрхлэгчийг хэрхэн хуваах, тусгаарлахыг шийдвэртээ тодорхой заана." гэж шүүгчийн шийдвэр, захирамж гаргахдаа удирдлага болгох хэм хэмжээг шууд заасан байна. Шүүгч шийдвэр гаргахдаа ямар хуулийн, ямар зохицуулалт хэрэглэх нь шүүгчийн дотоод итгэл үнэмшилд хамаарах асуудал бөгөөд хууль тогтоомжоор шүүгчийн шийдвэр гаргахдаа удирдлага болгон хэрэглэх зохицуулалтыг хуульд шууд зааж өгөх нь дээр дурьдсан хуулиудтай зөрчилдөж байна.

Гуравдугаарт, хуулийн төслийн 10.1-д "Энэ хуулийн 7.1-д ..." гэж зааснаас харахад 7.1-д заасан үйл ажиллагааг хоёр ба түүнээс дээш удаа явуулсан ч гэсэн тухай бүрт Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх бөгөөд энэ төрлийн үйл ажиллагаа явуулсных нь төлөө тухайн компанийг шүүхийн шийдвэрээр хуваах, тусгаарлах зохицуулалт хийж байгаа нь Компанийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т "Компанийг хуваах замаар өөрчлөн байгуулах, шинээр компани байгуулах, хуваах балансыг батлах асуудал болон тухайн компанийн үнэт цаасыг шинээр байгуулагдсан компанийн үнэт цаас буюу эд хөрөнгөд хөрвүүлэх журмыг хуваагдаж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.", 22 дугаар зүйлийн 22.3-т "Компанийг тусгаарлах нөхцөл, журам, хуваах балансыг батлах болон шинэ компани байгуулах тухай шийдвэрийг өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ гаргана." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Зөрчил, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл хэмжээг энэ хуулиар тогтооно.” гэсэн хууль ёсны зарчим үйлчилдэг бөгөөд компанийг хуваах, тусгаарлах зэрэг арга хэмжээ авах нь хууль ёсны зарчимд зааснаас гадуур тухайн аж ахуй эрхлэгчид оногдуулж буй шийтгэл тул Зөрчлийн тухай хуулийн энэхүү зарчимтай зөрчилдөж байна. Иймд компанийг хуваах, тусгаарлах арга хэмжээг Зөрчлийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан албадлагын арга хэмжээний нэг төрөл болгон нэмэх.

7.Хуулийн төслийн 8 дугаар дугаар зүйлийн 8.4-т “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороо зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хянаж зөвхөн өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөл бүрдэнэ гэж үзвэл татгалзсан дүгнэлт гаргана.” гэж заасан бөгөөд өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөл гэдэгт юуг хамруулах, хүсэлтийг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг журмаар бус хуульд маш тодорхой тусгах шаардлагатай байна.

8.Түүнчлэн хуулийн төслийн 8.4, 11.3, 11.5, 15.1.8, 15.1.23, 25.1.1 дэх заалтад зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох болон аж ахуй эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, давамгайл байдлыг тогтоохтой холбогдох журам, өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн буюу бүрдүүлж болзошгүйг гэрээ, хэлцлийг тогтоохтой холбоотой журам, аж ахуй эрхлэгч бусад аж ахуй эрхлэгчтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж ахуй эрхлэгчийн хувьцааг худалдан авах хүсэлтийг татгалзах дүгнэлт гаргахтай холбогдох журам гэх мэт хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуулиар Засгийн газар тусгайлан батлан мөрдүүлэх журмуудыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороо батлахаар өөрчилсөн байна. Хуулийн төсөлд зааснаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хорооны дарга, гишүүдийг Засгийн газраас томилж, чөлөөлөхөөр, үйл ажиллагаагаа Засгийн газарт тайлагнахаар заасан. Түүнчлэн өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, төрөөс баримтлах бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх, холбогдох журам баталж, мөрдүүлэх, зөрчлийг шалган шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх гээд бүх бүрэн эрхийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороо нь хэрэгжүүлэхээр заасан байна. Өрсөлдөөний асуудлаар төрийн бусад байгууллагын хэрэгжүүлэх бүрэн эрх тусгагдаагүй. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1-д зааснаар шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах асуудал нь аль нэг төрийн захиргааны төв байгууллагад харьяалагддаггүй, харин Шадар сайдын эрхлэх асуудалд хамаарах бөгөөд уг асуудлын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг хариуцан хэрэгжүүлэхээр заасан байна. Түүнчлэн тус хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-д Засгийн газрын гишүүн эрхэлсэн асуудлын хүрээнд төрийн бодлого боловсруулах бүрэн эрхтэй байхаар заасан.

Шинэчилсэн найруулгын төсөлд зааснаар Засгийн газар зөвхөн томилох болон чөлөөлөх эрхтэй, харин өрсөлдөөний талаар баримтлах бодлогын баримт бичиг баталж, хэрэгжүүлэх боломжгүй байхаар хуулийн төсөлд тусгаснаар хороо бодлого боловсруулж батлах, түүнд нийцсэн журам баталж хэрэгжүүлэх, үүний дагуу хяналт шалгалт хийж, зөрчил шалган шийдвэрлэх зэрэг бүх асуудлыг өөрт төвлөрүүлж шийдвэрлэх нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1 болон 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасантай зөрчилдөж, Засгийн газраас хэрэгжүүлэх бодлого, чиглэлд уялдуулах, нийцүүлэх шаардлага алдагдах эрсдэл бий болж байна.

9.Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.2-т “Засгийн газраас ... зарим төрлийн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлд тодорхой хугацаагаар хязгаарлалт хийж

болно.” гэж заасан бөгөөд хязгаарлалт гэдэгт ямар үйл ажиллагааг хамруулж байгааг тодорхой болгох шаардлагатай. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгай зөвшөөрөлд хязгаарлалт хийх талаар тусгайлсан зохицуулалт байхгүй бөгөөд зөвхөн тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар зохицуулсан байна.

10. Хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын эрх зүйн статусыг хамтын удирдлагын зарчмаар ажиллах “хороо” болгон өөрчилж зохицуулсан байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд олон улсын жишигт төдийгүй Монгол Улсад хамтын удирдлагын зарчмаар ажилладаг байгууллагууд нь хороо, комисс гэсэн статустай байдаг бөгөөд жишээлбэл, Санхүүгийн зохицуулах хороо, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн үндэсний комисс байна гэж үзжээ. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар /Засгийн газрын тохируулагч агентлаг/-ыг дээрх байгууллагуудтай харьцуулах замаар хороо болгон өөрчлөн зохион байгуулах нь үндэслэлтэй эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэхийг дүгнэвэл:

Нэгдүгээрт, дээрх байгууллагууд нь Засгийн газраас бус Улсын Их Хурлаас байгуулагддаг, өөрөөр хэлбэл, хорооны дүрэм, хорооны дарга, гишүүдийг Улсын Их Хурлаас баталдаг, томилдог, огцруулдаг, чөлөөлдөг, үйл ажиллагаагаа Улсын Хуралд тайлагнадаг, хараат бус, бие даасан, эрх зүйн статус нь тусдаа хуулиар тодорхойлогддог байгууллагууд юм. Харин шинэчилсэн найруулгын төсөлд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хорооны дарга, гишүүдийг Засгийн газраас томилж, чөлөөлөхөөр, үйл ажиллагаагаа Засгийн газарт тайлагнахаар зохицуулсан байна.

Хоёрдугаарт, дээрх байгууллагууд нь хамтын удирдлагын зарчмаар ажилладаг боловч эрхлэн хариуцах асуудалтай холбоотойгоор шийдвэр гаргах процесс нь ялгаатай. Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хорооноос тавих хяналт шалгалтыг улсын байцаагч хэрэгжүүлж, хууль тогтоомжийн дагуу захиргааны шийтгэл ногдуулдаг /хянан шийдвэрлэсний үндсэн дээр/ бол тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих бүрэн эрхийг Хороонд олгосон байна. Харин шинэчилсэн найруулгын төсөлд өрсөлдөөний хуулийн зөрчлийг хянан шийдвэрлэх бүрэн эрхийг улсын байцаагч хэрэгжүүлдэг байсныг Хороо хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Гуравдугаарт, практикт хууль тогтоомжийн дагуу Засгийн газраас байгуулсан хорооны эрх зүйн байдлын талаар авч үзье. Тухайлбал, Эрчим хүчний тухай хуулийн дагуу Эрчим хүчний зохицуулах хороог Засгийн газар байгуулахаар заасан. Тус хуулиар хороо нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах, үнэ тарифыг тогтоох, эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох бүрэн эрхтэй байхаар заасан бол эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эрчим хүчний тухай хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгохтой холбогдон гарсан маргааныг хянаж дүгнэлт гаргах эрхтэй байхаар уялдуулан зохицуулсан. Өөрөөр хэлбэл, хороо нь зөвхөн эрчим хүчний хууль тогтоомжийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулах чиг үүргийн хүрээнд хяналт тавих, харин салбарын бодлогын асуудлыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хэрэгжүүлэхээр заасан байна. Түүнчлэн тусгай зөвшөөрөлтэй холбоотой хорооны байцаагчийн гаргасан шийдвэрийг төрийн захиргааны төв байгууллага нь хянан

хэлэлцэж шийдвэрлэхээр заасан нь захиргааны актыг дээд шатны захиргааны байгууллагад гомдол гаргах журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг хангасан зохицуулалт байна.

Түүнчлэн Харилцаа холбооны тухай хуулийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хороог Засгийн газар байгуулахаар заасан боловч харилцаа холбооны тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай байхаар хуульчилсан.

Нөгөөтэйгүүр, хорооны статустай ажилладаг гадаад улс орнуудын хууль тогтоомжийг харьцуулан судлахад, Япон Улсын Засгийн газрын тухай хууль<sup>4</sup>-ийн 3 дугаар зүйл болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын тухай хууль<sup>5</sup>-ийн 2 дугаар зүйлд зааснаар Засгийн газраас байгуулагдах байгууллагад яам, агентлаг, хороо хамаарах бөгөөд яам нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хороо болон агентлаг байгуулахаар заасан байна. Япон Улсын Засгийн газрын тухайд, яамны хариуцан хэрэгжүүлэх үйл ажиллагааны томоохон хэсэг буюу хүрээ, чиг үүргийг дагнан хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзвэл агентлаг байгуулах, харин сайдын шууд удирдлага, хяналтан дор үйл ажиллагаа явуулснаар тодорхой ажил, үйл ажиллагааны зорилгод саад учруулах, алдагдах байдал үүсэх магадлалтай тохиолдолд хороо байгуулан ажилладаг байна.<sup>6</sup>

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 1-д зааснаар Засгийн газар нь үйл ажиллагааныхаа зохих хүрээ, салбарт тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийг байгуулж болно. Төрийн захиргааны төв байгууллага эсхүл төрийн захиргааны байгууллагагүйгээр Засгийн газрын байгууллагын түвшинд "хороо" байгуулсан жишиг байхгүй байна.

Иймд хороо байгуулах тохиолдолд шударга өрсөлдөөний бодлогын асуудлыг Засгийн газар эсхүл уг асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хамааруулж, шударга өрсөлдөөнийг зохицуулах чиг үүргийг хороонд хуваарилан хуульчлах нь зүйтэй байна. Энэ тохиолдолд Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-д өөрчлөлт оруулахаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах шаардлагатай.

11.Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороо нь ... өрсөлдөөний талаар баримтлах бодлогыг тодорхойлж, улсын хэмжээнд хэрэгжүүлэх ..." гэж заасан нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна." гэж заасантай нийцэхгүй байх тул уг хэсгийг хасах. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд зааснаар шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах асуудлыг харьяалах төрийн захиргааны төв байгууллага байхгүй бөгөөд Шадар сайдын эрхлэх асуудалд хамаардаг бөгөөд шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах асуудлын бодлогын төлөвлөлт, боловсруулалтын асуудлыг хуулиар Засгийн газарт эсхүл асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхэд хамааруулан хуульчлах нь зүйтэй байна.

<sup>4</sup> <http://www.cas.go.jp/jp/seisaku/hourei/data/ngo.pdf>

<sup>5</sup> <http://www.moleg.go.kr/english/korLawEng?pstSeq=54793&rctPstCnt=3&searchCondition=Ttl&searchKeywo rd=government+organization+act>

<sup>6</sup> [https://japan.kantei.go.jp/constitution\\_and\\_government/frame\\_all\\_02.html](https://japan.kantei.go.jp/constitution_and_government/frame_all_02.html)

12.Хуулийн төслийн 19 дүгээр зүйлд хорооны дарга, гишүүнийг огцруулах асуудлыг зохицуулсан байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6-д Улсын Их Хурал “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шүүд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах” онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан бөгөөд Засгийн газраас байгуулах байгууллагын бүрэлдэхүүнийг огцруулах асуудал үүнд хамаарахгүй. Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн уг заалтыг хасах.

13.Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн зөрчил үйлдэгдсэн өдрөөс, зөрчил үргэлжилсэн буюу давтан үйлдэгдсэн тохиолдолд сүүлийн зөрчил үйлдэгдсэн өдрөөс хойш 3 жилийн дотор зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж болно. Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил хөөн хэлэлцэх хугацаа энэ хуульд хамаарахгүй.” гэж заасныг Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлтэй нийцүүлэн “Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн зөрчил үйлдэгдсэн өдрөөс, зөрчил үргэлжилсэн буюу давтан үйлдэгдсэн тохиолдолд сүүлийн зөрчил үйлдэгдсэн өдрөөс хойш 3 жил өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй.” гэж өөрчилж, “Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил хөөн хэлэлцэх хугацаа энэ хуульд хамаарахгүй.” гэснийг хасах.

14.Уг хөөн хэлэлцэх хугацаатай уялдуулан төлөвлөгөөт хяналт шалгалтын хугацааг тогтоон явуулах нь зүйтэй.

15.Хуулийн төслийн 11.1-д “Аж ахуй эрхлэгчийн байгуулсан дор дурдсан агуулга бүхий гэрээ, хэлцэл нь өрсөлдөөнийг хязгаарлах тул хориглох ба энэ хэлцлийг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцно.” гэж заасан байна. Иргэний хуулийн 56-61 дүгээр зүйлд хүчин төгөлдөр бус хэлцлийн талаар зохицуулсан бөгөөд тус хуулийн 56 дугаар зүйлд заасан хэлцэл нь заавал шүүхээр хүчин төгөлдөр бус гэж тогтоогдох шаардлагагүй, хүчин төгөлдөр бус байх нь тухайн хэлцлийн эрх зүйн энгийн үр дагавар байдаг. Харин мөн хуулийн 57.1-д “Шүүх хуульд заасан үндэслэл, журмын дагуу сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцож болно.”, 57.2-т “Шүүхээс хүчин төгөлдөр бус гэж тооцсон хэлцэл нь хийсэн үеэсээ хүчин төгөлдөр бус байна.” гэж заасны дагуу энэхүү 57 дугаар зүйлд заасан хэлцэл нь зөвхөн шүүхийн шийдвэрийн үндсэн дээр хүчин төгөлдөр бусад тооцогдоно.

Дээрхээс үзвэл хуулийн төсөлд тусгасан хэлцлийг хуулиар хориглож байгаа тул Иргэний хуулийн 56.1.1-д заасан “хууль зөрчсөн хэлцэл” нь анхнаасаа хүчин төгөлдөр бус байх тул хуулийн төслийн 11.1-г “Аж ахуй эрхлэгчийн байгуулсан дор дурдсан агуулга бүхий гэрээ, хэлцэл нь өрсөлдөөнийг хязгаарлах тул хориглох ба энэ хэлцэл хүчин төгөлдөр бус байна.” гэж өөрчлөх.

16.Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “Аж ахуй эрхлэгчдийн хоорондох дараахь гэрээ, хэлцэл нь өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн буюу бүрдүүлж болзошгүй нь тогтоогдсон бол хориглоно.” гэж заасан боловч ийнхүү зөрчиж байгуулсан гэрээ, хэлцлийн үйлчлэлийн талаар зохицуулалгүй орхигдуулсан байна.

Иймд хуулийн төслийн 11.2 дахь хэсгийг “Аж ахуй эрхлэгчдийн хооронд байгуулсан дараахь гэрээ, хэлцэл нь өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн буюу бүрдүүлж болзошгүй нь тогтоогдсон бол хориглох ба энэ хэлцэл хүчин төгөлдөр бус байна.” гэж өөрчлөх.

17.Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Хороо чиг үүргийнхээ дагуу дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гээд 15.1.4-т “өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуй эрхлэгч,

байгууллагад хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг шалган шийдвэрлэх, таслан зогсоох, мэдээлэл, баримт материал үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, дүгнэлт гаргах, хууль зөрчсөн этгээдэд шийтгэл хүлээлгэх, хуульд заасан үндэслэлээр шийтгэлээс чөлөөлөх”, 15.1.14-т “аж ахуй эрхлэгч Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг зөрчсөн эсэх талаар шийдвэр гаргах” гэж тус тус заажээ. Хуулийн төслийн 17 дугаар зүйлээр Хорооны дарга, гишүүнийг томилох харилцааг зохицуулсан бөгөөд 17.4-т Хорооны дарга нь эдийн засаг, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ арван таваас доошгүй жил, үүнээс төрийн байгууллагад арваас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэн байна”, 17.5-д Хорооны гишүүн нь эдийн засаг, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ арваас доошгүй жил, үүнээс төрийн байгууллагад наймаас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэн байна” гэж хорооны дарга болон гишүүдэд тавих шаардлагыг тус тус тодорхойлжээ. Энэхүү тодорхойлолтоос үзвэл улсын байцаагчийн эрхгүй этгээдүүд Өрсөлдөөний тухай хууль тогтоомж зөрчсөн тухай, зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаа явуулах гэж байгаа нь хууль зүйн үндэслэлгүй байна.

Учир нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6-д “Дараахь эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ” гээд 1.8 дугаар зүйлийн 6.16-д “Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.10, 10.1, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.5 дахь заалт, 10.7, 10.8 дугаар зүйл, 10.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 10.27 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил” гэж заасан байна. Энэхүү зөрчил шалган шийдвэрлэх харьяаллаас харахад зөрчлийг зөвхөн улсын байцаагч шалгаж, шийдвэр гаргах эрхтэй байх бөгөөд хуулийн төсөлд заасны дагуу хорооны дарга, гишүүд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах нь Зөрчлийн тухай хуультай зөрчилдөж байна.

18.Хуулийн төслийн 15.1.9-д “өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг зөрчиж гаргасан захиргааны байгууллагын шийдвэрийг бүхэлд нь эсхүл холбогдох хэсгийг хүчингүй болгох шийдвэр гаргаж тухайн этгээдийн дээд байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлэх” гэж заасан байна. Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно” гэж захиргааны байгууллагад хамаарах этгээдүүдийг заасан бөгөөд хуулийн 37.1-д “захиргааны акт гэж захиргааны байгууллагаас зөрил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно” гэж заасны дагуу хуулийн төсөлд заасан захиргааны байгууллагын шийдвэр нь захиргааны акт болох юм.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106.3-т “Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаас хянан хэлэлцээд дараахь шийдвэрийг гаргана.” гээд 106.3.1-д “захиргааны акт, захиргааны гэрээ илт хууль бөгөөд түүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн болох нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгох” шийдвэр гаргахаар байна. Энэхүү хуулийн зохицуулалтаас үзвэл захиргааны байгууллагын шийдвэрийг хүчингүй болгох эрх нь гагцхүү захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах бөгөөд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороо нь хуулийн төсөлд зааснаар захиргааны байгууллагын шийдвэрийг бүхэлд нь эсхүл холбогдох хэсгийг хүчингүй болгох нь Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчиж байна.

Иймд хуулийн төслийн 15.1.9 заалтыг “өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг зөрчиж гаргасан захиргааны байгууллагын шийдвэрийг бүхэлд нь эсхүл холбогдох хэсгийг хүчингүй болгох саналыг тухайн этгээдийн дээд байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлэх” гэж өөрчлөх.

19.Хуулийн төслийн 15.1.23-т “аж ахуй эрхлэгчийг захиргааны шийтгэлээс чөлөөлөхтэй холбогдох журмыг батлах” гэж Хорооны хэрэгжүүлэх эрхийг заасан байна.

Захиргааны шийтгэл гэх нэр томъёо нь 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсон Захиргааны хариуцлагын тухай хуульд хэрэглэгдэж байсан нэр томъёо бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 2-т “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчлийн шинжийг харгалзан энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу шийтгэл оногдуулна.” гэж заасны дагуу зөрчил, түүнд хүлээлгэх шийтгэл гэж хэрэглэх нь хуульд нийцэх юм.

Хуулийн төсөлд тусгаснаар Хороо нь зөрчлийн шийтгэлээс чөлөөлөхтэй холбогдох журмыг батлахаар төсөлд тусгажээ. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10 дугаар зүйлийн 1-д “Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгаж дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана” гээд 1.3-т “Зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үндэслэл байгаа бол шийтгэлээс чөлөөлөх”, 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хэргийн шүүх зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэж, дараахь үйдвэрийн аль нэгийг гаргана.” гээд 1.3-т “шийтгэлээс чөлөөлөх” гэж тус тус зааснаас үзвэл зөрчлийн шийтгэлээс чөлөөлөх эрх бүхий этгээд нь улсын байцаагч, эсхүл шүүх байна.

Иймд хороо нь шийтгэлээс чөлөөлөх журмыг батлах нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг зөрчиж байгаа бөгөөд хуулийн төсөлд тусгасан зөрчлөөс чөлөөлөх гэсэн ойлголт бус шийтгэлээс чөлөөлөх гэсэн ойлголт байгааг анхаарна уу.

20.Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.3-т “Хорооны дарга, гишүүнээр дараахь этгээдийг томилж болохгүй.” гээд 17.3.2-т “улс төрийн намын улирдах албан тушаалтан” гэж заасан байна. Хуулийн төслийн үзэл баримтлалаас үзэхэд тус хороог улс төрөөс ангид байлгах зорилготой байх бөгөөд энэхүү зохицуулалтын хүрээнд улс төрийн намын удирдах албан албан тушаалтнаас бусад буюу намын дунд шатны албан тушаалтан, намын гишүүн хүн хорооны дарга, гишүүнээр томилогдох боломжтой байхаар заасан байна.

Иймд хуулийн төслийн 17.3.2 дахь заалтыг “улс төрийн намын гишүүн” гэж өөрчлөх нь зүйтэй байна.

21.Хуулийн төслийн 24.2 дахь хэсгээр улсын байцаагчийн эрх, үүргийг тодорхойлсон бөгөөд 24.2.1-д “өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах, зөрчил шалгах болон хяналт шалгалт хийх саналаа Хорооны даргад тавьж шийдвэрлүүлэх, Зөрчлийн тухай хуулийн 10.7 дугаар зүйлийн 6-д заасан зөрчлийг шалган шийдвэрлэх”, 24.2.5-д “Өрсөлдөөний тухай хууль тогтоомж зөрчсөн нь Хорооноос гаргасан шийдвэрээр тогтоогдсон аж ахуй эрхлэгчид захиргааны шийтгэл ногдуулах” гэж заасан байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6-д “Дараахь эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ” гээд 1.8 дугаар зүйлийн 6.16-д “Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.10, 10.1, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.5 дахь заалт, 10.7, 10.8 дугаар зүйл, 10.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 10.27

дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил” гэж заасан байна. Энэхүү зөрчил шалган шийдвэрлэх харьяаллаас харахад зөрчлийг зөвхөн улсын байцаагч шалгаж, шийдвэр гаргах эрхтэй байх бөгөөд энэхүү зөрчлүүдэд хяналт шалгалт явуулах, зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах эрх нь гагцхүү улсын байцаагчид хамаарах эрх байх тул Хороо энэхүү эрхийг хэрэгжүүлэх боломжгүй юм. Мөн хуулийн төслөөс улсын байцаагчид дан ганц Зөрчлийн тухай хуулийн 10.7 дугаар зүйлийн 6-д заасан зөрчлийг шалган шийдвэрлэх эрх олгож байгаа нь бусад зөрчлийг хөрөө шалган шийдвэрлэхээр харагдаж байна. Хорооны дарга болон гишүүд нь зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд биш бөгөөд хуулийн төслийн энэхүү зохицуулалт нь Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг зөрчиж байна.

Нөгөөтэйгүүр, хуулийн төслийн 24.2.5 дахь заалтаас харахад Хороо нь аж ахуй эрхлэгчийг өрсөлдөөний тухай хууль тогтоомж зөрчсөн болохыг тогтоож, улсын байцаагч нь дан ганц шийтгэл ногдуулах эрхтэй байхаар тусгасан байгаа нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6-д “Дараахь эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ.” гэж хуулиар улсын байцаагчид тусгайлан харьяалуулсан зөрчил шалган шийдвэрлэх бүрэн эрхэд халдсан зохицуулалт болсон байна.

Иймд Хороо нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх зүйн үндэслэл байхгүй болохыг анхаарна уу.

### **Зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааны талаарх зохицуулалт**

Шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан боловсруулсан Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд дараахь дүгнэлт, зөвлөмжийг өгч байна.

22.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр 9.1 дүгээр зүйлд нэмэлтээр оруулах 19, 20, 21, 22, 23 дахь хэсэг, 1.8 дугаар зүйлийн 6.16 дахь заалтад оруулах нэмэлт нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 2.4 дүгээр зүйлд заасантай зөрчилдөж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зөрчил үйлдсэн этгээдэд шийтгэл оногдуулах, шийтгэлээс чөлөөлөх эсэхийг улсын байцаагчийн эрхтэй албан тушаалтан, эсхүл шүүх хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэхээр заасан.

Гэтэл зөрчил үйлдсэн этгээдэд хариуцлага тооцох эсэхийг өрсөлдөөний талаар баримтлах бодлого тодорхойлох, хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий орон тооны бус хорооны гишүүд өөрсдийн тогтоосон дэг бүхий хурлаар хэлэлцэн олонхийн саналаар нэгтгэн шийдвэрлэхээр төсөлд тусгасан нь дээрх зөрчлийг үүсгэж байна.

23.Шинэчилсэн найруулгын төсөлд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг журамласан нь тухайн хуулиар зохицуулах харилцааны хүрээнээсээ хальсан нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалттай давхардал, хийдэл, зөрчил үүсгэхээс гадна Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.1.5, 29.1.6 дахь заалтад заасан шаардлагыг зөрчсөн байна.

Тухайлбал, төсөлд тусгасан дараахь зохицуулалт нь хүрээнээсээ хальж, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтаар зохицуулсан асуудлыг давхардуулан зохицуулахаар зөрчил үүсгэсэн байна:



№	Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт	Санал
1	Төслийн 11.5 дахь хэсэг	ЗШШТХ-ийн 6.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэг	ЗШШТХ-ийн 6.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэгтэй нийцүүлэх
2	Төслийн 15.1.10, 15.1.12, 15.1.19, 24.2.2, 28.1.2 дахь заалт	ЗШШТХ-ийн 4.4, 4.5 дугаар зүйл	"... зөрчил шалган шийдвэрлэх ...", "... зөрчил шалгах ..." хэсгийг зохицуулалтаас хасах.
3	Төслийн 15.1.14, 15.1.21, 24.2.5 дахь заалт	ЗШШТХ-ийн 6.10, 6.11, 7.1 дүгээр зүйл	ЗШШТХ-д нийцүүлэх
4	Төслийн 24.2.4, 24.2.5, 24.2.6, 24.2.8 дахь заалт	ЗШШТХ-ийн Дөрөвдүгээр бүлгийн зохицуулалт	ЗШШТХ-д нийцүүлэх

24. Хуулийн төсөлд зөрчил болон төрийн хяналт шалгалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой алдаа, дутагдал, тэдгээрийг шалган шийдвэрлэх ажиллагааны ялгаатай байдлыг зааглан тодорхойлоогүйгээс хууль хоорондын давхардал, хийдэл үүсгэсэн байна. Хяналт шалгалт, зөрчлийн шалгалтыг ялгаж, тусад нь зохицуулах.

Тухайлбал, ЗШШТХ-ийн 9.1 дүгээр зүйлд нэмэлт оруулахаар томьёолсон 14, 15, 16, 17 дахь хэсэг нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг нэгдсэн стандарт, журмаар зохицуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах гэсэн ЗШШТХ-ийн үзэл баримтлал, үндсэн зорилго, зарчимтай зөрчилдсөн байна.

Учир нь ЗШШТХ-ийн Есдүгээр бүлэгт заасан тусгай журмаар зөвхөн баривчлах шийтгэл оногдуулж болох буюу гэм буруутай эсэхийг тогтоох шаардлага бүхий зөрчлийг шалгахад хязгаарлалттай. Иймд энэхүү тусгай журмыг Зөрчлийн тухай хуулийн 10.7 дугаар зүйлд заасан зөрчлийг шалгахад хамруулан зохицуулах боломжгүй юм.

Түүнчлэн Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл, гомдол, мэдээллийг хүлээн авах журмыг ЗШШТХ-ийн 6.1, 6.2 дугаар зүйлээр, эрх бүхий албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой гомдлыг шийдвэрлэх журмыг 1.12 дугаар зүйлээр тус тус зохицуулсан тул зөвхөн Өрсөлдөөний тухай хууль зөрчсөн зөрчилд холбогдуулан нэмэлтээр дээрх харилцааг зохицуулсан журмыг нэмэх шаардлагагүй болно.

Иймд ЗШШТХ-ийн 9.1 дүгээр зүйлд шинээр 15, 25, 26 дахь хэсгийн зохицуулалтыг нэмэх шаардлагагүй болно.

Харин өрсөлдөөний хууль тогтоомжийн биелэлтэд төрийн хяналт шалгалт явуулахтай холбоотой журмыг /хяналт шалгалт явуулах үндэслэл, алдаа, дутагдлыг илрүүлэх, шалгах, дүгнэлт гаргах, хугацаатай даалгавар өгөх гэх мэт/ Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зөрчлөөс тусад нь зохицуулах нь зүйтэй байна.

25. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан зохицуулалтын хувьд мөн дээрхийн адил хууль хоорондын зөрчил, хийдлийг үүсгэж байна.

Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлд нэмэлтээр оруулах 5, 6 дугаар хэсэг нь тус хуулийн үзэл баримтлалтай зөрчилдсөн, 10.4 дугаар зүйлийн 4.8-д оруулах нэмэлт нь тус хуулийн 8.5 дугаар зүйлтэй давхардсан, 10.7 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт оруулах нэмэлт нь мөн хуулийн 2.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгтэй тус тус зөрчилдсөн, мөн зүйлийн 12 дахь хэсэгт оруулах нэмэлт нь ямар үйлдэл, эс үйлдлийг зөрчилд тооцох нь тодорхойгүй, 10.7 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт оруулах өөрчлөлт нь зөрчлийг тодорхойлсон бус Өрсөлдөөний тухай хуулиар зохицуулах хориглолтыг заасан, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт оруулах нэмэлт нь тус зүйлээр зохицуулсантай давхардуулсан байна.

25.Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон түүнийг дагалдах Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дээрх дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалыг дахин тодорхойлж, түүнд нийцүүлэх замаар боловсруулах нь зүйтэй байна.

26.Хуулийн төслийг боловсруулахдаа өрсөлдөөний хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас явуулах үндсэн чиг үүргийн хяналт буюу төрийн хяналт шалгалтыг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас зааглан тодорхойлох, мөн төрийн хяналт шалгалтын үр дүнд шийдвэрлэж болох алдаа, дутагдал болон зайлшгүй хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай зөрчилд тооцох үйлдэл, эс үйлдлийг ялган зохицуулахад анхаарах шаардлагатайг зөвлөж байна.

-----oOo-----

---

**“ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД  
ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО**

## ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу урьдчилсан байдлаар тооцлоо.

Шинээр боловсруулж буй хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал үүсэх магадлалыг урьдчилан гаргах зорилготой. “Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл” дэх зохицуулалтууд нь хуулийн этгээд болон иргэнд шинээр зардал үүсэхгүй болно. Харин төрийн байгууллагад зардал үүсч байна.

Хуулийн төслөөр зөвхөн шинээр бий болж буй үүрэгтэй холбогдох зардал тооцоогдож байгаа тус бодит статистик тоо баримтыг шууд ашиглах боломжгүй тохиолдлыг ижил төстэй ажил үйлчилгээнд тулгуурлан аргачлалын 2.5.2 дахь заалтад үндэслэн баримжаалан тохиолдлын тоог тогтоосон болно.

### НЭГ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ бүлэгт “Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийн төрийн захиргааны байгууллагад үүрэг оногдуулсан зохицуулалтууд нь тухайн байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтооход оршино.

Зардлыг тооцохдоо дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
2. Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
3. Гарах зардлыг урьдчилан тооцоолох;
4. Зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах;

#### 1.1 Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр дараах чиг үүргийг Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн хороо одоо хэрэгжүүлж байгаа чиг үүрэг дээрээ нэмж гүйцэтгэхээр байна. Үүнд:

1. Аж ахуй эрхлэгч бусад аж ахуй эрхлэгчтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж ахуй эрхлэгчийг худалдан авах зөвшөөрсөн эсхүл татгалзсан дүгнэлт гаргаж өгөх /Хуулийн төслийн 8 дугаар зүйл/

2. Өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах талаар баримтлах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, баримтлах бодлогыг тодорхойлох /Хуулийн төслийн 14.1,15 дугаар зүйл/
3. Захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлсан үйл ажиллагаа явуулсан эсэхийг шалгаж, ирүүлсэн өргөдөл гомдлыг хянах /Хуулийн 13 дугаар зүйл/
4. Төрийн бусад байгууллагаас хэрэгжүүлж буй салбарын бодлого, үйл ажиллагаанд өрсөлдөөний бодлогыг тусгах санал зөвлөмж боловсруулж хүргүүлэх /Хуулийн 15 дугаар зүйл/
5. Зөрчлийн хэрэг бүртгэлт, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хорооны улсын байцаагч хэрэгжүүлэх

## 1.2 Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт хүлээлгэсэн үүрэг тус бүрийг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаа буюу ажил үйлчилгээ тус бүрийг тооцож, эдгээрт ямар цаг хугацаа зарцуулах, улсын төсөвт хүний нөөцтэй холбоотой ямар хэмжээний зардал үүсэхийг урьдчилан тооцлоо.

Хүний нөөцийн хэрэгцээг тооцохдоо тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хугацаа болон 1 жилд гүйцэтгэх тохиолдлын тоогоор баримжаална.

ШӨХТГ-ын 2015-2017 оны жилийн эцсийн тайлан мэдээ, статистик үзүүлэлт болон 2018 оны 1 дүгээр улирлын тоон үзүүлэлт, мэдээ баримт, хяналт шалгалтын бүртгэл, мэдээлэл болон ажлын байрны ажиглалт дээр үндэслэн стандарт үйл ажиллагааны хугацааг тогтоосон болно.

1. Аж ахуй эрхлэгч бусад аж ахуй эрхлэгчтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж ахуй эрхлэгчийг худалдан авах зөвшөөрсөн эсхүл татгалзсан дүгнэлт гаргаж өгөхөд шаардлагатай хүний нөөцийн тооцоо:

Хүснэгт №1

Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Гүйцэтгэх хугацаа дунджаар /минут/	Тохиолдлын тоо /дундаж/	Нийт /минут/
Аж ахуй эрхлэгч бусад аж ахуй эрхлэгчтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах,	Аж ахуй эрхлэгчийн хүсэлтийг бүртгэх,	5	60	300
	Хүсэттэй танилцаж, нэгжид шилжүүлэх	5	60	300
	Хүсэлтийг хүлээн авч, холбогдох материалтай танилцах, бүрдүүлэх материалыг бүрэн эсэхийг нягтлах <sup>1</sup>	20	60	1200

<sup>1</sup> Компанийн товч танилцуулга, гэрчилгээний хуулбар, холбогдох байгууллагын лавлагаа, нэгдэх, нийлэх, хувьцаа худалдан авах талаар гаргасан шийдвэр, гэрээ, санхүүгийн тайлан, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл, борлуулалтын хэмжээ, эдийн засгийн үзүүлэлтийн талаарх мэдээлэл, холбогдох материалын бүрдлийг хянаж, мэдээлэл нь шаардлага хангаагүй, дутуу бол нэмэлт материал гаргуулах, эсхүл хүлээн авахаас татгалзах эсэхийг нягтлах,

бусад аж ахуй эрхлэгчийг худалдан авах зөвшөөрсөн эсхүл татгалзсан дүгнэлт гаргаж өгөх /Хуулийн төслийн 8 дугаар зүйл/	Өргөдөлд хяналт шинжилгээ хийх <sup>2</sup>	1440	60	86400
	Зах зээлийн төвлөрлийн түвшинг тодорхойлох	1200	60	72000
	Зах зээлээс шахах, зах зээлд нэвтрэхэд саад учруулах нөхцөл байдал үүсэх эсэхийг судлах, хянах	2400	60	144000
	Өрсөлдөгчийг эдийн засгийн ашиг сонирхлыг хясан боогдуулсан эсэхийг шалгах, судлах	1920	60	115200
	Хүсэлтийг хариу хүргүүлэх албан бичиг боловсруулах,	30	60	1800
	Албан бичгийг албажуулах, шууданд хийх	15	60	900
Нийт шаардлагатай хугацаа /минут/				<b>422,100</b>

Шаардлагатай хүний нөөц:  $422,100 : 60 \text{ минут} = 7035 \text{ цаг}$ ,  $7035 : 8 \text{ цаг} = 879.3 \text{ ажлын өдөр}$ ,  $879.3 : 220^3 \text{ ажлын өдөр} = 3.99 \text{ буюу } 4 \text{ хүний орон тоо чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо гарч байна.}$

1. Өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах талаар баримтлах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, баримтлах бодлогыг тодорхойлоход шаардлагатай хүний нөөцийн тооцоо:

Хүснэгт №2

Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Гүйцэтгэх хугацаа дунджаар /минут/	Тохиолдлын тоо /дундаж/	Нийт /минут/
Өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах талаар баримтлах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, баримтлах бодлогыг тодорхойлох /Хуулийн төслийн 14.1, 15 дугаар зүйл/	Зах зээлийн судалгаа хийж, холбогдох мэдээллийг цуглуулах	4800	20	96000
	Мэдээллийг боловсруулах, нэгтгэх	1440	20	28800
	Холбогдох салбарын хууль эрх зүйн орчин, бодлогын баримт бичиг, дүрэм журмыг судлах	2400	20	48000
	Өнөөгийн төлөв байдлыг судлах,	3360	20	67200
	Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх	7200	20	144000
	Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийх	3360	20	67200
	Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	960	1	960
	Төлөвлөгөө хэрэгжүүлэх, үр дүнг танилцуулах	7200	1	7200

<sup>2</sup> Нэгдэснээр өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөл бүрдэх эсэхийг үзнэ хэвтээ, босоо, цогцолбор хэлбэрийн аль нь болохыг тодорхойлох

<sup>3</sup> Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийг баримталж, ээлжийн амралт болон нийтээр амрах хоногийг хасч ажлын өдрийг тооцож гаргасан болно.

Аж ахуй эрхлэгчдэд өрсөлдөөний талаар баримтлах бодлогын талаар сургалт, уулзалт зохион байгуулах	1440	20	28800
Нийт шаардлагатай хугацаа /минут/			<b>488,160</b>

Шаардлагатай хүний нөөц:  $488,160 : 60 \text{ минут} = 8136 \text{ цаг}$ ,  $8136 : 8 \text{ цаг} = 1017 \text{ ажлын өдөр}$ ,  $1017 : 220 \text{ ажлын өдөр} = 4.62 \text{ хүн}$

2. “Захиргааны байгууллага”<sup>4</sup>-аас өрсөлдөөнийг хязгаарлсан үйл ажиллагаа явуулсан эсэхийг шалгаж, ирүүлсэн өргөдөл гомдлыг хянахад шаардлагатай хүний нөөцийн тооцоо:

Хүснэгт №3

Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Гүйцэтгэх хугацаа дунджаар /минут/	Тохиолдлын тоо /дундаж/	Нийт /минут/
Захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлсан Үйл ажиллагаа явуулсан эсэхийг шалгаж, ирүүлсэн өргөдөл гомдлыг хянах <sup>5</sup> /Хуулийн 13 дугаар зүйл/	Өргөдөл гомдол хүлээн авах, бүртгэх	5	30	150
	Өргөдөл гомдолтой танилцаж, нэгжид шилжүүлэх	5	30	150
	Мэдээлэл цуглуулах, нэгтгэж боловсруулах,	480	30	14400
	Өргөдөл гомдлын дагуу хяналт шалгалт хийх,	1440	30	43200
	Хяналт шалгалтын үр дүнг удирдлагад танилцуулах	30	30	900
	Албан бичиг боловсруулах, албажуулах, гомдол гаргагч, холбогдогчид мэдэгдэх	45	30	1350
	Захиргааны байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг судлаад санал өгөх	120	30	3600
	Урирдамжтай хяналт шалгалт хийх	480	20	9600
Нийт шаардлагатай хугацаа /минут/				<b>73,350</b>

<sup>4</sup> Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 “Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно:” хуулийн 5.1.1.төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага; 5.1.2.хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага;5.1.3 захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд;5.1.4.үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа;5.1.5.нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллагууд багтаж байна.

<sup>5</sup> Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлд “Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахыг хориглох” гэснийг хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр “Захиргааны байгууллага” гэж өөрчилсөнөөр хамааралтай байгууллагууд нь нэмэгдсэн болно.

Шаардлагатай хүний нөөц:  $73,350: 60 \text{ минут} = 1222.5 \text{ цаг}$ ,  $1222.5: 8 \text{ цаг} = 152.8 \text{ ажлын өдөр}$ ,  $152.8: 220 \text{ ажлын өдөр} = 0.69 \text{ хүн}$  шаардлагатай тооцоо гарч байна.

3. Төрийн бусад байгууллагаас хэрэгжүүлж буй салбарын бодлого, үйл ажиллагаанд өрсөлдөөний бодлогыг тусгах санал зөвлөмж боловсруулж хүргүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн тооцоо:

Хүснэгт №4

Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Гүйцэтгэх хугацаа дунджаар /минут/	Тохиолдлын тоо /дундаж/	Нийт /минут/
Төрийн бусад байгууллагаас хэрэгжүүлж буй салбарын бодлого, үйл ажиллагаанд өрсөлдөөний бодлогыг тусгах санал зөвлөмж боловсруулж хүргүүлэх /Хуулийн 15 дугаар зүйл/	Төрийн бусад байгууллагаас хэрэгжүүлж буй салбарын бодлого, баримт бичигтэй танилцах	20	100	2000
	Хэрэгжүүлж буй салбарын бодлого, баримт бичигтэй холбогдолтой хууль эрх зүйн баримт бичгүүдийг судлах	720	100	72000
	Салбарын нөхцөл байдал, өрсөлдөөний орчныг судалж тодорхойлох	720	100	72000
	Тухайн салбарын үйл ажиллагаанд өрсөлдөөний бодлогыг тусгах санал зөвлөмж боловсруулах	120	100	12000
	Өрсөлдөөний бодлогыг тусгах санал зөвлөмж боловсруулсан төслийг удирдлагад танилцуулж, хянуулах	45	100	4500
	Өрсөлдөөний бодлогыг тусгах санал зөвлөмж хүргүүлэх албан бичиг боловсруулах,	30	100	3000
	Албан бичгийг албажуулах, шууданд хийх	20	100	2000
Нийт шаардлагатай хугацаа /минут/				167,500

Шаардлагатай хүний нөөц:  $167,500: 60 \text{ минут} = 2791.6 \text{ цаг}$ ,  $2791.6: 8 \text{ цаг} = 348.95 \text{ ажлын өдөр}$ ,  $348.95: 220 \text{ ажлын өдөр} = 1.58 \text{ хүн}$  шаардлагатай тооцоо гарч байна.

4. Зөрчлийн хэрэг бүртгэлт, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хорооны улсын байцаагч хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн тооцоо:

Хүснэгт №5

Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Гүйцэтгэх хугацаа дунджаар /минут/	Тохиолдлын тоо /дундаж/	Нийт /минут/
	Өргөдөл гомдлыг хүлээн авах, танилцах	10	200	2000
	Хяналтын прокурорт танилцуулах, бүртгүүлэх	45	200	9000
	Мэдээлэл цуглуулах, хууль ёсны төлөөлөгчийг томилох, мэдүүлэг авах гэх мэт тэмдэглэлүүдийг үйлдэх	1440	200	288000



Зөрчлийн хэрэг бүртгэлт, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хорооны улсын байцаагч хэрэгжүүлэх	Шийдвэр гаргах /Зөрчлийн хэрэг нээх тогтоол үйлдэх, бүртгүүлэх, зөрчлийн хэргийн дугаар авах/	300	100	30000
	Шийдвэр гаргах / Хүлээн авахаас татгалзах тэмдэглэл үйлдэх, бүртгүүлэх, архивлах/	300	25	7500
	Шийдвэр гаргах / Харъяалалын дагуу шилжүүлэх санал үйлдэх, бүртгүүлэх, шилжүүлэх/	300	45	13500
	Шийдвэр гаргах/ Хялбаршуулан журмаар шийдвэрлэх тэмдэглэл үйлдэх, бүртгүүлэх, шийтгэвэрийн хуудсыг хүлээлгэн өгөх/	480	30	14400
	Зөрчлийн хэрэг нээсэн хэргийг шалгах, нотлох баримт цуглуулах, мэдээллийг боловсруулах...зэрэг хяналт шалгалтын ажиллагааг хийх	1920	100	192000
	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу Зөрчлийн хэрэгтэй холбогдох тэмдэглэл, санал, тогтоол үйлдэх, боловсруулах	1440	100	144000
	Зөрчлийн хэрэгт шаардлагатай тохиолдолд Шинжээч томилуулах,	120	20	2400
	Эрх хязгаарлах арга хэмжээ авах	120	20	2400
	Хяналт шалгалтаар үзлэг хийх, тэмдэглэл хөтлөх,	1440	50	72000
	Зөрчлийн хэрэгтэй холбогдолтой бусад нэмэлт ажиллагааг хийх	60	20	1200
	Зөрчлийн хэргийг хянаж дуусгах, шийдвэрийг гомдол гаргагч, холбогдогч нарт танилцуулах, тэмдэглэл үйлдэх,	960	100	96000
	Зөрчлийн хэргийн материалд товъёо хийх, хавтаслах зэргээр шаардлагад нийцүүлэн бэлтгэх	60	100	6000
	Зөрчлийн хэргийг прокурорт хүргүүлэх, гомдол гаргагч, холбогдогч нарт шийдвэрлэсэн тогтоол, /шийтгэвэрийн хуудас гэх мэт/ хувийг хүргүүлэх	60	100	6000
	Зөрчлийн үр дагавар арилгах арга хэмжээ авна.	1920	10	19200
	Шүүх худалдаанд оролцох	120	5	600
Нийт шаардлагатай хугацаа /минут/				906,200

Шаардлагатай хүний нөөц:  $906,200 : 60 \text{ минут} = 15103.3 \text{ цаг}$ ,  $15103.3 : 8 \text{ цаг} = 1887.9 \text{ ажлын өдөр}$ ,  $298.12 : 220 \text{ ажлын өдөр} = 8.58 \text{ хүн}$

Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн хороонд нэмэгдэж байгаа чиг үүрэгт шаардлагатай хүний нөөцийг нэгтгэсэн тооцоо:

Хүснэгт №6

№	Хэрэгжүүлэх чиг үүрэг	Шаардлагатай хүний нөөц
1	Аж ахуй эрхлэгч бусад аж ахуй эрхлэгчтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, бусад аж ахуй эрхлэгчийг худалдан авах зөвшөөрсөн эсхүл татгалзсан дүгнэлт гаргаж өгөх /Хуулийн төслийн 8 дугаар зүйл/	3.99

2	Өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах талаар баримтлах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, баримтлах бодлогыг тодорхойлох /Хуулийн төслийн 14.1,15 дугаар зүйл/	4.62
3	Захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаа явуулсан эсэхийг шалгаж, ирүүлсэн өргөдөл гомдлыг хянах /Хуулийн 13 дугаар зүйл/	0.69
4	Төрийн бусад байгууллагаас хэрэгжүүлж буй салбарын бодлого, үйл ажиллагаанд өрсөлдөөний бодлогыг тусгах санал зөвлөмж боловсруулж хүргүүлэх /Хуулийн 15 дугаар зүйл/	1.58
6	Зөрчлийн хэрэг бүртгэлт, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хорооны улсын байцаагч хэрэгжүүлэх	8.58
<b>Нийт</b>		<b>19.46</b>

### 1.3 Гаргах зардлыг урьдчилан тооцоолох

#### Хүний нөөцийн зардал:

ШӨХТГ-ын нийт төсөв 2018 оны байдлаар 953.1 сая төгрөг байгаагаас 698.7 сая төгрөг нь бараа, үйлчилгээний зардал байгаа бөгөөд Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолд заасны дагуу орон тоо 36 байна. Хуулийн төслөөр нэмэгдэж буй орон тооны бүтцийг дор харуулая.

#### Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороонд /төв/:

Хорооны бүтэц	Орон тооны хязгаар
Ажлын албаны дарга	1
Улсын ахлах байцаагч	4
Улсын байцаагч	10
Мэргэжилтэн	4
<b>НИЙТ</b>	<b>19</b>

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороо нийт 19 албан хаагч ажиллах тооцоо гаргасан. Төрийн захиргааны алба хаагчийн цалингийн зэрэглэл ТЗ 10-6 зэргээр цалинждаг. "Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ТЗ-7 зэрэглэлээр дундаж цалингийн хэмжээг тооцож гаргалаа.

Хүснэгт №7

Албан тушаалын зэрэглэл	1	2	3	4	5	Сарын дундаж цалин /Төгрөг/
ТЗ-7	591,218	627,465	663,720	698,795	733,863	663,012

/мянган төгрөгөөр/

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	2016 гүйцэтгэл	2017 гүйцэтгэл	2018 төлөвлөгөө
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>			
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	454,527.4	458,874.1	443,151.1
Ажил олгогчоос төлөх НДШ	46,505.2	49,354.2	53,215.0

Үндсэн цалингаас гадна нийгмийн даатгал, хоол унааны нэмэгдэл, ажилласан жилийн нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдэл, шагнал урамшуулал, бусад зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай.

Эдгээр зардлыг тодорхой тооцох боломжгүй тул дээрх 2016-2018 оны цалин хөлсний зардлын тоо мэдээ дээр тулгуурлан хоол унааны зардал 15%, нэмэгдэл, урамшил 20%, бусад холбогдох зардал 15%-иар тооцлоо.

Нэг албан хаагчийн сарын дундаж цалингийн зардал:

Хүснэгт №8

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Хэмжээ /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	663,012		663,012
Хоол унааны нэмэгдэл	663,012	15%	99,451
Нэмэгдэл, урамшил	663,012	20%	132,602
Бусад холбогдох зардал	663,012	10%	66,301
Нийт			895,131

Төрийн захиргааны 1 албан хаагчийн дундаж цалин 895,131 төгрөг болж байна. Үүнд албан хаагчийн нийгмийн даатгалын зардал, хүн амын орлогын албан татварын зардал багтсан болно. Ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл  $895,131 \times 12\% = 107,415$  төгрөгийн тооцоо үүсч байна.

#### Материаллаг зардал:

Материаллаг зардалд тухайн үүргийг гүйцэтгэж буй нэг албан хаагчийг ажиллах нөхцөлөөр хангахад зарцуулж буй зардлыг ойлгоно. ШӨХТГ-ын 2016-2018 оны урсгал үйл ажиллагааны зардалд тулгуурлан тооцов.

Нэг албан хаагчид гарах жилийн дундаж материаллаг зардал:

Хүснэгт №9

Зардлын нэр	Зардлын төрөл	Хэмжээ /төгрөг/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	161,000
	Ном хэвлэл авах зардал	42,500
	Хяналт шалгалтаар явах шатахууны зардал	72,800
	Шуудан холбоо	325,500
	Бага үнэтэй түргэн элэгдэх зардал	87,950
Барилга байгууламж, ашиглалтын зардал	Байрны түрээс, ашиглалтын зардал <sup>6</sup> /бүгд/	2,408,000
	Урсгал засвар	182,800
Элэгдэл хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	160,000
	Тавилга эд хогшил	80,000
	Нийт	3,520,550

<sup>6</sup> ШӨХТГ өөрийн ажлын байр /оффис/ байхгүй, Засгийн газрын 11 дүгээр байрны 9,10 дугаар давхар болон 1 давхарын хэрэглэгчийн төвийг түрээсийн гэрээгээр ашигладаг болно. /ашиглалт, цэвэрлэгээ, үйлчилгээ бүгд хамаарна./

### Бусад зардал:

Бусад зардалд төрийн байгууллагаас тухайн ажил үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дагалдан гарах зардлыг авч үзнэ. Үүнд:

Хүснэгт №10

№	Зардлын төрөл	Хэмжээ /төгрөг/
1	Техник тоног төхөөрөмж <sup>7</sup> /Компьютер, принтер, канон гэх мэт/ Нийт 19 хүн: 3,527,900*19= мян,төг/	67,030,100
2	Тавилга эд хогшил /Ширээ, сандал, шүүгээ гэх мэт/	37,767,421
	Нийт	104,797,521

Бусад зардлаас гадна албан үүргээ гүйцэтгэхэд шаардах хөрөнгийн зардал **104,797,521** төгрөг /Зуун дөрвөн сая долоон зуун ерин долоон мянга таван зуун хорин нэгэн төгрөг/ болно.

### 1.4 Зардлыг нэгтгэн тооцох

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороонд үүсэх нийт зардлын хэмжээ:

Хүснэгт №11

№	Зардлын төрөл	Зардлын хэмжээ	Хугацаа	Хүний нөөцийн хэрэгцээ	Нийт зардал
1	Хүний нөөцийн зардал /Цалин/	895,131	12 сар	19	204,089,868
2	Хүний нөөцийн зардал /Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл/	107,415	12 сар	19	24,490,620
3	Материаллаг зардал	3,520,550	1 жил	19	66,890,450
4	Бусад зардал				67,800,000
	Нийт				363,270,938

Нийт  $363,270,938 + 104,797,521 = 468,068,459$  төгрөг /Дөрвөн зуун жаран найман сая жаран найман мянга дөрвөн зуун тавин есөн төгрөг/ жилд дунджаар шаардлагатай болохыг тооцоолов.

Гэхдээ бусад зардалд тусгасан тоног төхөөрөмж, тавилга эд зүйлийн **104,797,521** төгрөгийн зардал нь зөвхөн нэг удаа буюу эхний жилд зарцуулагдах зардал болно.

### 1.5 Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Өрсөлдөөний тухай хуулийн төслөөр Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн хороонд 19 хүний орон тоо шаардлагатай тооцоо гарсан болно. Хэдийгээр орон тоо нэмэгдэж байгаа боловч хуулийн төслөөр иргэн болон хуулийн этгээдэд зардал үүсэхгүй. Харин улсын төсөвт үүсч байгаа зардал нь үр нөлөө, үр өгөөжөөсөө илүүгүй байх харьцааг нягтлах нь зүйтэй.

<sup>7</sup> Шинээр нэмэгдэж буй орон тоогоор нэмж авах шаардлагатай.

# ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ОЛОН НИЙТЭЭС САНАЛ АВАХААР ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ТАЛААР

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын [afccp.gov.mn](http://afccp.gov.mn) цахим хуудсанд Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасны дагуу Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, түүний үзэл баримтлал хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судласан судалгаа, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын тайлан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тайланг тус тус 2018 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр олон нийтээс санал авахаар байршуулсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т заасны дагуу санал авч дуусах хугацааг 2018 оны 9 дүгээр сарын 26-ний өдөр байхаар тооцсон боловч энэ хугацаанд иргэдээс нэг ч санал ирүүлээгүй тул хугацааг дахин 1 сараар сунгаж 10 дугаар сарын 2-ны өдөр санал авах ажлыг зогсооход мөн нэг ч санал ирүүлээгүй болно.



Нүүр хуудас Бидний тухай Үйл ажиллагаа Мэдээ мэдээлэл Хяналт шинжилгээ Хууль эрхзүй Ил тод байдал Холбоо барих

## Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авч байна.

2018-09-11



Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд олон нийтийн саналыг хүлээн авч байна.

Та хуулийн төсөлтэй холбоотой саналаа [parantseteg@afccp.gov.mn](mailto:parantseteg@afccp.gov.mn) цахим хаягаар болон бичгээр Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт хандан ирүүлнэ үү

Лавлах утас: 51-263778

Санал авах хугацаа: 9-р сарын 26 хүртэл


Доорх холбоосоор татаж авна уу

1. Өрсөлдөөний тухай хууль- Шинэчилсэн найруулга
2. Үзэл баримтлал
3. Өрсөлдөөний тухай хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайлан
4. Тандалт судалганы тайлан
5. Үр нөлөөг үнэлэх ажлын тайлан

Зохихуулийн газрын төлөөлөгчид Монгол Улсын өрсөлдөөнийг зохицуулах эрх зүйн орчинтой танилцав



Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр-ийн хэрэгжилтийг зохион байгуулах хяналт тавих зөвлөлийн



**“ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ”-Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН САНАЛ**

**Хугацаа:** 2017 оны 6-р сарын 06-ны өдөр 09.00-15.00 цаг  
**Байрлал:** “Чингис” зочид буудал “Өргөө” хурлын танхим

Д/д	Санал гаргасан газар	Саналын утга	Хуулийн төсөлд тусгасан эсэх	Тайлбар
1	“Энержи ресурс” ХХК-ийн хуульч Т.Энхжаргал	Бүх аж ахуй нэгжүүд нэгдэн нийлэхдээ саналаа өгдөг бол амьдралаас хол тасарч байгаа явдал юм. Үүнийг харах Хүсэлт шийдвэрлэх хугацаа 30 хоног байгаа нь маш урт хугацаа байна. Ажлын 10 хоног байх зохицуулалт оруулах.	Тусгасан	
2	МУИС-ийн ЭЗС-ийн багш Док/Ph.D/ Х.Цэвэлмаа	Хуулийн төслийн 12.1.4-т заасан үйлдлийг өрсөлдөөнд харшилна гэсэн нь праллель импортыг хориглохоор байна. - Нэгдэн нийлэх, хуваан тусгаарлахыг нэг үгээр хэрэглэх	Тусгаагүй	Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Өрсөлдөөний тухай хуулийн 8.2-т “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар өргөдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянаж зөвшөөрсөн, эсхүл татгалзсан дүгнэлт гаргана. Энэ хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болох бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл гаргуулж болно.” гэж заасан байдаг. Дээрх зохицуулалтыг өөрчлөх талаар Өрсөлдөөний тухай хуулийг шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй болно. Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Өрсөлдөөний тухай хуулийн заалт хэвээр байгаа. Энэ заалт нь праллель импортыг хориглохгүй дэмжиж байгаа.
3	“Сод Монгол групп” ХХК Н.Ганболд	- Хорооны гишүүдийг томилохоор санал өгөх эрх нь төрийн байгууллагаас санал болгосноор томилж байна. Аж ахуй эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах төлөөлөл харагдахгүй байна. МУХАУТ-ээс дор	Тусгаагүй	Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Өрсөлдөөний тухай хууль дахь нэршил хэвээр байгаа. Олон улсад хэрэглэгддэг нэршил. 1. ШӨХТГ-ын хуралдаан 2012-2018 оны хооронд буй 6 жилийн хугацаанд нийт 28 удаа хуралдахад Төрийн бус байгууллагын төлөөлөл болох Орон тооны бус гишүүн, МҮЭХ-ны ерөнхийлөгч хуралдаанд 1 удаа оролцож 27 удаа оролцоогүй тасалсан.

	<p>хаяж 1 гишүүнийг томилдог байх саналыг нэмж өгөх.</p> <p>-Хяналт шалгалтыг олон журмаар зохицуулж байгаа нь өөрөө маргаан үүсгэдэг. Хуулийн төслийн 27 дугаар зүйлд энэ асуудлыг тодорхой оруулж өгөх.</p>		<p>2. Мөн өрсөлдөөний харилцаа түүний зохицуулалт нь төрийн бодлоготой уялдаатай явагддаг тул хорооны Орон тооны бус гишүүнд Төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах нь зохимжтой бус гэж үзэн төрийн байгууллагын төлөөлөл оруулахаар хуулийн төсөлд тусгасан болно.</p> <p>Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа болон төрийн хяналт шалгалтын ажиллагааг зааглан тус тусд нь зохицуулах нь зүйтэй гэж үзсэн. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зөрчил шалган шийдвэрлэх харилцааг зохицуулсан.</p>
<p>4 НЗХАШШ-ийн шүүгч О.Оюунгэрэл</p>	<p>Хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн саналын 3-р бүлэгт тусгагдсан байгууллагын эрх зүйн байдал нь хороо болж өөрчлөгдөж байгааг нь дэмжиж байна. Бусад улс оронд ч Хороо гэдгээр үйл ажиллагаагаа явуулаад хэвшсэн байдаг. Гэхдээ хуулийн төсөлд тусгасан хорооны эрх зүйн чадамж өмнөхөөсөө төдийлөн дээрдээгүй, харин ч хорооны бүтэц, зохион байгуулалтын статусаар нь авч үзвэл маш сул зохион байгуулалттай болсон харагдаж байна. Хорооны үйл ажиллагааг явуулах, өрсөлдөөний бодлогоо тодорхойлох, удирдлага, хүний нөөцийн чадавхи туйлын хангалтгүй тусгагдсан байна. Хорооны гишүүд, улсын байцаагч нарыг томилох шалгуурыг хуулийн 17.4, 17.5-д заасан байна. Миний хувьд энэ шалгуурыг 2-3 дахин нэмэх, тэдний эдийн засаг, хууль эрх зүйн мэдлэг, туршлага, мэргэжлийн ур чадварыг тодорхой зааж өгч байж хуульчлах ёстой юм болов уу гэж бодож байна.</p> <p>Ингэснээр тухайн байгууллага</p>	<p>Тусгаагүй</p> <p>Тусгасан</p>	

	<p>өрсөлдөөний асуудлыг мэргэжлийн түвшинд зохицуулах, зах зээлийн өөрчлөлт шинэчлэлтийг урьдчилан харах, өрсөлдөөнийг дэмжин хөгжүүлэх оновчтой шийдвэр гаргах, бусдаас хараат бусаар бие дааж ажиллах эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзэж байна.</p>		
	<p>Төслийн 10.2-т шүүхийн хийх ажил, шийдвэрийг заасан нь шүүхийн эрх мэдэлд халдсан байна.</p>	Тусгасан	
	<p>19.1.6, 20.3-т Захиргааны хэрэг үүсгэ гэсэн шийдвэрийг Хороо гаргахаар тусгаснаа эргэж харахыг хүсэж байна.</p>	Тусгасан	
5	<p>"Хөрөнгийн бирж" Б.Батбаяр</p>	Тусгаагүй	<p>Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуульд заасан аж ахуй эрхлэгчдийн нэгдэх, нийлэх, хувьцаа худалдан авах харилцааны зохицуулалтыг илүү боловсронгуй, хэрэгжихүйц байхаар, мөн олон улсын жишигт нийцүүлэн тусгасан. Ингэхдээ аж ахуй эрхлэгчдийн нэгдэх, нийлэх, хувьцаа худалдан авах харилцаанд хийх өрсөлдөөний зохицуулалтад хамаарах аж ахуй эрхлэгчдийн талаар босго борлуулалтын орлогын хэмжээг Засгийн газраас тогтоодог байхаар хуулийн төсөлд тусгасан. Мөн зарим зохицуулалтын хүрээг багасгаж өгсөн нь аж ахуй эрхлэгчдэд таатай нөхцөлийг бий болгоно.</p>
6	<p>"Скайтел" ХХК-ийн Хүний нөөц, хуулийн албаны захирал Д.Жамбалсүрэн</p>	Тусгаагүй	<p>Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний хуулиар зах зээлд давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг урьдчилан судалж тогтоодог байхаар зааж зохицуулснаас үүдэлтэй бодит байдал дээр хуулийн хийдэл ихээхэн гарч байгаа. Өөрөөр хэлбэл бодит байдал дээр давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг давамгай байдалтайгаар урьдчилан тогтоож нийтэд зарлаагүй л бол уг аж ахуй эрхлэгч хууль зөрчсөн байсан ч шийтгэл хүлээхгүй байх тохиолдол гарч байна. Аж ахуй эрхлэгч хуульд заасан тодорхой зөрчлийг гаргасан бол уг этгээдийг зөрчил үйлдэх үедээ давамгай байдалтай байсан</p>



				эсэхийг судалж тогтоон хуулийн үйлчлэлд хамаарах эсэхийг шийдвэрлэдэг болно. Энэ нь олон улсад мөрдөгддөг зохицуулалтын нийтлэг жишиг төдийгүй бодит байдалд үр дүнтэй хэрэгжих бүрэн боломжтой.
7	"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК Г. Ууганбаяр	Хяналт шалгалтыг 1 жилийн хугацаанд хийх асуудлыг харах Энгийн хувьцааны 20, Давуу эрхийн хувьцааны 10 хувийг худалдан авах аж ахуй эрхлэгчид танай байгууллагаас зөвшөөрөл авна гэснийг хүчингүй болгох гэж байгаа нь 1 ширхэг хувьцаа худалдан авсан ч байсан танайд мэдэгдэж зөвшөөрөл авахаар ойлгогдож байна. Ингэвэл танай байгууллага хувьцааны бүртгэл хийдэг байгууллага болох мэт харагдаж байна.	Туссан	
8	"УБТЗ" ХНН О. Баясгалан	Хяналт шалгалтын хугацаа 1 жил 6 сар гэсэн нь хэтэрхий урт байна. Хуулийн төслийн 23.3-т улсын байцаагч өөрийн хийсэн шалгалтын дүнгээ хариуцна гээд дахиад 23.4-т Хорооны хурлаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг хорооны дарга нь шийдвэрлэх гэснийг харах	Туссан	
10	"Монголын цахилгаан холбоо" ХК Д.Нямаа	Үнэ тарифтай холбоотой хэт өндөр үнэ тогтоох гэсэн хуулийн 7.1.2 дахь заалтыг хассан байна. Давуу эрхтэй, давамгай байдалтай аж ахуйн нэгжүүдийг улам өөхшүүлж, өөрсдөө үнээ тогтоох боломжийг нээж өгч байна. Энэ заалтыг оруулах.	Тусгаагүй	Хэт өндөр үнийн зохицуулалт нь өрсөлдөөний хуулиар зохицуулах харилцаа биш юм. Олон улсад ч ийм жишиг, туршлага байхгүй болно.
11	"Монголын банкны холбоо" Ч. Намжилмаа	Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуулийн 8.1 дэх заалтыг хэвээр байлгах	Тусгаагүй	Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуульд заасан аж ахуй эрхлэгчдийн нэгдэх, нийлэх, хувьцаа худалдан авах харилцааны зохицуулалтыг илүү боловсронгуй, хэрэгжихүйц байхаар, мөн олон улсын жишигт нийцүүлэн тусгасан. Ингэхдээ аж ахуй эрхлэгчдийн нэгдэх, нийлэх, хувьцаа худалдан авах

				<p>харилцаанд хийх өрсөлдөөний зохицуулалтад хамаарах аж ахуй эрхлэгчдийн талаар босго борлуулалтын орлогын хэмжээг Засгийн газраас тогтоодог байхаар хуулийн төсөлд тусгасан. Мөн зарим зохицуулалтын хүрээг багасгаж өгсөн нь аж ахуй эрхлэгчдэд таатай нөхцөлийг бий болгоно.</p>
		<p>Байцаагчийн эрх хязгаарлагдмал, эцсийн шийдвэрийг хорооны дарга гаргахаар байна үүнийг өөрчлөх</p>	Тусгасан	
	<p>Хяналт шалгалтын хугацаа 1 жил байна, картельтэй холбоотой хяналт шалгалтыг 1 жил байхаар зохицуулах.</p>	Тусгаагүй	<p>Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Өрсөлдөөний тухай хуулийн 23.1-т "Улсын байцаагч хянан шалгах ажиллагааг 60 хоногийн дотор явуулна.", 23.2-т "Энэ хуулийн 23.1-д заасан хугацаанд зөрчлийг хянан шалгах ажиллагааг дуусгах боломжгүй бол уг хугацааг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга 30 хүртэл хоногоор сунгаж болно" гэж заасан.</p> <p>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.8 дугаар зүйлийн 6.8.1-т "Эрх бүхий албан тушаалтан 14 хүртэл хоногийн дотор зөрчлийн хэрэг бүртгэлт явуулна." гэж, 6.8.2-т "Зөрчил шалгах нэмэлт ажиллагаа явуулж нотлох баримт цуглуулах шаардлагатай бол зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан 14 хүртэл, прокурор 30 хүртэл хоногоор сунгаж болно." гэж заасантай нийцүүлж хяналт шалгалтын хугацааг хуулийн төсөлд хэвээр тусгасан</p>	
<p>12 "УБЦТС" ТӨХК Н.Төрболд</p>	<p>Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-дахь заалтыг нэмэх</p>	Тусгаагүй	<p>Зохихуулах байгууллагаас гаргаж буй бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ тарифын зохицуулалт нь одоогийн байдлаар зөвхөн үнэ тариф нэмэх тухай шийдвэрүүд байдаг.</p> <p>Зохихуулах байгууллага шийдвэр гаргахдаа зөвхөн салбарын үр ашиг, салбарын асуудал талаас шийддэг. Харин өрсөлдөөний байгууллага 1993-2015 оны хооронд мөрдөж байсан Өрсөлдөөний тухай хуулиар монополь салбарын үнийн зохицуулалтыг хянахдаа бусад салбар зах зээлийн өрсөлдөөнд нөлөөлөх нөлөөлөл, хэрэглэгчид үзүүлэх нөлөөлөл</p>	

				<p>зэрэг олон талаас харж асуудлыг шийддэг байсан. Гэтэл 2015 онд Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулж салбарын зохицуулах байгууллагуудад энэ эрхийг шилжүүлэн өөрчлөлт оруулахдаа өрсөлдөөний байгууллагаас санал аваагүй байдаг. Аливаа монополь зах зээл гэдэг нь цор ганц аж ахуйн нэгж ямар ч өрсөлдөөнгүй үйл ажиллагаа явуулан, мөн өөрийн зах зээлийн үйл ажиллагаанаас хамааралтай бусад зах зээлийн өрсөлдөөнд зөвхөн өөрийн ашиг сонирхолын үүднээс хүчтэй нөлөөлөн өрсөлдөөнийг хязгаарлах бүрэн боломжтой байдаг. Иймд энэ асуудлын хяналт зохицуулалт нь өрсөлдөөний байгууллагын эрхлэх үйл ажиллагаанаас ангид байх боломжгүй юм.</p>
--	--	--	--	--

**“ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН САНАЛ**

**Хугацаа:** 2017 оны 11-р сарын 09-ний өдөр 09.00-15.00 цаг  
**Байрлал:** Төрийн ордон “Б” танхим

Д/А	Санал гаргасан газар	Саналын утга	Хуулийн төсөлд тусгасан эсэх	Тайлбар
1	<p>“УБТЗ” ХНН-ийн зөвлөх Т.Очирхүү</p>	<p>ШӨХТГ-ын рейтинг, статусыг өргөөд Засгийн газрын байгууллагуудтай бодлогын төвшинд ажиллах, шаардлага тавих нь зөв юм гэж үзэж байна. Үүнд би одоогийн удирдлага, хамт олонд баяр хүргэе. Нэгдэж нийлэх бүртгэлийн процесс, үйл ажиллагаанд Засгийн газар юм уу Их хурлаас байгуулсан нэг байгууллага бүртгэлд нь оролцож, зөвшөөрөл өгдөг, бүртгэл нь удаан хугацаанд хүнд суртал, цаг хугацааны механизм болох нь зохистой биш үүнийг анхаарах.</p>	Тусгаагүй	<p>Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуульд заасан энэ төрлийн зохицуулалтад зөвхөн давамгай байдалтай аж ахуй эрхлэгч хамаарахаар байгаа нь нэгдүгээрт давамгай байдалтайгаар урьдчилж тогтоогдоогүй этгээд уг зохицуулалтад хамаарахгүй болох, хоёрдугаарт, давамгай биш хэд хэдэн этгээд нэгдэх, нийлэх замаар зах зээлд хэт төвлөрөл үүсгэж өрсөлдөөнийг хязгаарлах боломжийг олгож байгаа.</p>

2	Зөвлөх Д.Байлийхүү:	Хуулинд бичигдэж байгаа үгнүүд тодорхой, хоёрдмол утгагүй байх хэрэгтэй. Байгууллагын хараат бус бие даасан байдал байна. анх 1993 онд батлагдахад хуулийн гол үзэл баримтлал бол байгууллага хараат бус, бие даасан байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч байсан, гэхдээ энэ үзэл баримтлал бүрэн тусгагдаж батлагдаагүй. Харин одоо байгууллага хараат бус байх нөхцөл бүрдэх гэж байна. Иймд байгууллагын статусыг тодорхой тусгаж өгөөрэй. Байгууллагын дарга байнга солигддог гэж байна. Тэгэхээр байгууллагын дарга, орон тооны гишүүдийн тогтвортой ажиллах нөхцөлд анхаарах хэрэгтэй.	Тусгасан	
		Орон нутагт өрсөлдөөний асуудлыг зохицуулах салбар бүтэц шаардлагатай байна. Үүнийг хуулинд тусгах	Тусгасан	
		Хуулинд мөн чанараа хангаагүй заалт туссан байдаг. Энэ бол 2010 оны хуулинд байсан. Тэр заалт хасагдсанд баяртай байна. Хэрвээ бид хэт өндөр үнийг зохицуулаад ирвэл юу болох вэ.	Тусгасан	
3	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Э.Зоригтбаатар	Өрсөлдөөний зөрчлийн хэрэг дээр прокурор ямар эрх эдэлж, ямар оролцоотой байх юм бэ. Өрсөлдөөн өөрөө онцлог салбар. Жишээ нь улсын байцаагчийн зөрчлийн дүгнэлтийг үндэслэн хороо шийдвэр гаргана гэсэн байна. Тэгвэл хорооны шийдвэрийг прокурорт хянуулах уу. Үүнийг тодорхой болгох. Өрсөлдөөний хэрэг зөрчлийг шийдвэрлэх тусдаа журам байх ёстой гэж үзэж байвал Зөрчлийн хууль болон бусад холбогдох хуулинд заасан ямар журмаар нь явахыг хуулиндаа тодорхой зааж өгөх Хорооны шийдвэр гаргах процессыг хуулиндаа зааж өгөх, хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамгийн гол зүйл бол байгууллагын даргыг улс төрөөс ангид	Тусгасан	
			Тусгасан	

		байлгахар, хараат бус байдлыг хангах нь хамгийн чухал зүйл гэж бодож байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлд зөрчлийг шалгах зөвшөөрлийг хорооны даргаас авна, хугацаа 6 сар гэсэн байна. Прокурор хугацааг сунгахгүй бол яах вэ? 6 сарын хугацаанд нь зөрчил нь илрээгүй, гэтэл прокурор хугацааг нь сунгаагүй тохиолдолд татгалзах нөхцөлийг хуулинд тодорхой тусгах.	Тусгасан	
4	Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын хуулийн хэлтсийн дарга Д.Ёндонжамц, Орон нутгийн төлөөлөл	Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.4.4-т орон нутагт улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана гэж заасан байна. Үүнийг хуулинд тодорхой тусгах. 7. Хуулийн төслийн 19.2-т "бүрэн эрхийн хугацаа нь хугацаанаас нь өмнө дуусгавар болсон дарга, гишүүний оронд томилогдсон этгээдийн бүрэн эрхийн хугацаа ийнхүү томилогдсон өдрөөс нь эхэлнэ." гэж, мөн хуулийн төслийн 20.1-д "Хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа зургаан жил ..." гэж заасан нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 <sup>3</sup> дугаар зүйлийн 2-т "... Агентлагийн даргын бүрэн эрхийн хугацаа хуулиар тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон бол дараагийн томилогдсон этгээдийн бүрэн эрхийн хугацаа өмнөх даргын бүрэн эрхийн хугацааны үлдсэн хугацаатай адил байна" гэж заасантай зөрчилдөж байна.	Тусгасан	
5	Олон улс судлалын дээд сургууль Д.Цэенсайхан:	Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан засгийн газрын гишүүн гэж ямар субъектыг хэлээд байна вэ? Үүнийг тодорхой оруулах	Тусгасан	
6	МУИС-ын Хууль их сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн	Миний хувьд энэхүү хуулийн төсөл дээр анхнаасаа саналаа өгөөд явж байгаа. Холбогдох саналаа өгсөн.		

	эрхлэгч, Доктор (LL.D), Дэд профессор Б.Амарсанаа			
7	МУИС-ын 5-р курсийн оюутан Б.Хулан	Хуулийн төслийн 24.2.1-д тухайн байцаагч нь зөрчил болон хяналт шалгалт хийх саналаа хорооны даргад тавьж шийдвэрлүүлэх гэсэн заалт байна. Энэ заалтын хувьд тухайн байгууллага нь иргэдээс мэдээлэл гомдол ямар нэгэн байдлаар зөрчил хянан шалгах ажил эхлэх үндсэн нөхцөл нь бүрдсэн байхад дахиад хорооны даргадаа санал оруулаад энэ дээр хяналт шалгалт хийлгэх эсэхээ хорооны даргаар шийдвэрлүүлэх үү? Хорооны дарга нь хэдэн хоногийн хугацаанд яаж шийдвэрлэх талаар процессын зохицуулалт оруулах.	Тусгасан	
8	Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбооны Гүйцэтгэх захирал Х.Ганбаатар	Хуулийн төслийн 15.1.14-д хорооноос аж ахуй эрхлэгчийг өрсөлдөөний тухай хууль тогтоомж зөрчсөн талаар шийдвэр гаргана гэсэн байна. Ямар шийдвэр гаргахыг тодорхой оруулах Хорооны бүрэлдэхүүнд хувийн хэвшлийн төлөөлөл, хэрэглэгчийн асуудал хариуцсан нэг төлөөлөл оруулах саналтай байна. Төрөөс томилогдсон их хурлын төлөөлөл ороод байхаар шударга өрсөлдөөний асуудал шударга шийдэгдэнэ гэж найдахад хэцүүхэн болж байна.	Тусгасан	1. ШӨХТГ-ын хуралдаан 2012-2018 оны хооронд буй 6 жилийн хугацаанд нийт 28 удаа хуралдахад Төрийн бус байгууллагын төлөөлөл болох Орон тооны бус гишүүн, МҮЭХ-ны ерөнхийлөгч хуралдаанд 1 удаа оролцож 27 удаа оролцоогүй тасалсан. 2. Мөн өрсөлдөөний харилцаа түүний зохицуулалт нь төрийн бодлоготой уялдаатай явагддаг тул хорооны Орон тооны бус гишүүнд Төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах нь зохимжтой бус гэж үзэн төрийн байгууллагын төлөөлөл оруулахаар хуулийн төсөлд тусгасан болно.
9	Дархан-Уул аймгийн ЗДТГ-	Хуулийн төслийн 24.2.1-д хяналт шалгалт хийхэд хорооны даргад саналаа тавьж	Тусгасан	

10	<p>ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга Л.Алтанчимэг; Санхүүгийн зохицуулах хорооны Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн М.Ням-Очир</p>	<p>шийдвэрлүүлнэ гэж заасан байгаа. Хяналт шалгалт хийх саналаа хорооны даргад тавихад бас хугацаа алдах магадлалтай байж болохоор харагдаж байна.</p>		
		<p>Зөрчлийн тухай хууль болон, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан улсын байцаагч буюу эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулаад шийтгэлийн хуудас буюу шийтгэврийг эс зөвшөөрвөл оролцогч захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шүүхэд гомдол гарган шийдвэрлэх процесс ерөнхийдөө явагдаж байгаа. Үндсэндээ зөрчлийг хянан шалгаад эрх бүхий албан тушаалтан буюу улсын байцаагч л зөрчлийг хянан шийдвэрлэх тухай хуулиараа зөрчлийг шийднэ. Хуулийн төслөөр ШӨХТГ хорооны статустай болоод үндсэндээ хорооны дарга нь шийдвэрлэдэг болох юм байна. Хороо тогтоол гаргаж шийдвэрлэнэ. Шийдвэр гаргахдаа хорооны хуралдаанаар шийднэ. Хорооны хуралдаан сард 1-с доошгүй хуралдана. Иймд зөрчил шалган шийдвэрлэхтэй холбоотойгоор хугацааны асуудал дээр анхаарах.</p>	Тусгасан	

ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД  
ЯАМД, ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДААС САНАЛ АВСАН ТАЛААР

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 13 яам, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас санал авахаар хүсэлт хүргүүлсэн боловч 13 яам холбогдох санал ирүүлснийг нэгтгэн хуулийн төсөлд тусгасан.

Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас санал ирүүлээгүй болно.



**ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН  
ТӨСЛИЙГ УИХ-ЫН ЧУУЛГАНААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ  
АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН НЭРС**

№	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар
1	Б.Лхагва	ШӨХТГ-ын дарга	88889818
2	С.Янжинсүрэн	Шадар сайдын Ахлах зөвлөх	99119376
3	С.Цогтгэрэл	ШӨХТГ-ын Орон тооны гишүүн	88882345
4	Т.Батцэцэг	ШӨХТГ-ын Өрсөлдөөний бодлого зохицуулалтын газрын дарга	99282398
5	Б.Наранцэцэг	ШӨХТГ-ын ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн	91915542

----000---